



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 12 дугаар сарын 14-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-24
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9-73
<i>1.Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	25-65
<i>2.Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцид 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	65-67
<i>3.Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	67-112

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 14-ний өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 44 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан, Г.Мөнхцэцэг, Г.Тэмүүлэн, Ч.Хүрэлбаатар, О.Цогтгэрэл, Ц.Цэрэнпунцаг;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Ё.Баатарбилэг, С.Батболд, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Сэргэлэн, Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд, Д.Цогтбаатар;

Тасалсан: Ш.Адъяа, Ц.Анандбазар, Д.Батлут, Ж.Бат-Эрдэнэ, Х.Ганхуяг, Б.Жавхлан, Б.Жаргалмаа;

Хоцорсон: Э.Бат-Амгалан-1 цаг 09 минут, Х.Булгантуяа-1 цаг 21 минут, Д.Ганбат-16 минут, Т.Доржханд-1 цаг 21 минут, Б.Саранчимэг-2 цаг 30 минут, Ж.Сүхбаатар-2 цаг 54 минут, Ч.Ундрал-09 минут, Н.Учрал-20 минут, Ж.Чинбүрэн-02 минут, Т.Энхтүвшин-23 минут, Ж.Эрдэнэбат-28 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Х.Болорчулуун, Д.Өнөрболор нараас албан бичиг ирүүлснийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Х.Болорчулуун, Д.Өнөрболор нар үг хэлэв.

Нэг.Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга Ц.Эрдэнэ-Очир, мөн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын ахлах шинжээч Л.Баянзул, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ,

Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 10 цаг 55 минутаас 12 цаг 13 минутад хуралдааныг даргалав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, С.Ганбаатар, Г.Дамдинням, Б.Баттөмөр, Ж.Батжаргал, Г.Ганболд, Б.Энх-Амгалан, Ц.Туваан, Д.Ганбат, Т.Энхтүвшин нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан, Зам, тээврийн хөгжлийн яамны Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга Ц.Эрдэнэ-Очир, мөн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын ахлах шинжээч Л.Баянзул, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Д.Ганбат, Ц.Идэрбат нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг 12 дугаар сарын 15-ны өдрийн 10.00 цагт явуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцид 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Далайн ашиглалт, усан замын тээврийн хэлтсийн дарга Д.Жавхлан, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Далайн захиргааны дарга Д.Отгонсүрэн, мөн захиргааны Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн О.Анужин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг 12 дугаар сарын 15-ны өдрийн 10.00 цагт явуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 06 минут үргэлжилж, 12 цаг 50 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 06 минутад эхлэв.

Гурав.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд, мөн газрын мэргэжилтэн Э.Баяртулга, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Нинж, Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Э.Цэрэнчунт, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал С.Өнөрсайхан, мөн төвийн Стратеги удирдлагын албаны дарга У.Эрхэмбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Ж.Чинбүрэн, Б.Бейсен, Ж.Батжаргал, С.Бямбацогт, Т.Энхтүвшин, С.Ганбаатар, Д.Ганбат, М.Оюунчимэг, Д.Өнөрболор, Ц.Мөнхцэцэг, Ц.Туваан нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд, мөн газрын мэргэжилтэн Э.Баяртулга, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Нинж, Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Э.Цэрэнчунт, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал С.Өнөрсайхан, мөн төвийн Стратеги удирдлагын албаны дарга У.Эрхэмбаяр нар хариулж, тайлбар хийв.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, П.Анужин, Ж.Чинбүрэн, Б.Жаргалмаа, М.Оюунчимэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “хүчин зүйл, халдварт болон халдварт бус өвчнийг тандах, өвчин,

эмгэгээс урьдчилан сэргийлэх, хамгаалах” гэснийг “хүчин зүйлийг, тандах, судлах, үнэлэх, хариу арга хэмжээг авах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хууль,” гэсний дараа “Үндэсний аюулгүй байдлын тухай,” гэж, “Эрүүл ахуйн тухай хууль,” гэсний дараа “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай,” гэж нэмж, мөн хэсгийн “Боловсролын тухай” гэснийг “Боловсролын ерөнхий” гэж өөрчилж, 2.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 14
Бүгд: 40
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “нотолгоонд” гэсний өмнө “судалгааны үр дүн,” гэж нэмж, 3.1.11 дэх заалтын “өвчний шинж тэмдэг илрээгүй хүн амыг” гэснийг “хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан, өвчин эмгэгээс” гэж өөрчилж, 3.1.3, 3.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.3.“нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал” гэж хүний болон зоонозын халдварт өвчний дэгдэлт, шалтгаан тодорхойгүй өвчлөл, өвчлөлийн шинэ тохиолдол, хими, цацрагийн осол, хордлогод хүн ам өртсөн, эсхүл өртөх нөхцөл үүссэнийг;

3.1.4.“эрүүл мэндийг дэмжих” гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.19-д заасныг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 14
Бүгд: 40
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “чанар, тоон үзүүлэлт судалгааны аргаар” гэснийг, 3.1.13 дахь заалтын “арга барилд сургах” гэснийг, 3.1.8, 3.1.19, 3.1.21 дэх заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.17 дахь заалтын “эрүүл мэндийн их дээд сургуулийг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр төгссөн мэргэжилтнийг”

гэснийг “их, дээд сургууль, коллежийг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр төгссөн, тухайн мэргэжлээрээ энэ хуулийн 11.1.1-11.1.4-т заасан байгууллагад ажиллаж байгаа ажилтныг” гэж, 3.1.18 дахь заалтын “ажилтан” гэснийг “мэргэжилтэн” гэж, “энэ хуулийн 7.1.1-7.1.3-д заасан байгууллагад” гэснийг “их, дээд сургууль, коллежийг энэ хуулийн 3.1.15-д зааснаас бусад чиглэлээр төгсөж, энэ хуулийн 11.1.1-11.1.4-т заасан байгууллагад энэ хуулийн 5.2-5.9-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэн” гэж, мөн заалтын дугаарыг “3.1.16” гэж, 3.1.16 дахь заалтын “чиглэлээр ажилладаг бусад ажилтныг” гэснийг “бусад мэргэжилтнийг” гэж, мөн заалтын дугаарыг “3.1.17” гэж, 3.1.17 дахь заалтын дугаарыг “3.1.15” гэж, тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 15

Бүгд: 40

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн гарчгийн “Үйл ажиллагаанд баримтлах” гэснийг “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “нотолгоонд” гэснийг “судалгааны үр дүн, нотолгоонд” гэж тус тус өөрчилж, 4.1.1 дэх заалтын “, тэгш хүртээмжтэй, чанартай” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:

“4.1.8.чанар, үр ашигтай байх;

4.1.9.тэгш хүртээмжтэй байх;

4.1.10.жендэрийн тэгш байдлыг хангах гэсэн саналыг гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 16

Бүгд: 40

65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтын “гэр бүл төлөвлөлт,” гэснийг хасаж, 5.2.6 дахь заалтыг 5.7 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.7.Энэ хуулийн 5.1.6-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд хувь хүн, хосууд эрүүл мэнд, эдийн засаг, амьдралын байдалд тохируулан гэр бүл төлөвлөх, тэдний нөхөн үржихүйн эрхийг хамгаалах, мэдлэг олгох үйл ажиллагаа явуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 12

Бүгд: 40

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “сэтгэл зүйн эрүүл мэнд” гэснийг “сэтгэц-зан үйл” гэж өөрчилж, 5.2.5 дахь заалтыг 5.6 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.6.Энэ хуулийн 5.1.5-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

5.6.1.нийгэм болон хүрээлэн байгаа орчноос үүдэлтэй сэтгэц-зан үйлийн эмгэгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг тогтоох, тандалт, судалгаа хийх, урьдчилан сэргийлэх, хянах, бууруулах;

5.6.2.хүнийг амьдралын зөв хэв маягт сургах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 14

Бүгд: 40

65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын “хөрсний бохирдол, ус хангамж, ариун цэвэр, хог хаягдлаас” гэснийг “уур амьсгалын өөрчлөлт, ус хангамж, хог хаягдал, хөрсний бохирдлоос” гэж, мөн заалтын дугаарыг “5.3” гэж тус тус өөрчилж, 5.2.4 дэх заалтыг 5.5 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.5.Энэ хуулийн 5.1.4-т заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

5.5.1.хүнсний аюулгүй байдал, шим тэжээлийн зохистой байдал алдагдсанаас шалтгаалсан өвчлөл, хордлогоос урьдчилан сэргийлэх;

5.5.2.хүнсний аюулгүй байдал, шим тэжээлийн зохистой байдал алдагдсанаас шалтгаалсан өвчлөл, хордлогод нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тогтоох, тандалт, судалгаа хийх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 15

Бүгд: 40

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 5.2.1 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.2.Энэ хуулийн 5.1.1-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

5.2.1.халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тандан судлах, тодорхойлох, урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг иргэн, гэр бүл, байгууллага, хамт олонд тулгуурлан зохион байгуулах;

5.2.2.нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх.” гэсэн саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч санал хураалт явуулаагүй болно.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 16 цаг 15 минутаас хуралдааныг даргалав.

Л.Мөнхбаатар: 11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалтын “өвчлөл,” гэсний дараа “осол, гэмтэл,” гэж нэмж, мөн заалтын дугаарыг “5.4” гэж, 5.2.8 дахь заалтын дугаарыг “5.9” гэж, мөн заалтын “байгалийн гамшиг, нийтийг хамарсан ноцтой байдлын үед” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед” гэж, “бэлэн байдлыг хангах,” гэснийг “бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаа явуулна.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалтын “дэмжих,” гэсний дараа “хамгаалах” гэж нэмж, мөн заалтын “эрүүл мэндийн боловсрол олгох” гэснийг 5.10.3 дахь заалт болгон өөрчилж, 5.3.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмэх:

“5.11.Энэ хуулийн 5.10.3-т заасан чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх асуудлыг Монгол Улсын хөгжлийн бодлогод тусгана.

5.12.Энэ хуулийн 5.11-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах, эрх бүхий этгээдэд танилцуулахтай холбогдсон харилцааг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн гарчиг, 6.1-6.5, 6.10-6.12 дахь хэсгийг тус тус хасаж, 6.6 дахь хэсгийг 6 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл

6.1.Нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг хэлэлцэж, салбар дундын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах чиг үүрэг бүхий Нийгмийн эрүүл мэндийн орон тооны бус үндэсний зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ Ерөнхий сайдын дэргэд ажиллана.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөлийн шийдвэр нь дүгнэлт, зөвлөмж хэлбэртэй байх бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 16

Бүгд: 39

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсгийг 7 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

7.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.Нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сангийн ажиллах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;

7.1.2.нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах журмыг гамшгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19

Бүгд: 39

51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийг 8 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллагуудын чиг үүрэг

8.1.Төрийн захиргааны төв байгууллагууд нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1.1.хүн амын эрүүл мэндийг дэмжих, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бодлого, үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх;

8.1.2.энэ хуулийн 14.1.3-т заасан чиг үүрэг;

8.1.3.Зөвлөлийн гаргасан дүгнэлт, зөвлөмжийг бодлого, шийдвэртээ тусгаж, хэрэгжүүлэх.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан арга хэмжээний биелэлтийн тайланг жил бүрийн хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.8.3 дахь заалтын “нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед” гэсний өмнө “шуурхай удирдлагын нэгжтэй байх бөгөөд” гэж нэмж, мөн заалтын дугаарыг “12.1.7” гэж өөрчилж, 6.8 дахь хэсгийг 9 дүгээр зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.8.1-6.8.2 дахь заалтын дугаарыг “9.1.1-9.1.2” гэж, 6.8.4 дэх заалтын дугаарыг “9.1.3” гэж тус тус өөрчлөх:

“9 дүгээр зүйл. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

9.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар дараах чиг, үүргийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:

“9.1.4. нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдлын удирдлагын тогтолцоонд шилжин ажиллаж байгаа байгууллагыг арга зүйгээр хангаж ажиллах;

9.1.5. Энэ хуулийн 8.2-т заасан тайланг нэгтгэн Зөвлөлд жил бүрийн дөрөвдүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

19. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсгийг 10 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.13.1-6.13.4 дэх заалтын дугаарыг “10.1.1-10.1.4” гэж өөрчлөх:

“10 дугаар зүйл. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

10.1. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18

Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.13.2 дахь заалтын “иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар” гэснийг “шаардлагатай санхүүжилтийг эрх бүхий байгууллагаар” гэж, 6.13.3 дахь заалтын “нөхцөлийг бүрдүүлэх” гэснийг “нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх” гэж тус тус өөрчилж, 6.13.4 дэх заалтын “урьдчилан сэргийлэх” гэсний дараа “, эрүүл мэндийн боловсрол олгох” гэж, мөн заалтын “оролцуулах” гэсний дараа “, урамшуулах” гэж, мөн хэсэгт доор дурдсан агуулгатай заалт тус тус нэмэх:

“10.1.5.нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, эрүүл мэндийн боловсрол олгох асуудлаар эрүүл мэндийн байгууллага, ажилтныг дэмжиж ажиллах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д заасныг үндэслэн” гэснийг, “эрх зүйн байдал,” гэснийг тус тус хасаж, мөн хэсгийн дугаарыг “11.2” гэж өөрчлөх; гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийн “7.1.2, 7.1.3-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын” гэснийг “11.1.2-т заасан байгууллагын” гэж, “батална” гэснийг “баталж, удирдлагыг Эрүүл мэндийн тухай хуулийн 12.2-т заасны дагуу аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга томилж, чөлөөлнө” гэж тус тус өөрчилж, “дүрмийг” гэсний дараа “хүн амын төвлөрөл, газар нутгийн байршлыг харгалзан” гэж нэмж, мөн хэсгийн дугаарыг “11.3” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг 11.4 дэх хэсэг болгон, мөн хэсгийн “15.1.4, 15.1.7, 15.1.11-15.1.13-т” гэснийг “15.1.3, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.11, 15.1.12, 15.1.13-т” гэж, “нийгмийн эрүүл мэндийн” гэснийг “энэ хуулийн 11.1.3-т заасан” гэж тус тус өөрчилж, “Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан ажилтныг ажиллуулж болно.” гэснийг хасаж, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг 11.10 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.10.Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, боловсролын сургалтын байгууллагад нийгмийн эрүүл мэндийн нэгж, алба, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнийг ажиллуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“11.5.Энэ хуулийн 11.1.3-т заасан байгууллагын иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэргүүлэх чиглэл нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийг 11.6 дахь хэсэг болгон “ажилтныг ажиллуулж болно” гэснийг “мэргэжилтэн ажиллуулна” гэж, 8.9 дэх хэсгийг 11.7 дахь хэсэг болгон мөн хэсгийн “7.1.1-7.1.5-д” гэснийг “11.1.1-11.1.4-т” гэж, “хоол зүйчид нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлнэ” гэснийг “хоол зүйч нарыг мэргэжил, арга зүйгээр хангана” гэж тус тус өөрчилж, мөн хэсэгт доор дурдсан агуулгатай 11.8, 11.9 дэх хэсэг нэмэх:

“11.8.Энэ хуулийн 11.1.1, 11.1.2-т заасан байгууллага нь энэ хуулийн 11.1.4-т заасан нэгж, албыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана.”

11.9.Энэ хуулийн 5.10.1, 5.10.2, 5.10.3, 5.10.4-т заасан тусламж, үйлчилгээг хувийн хэвшлийн, төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “бодлого стратеги” гэснийг “хөгжлийн бодлого, чиглэл” гэж өөрчилж, “мэргэжил, удирдлага, арга зүйгээр хангах” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“12.1.2.энэ хуулийн 11.1.2, 11.1.3, 11.1.4, 11.1.5-д заасан байгууллага, нэгж, алба, нийгмийн эрүүл мэндийн ажилтныг мэргэжил, арга зүйгээр хангах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын “өвчний хяналт, сэргийлэлтийн” гэснийг “энэ хуулийн 5.2-5.9-д заасан” гэж, “удирдан зохион байгуулах” гэснийг “зохион байгуулах, хянах, мэдээлэх, холбогдох байгууллагад санал, зөвлөмж өгөх” гэж тус тус өөрчилж, 8.1.3 дахь заалтыг, 8.1.4 дэх заалтын “хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох,” гэснийг, мөн заалтын “, сургагч багш бэлтгэх, мэргэжил арга зүйгээр хангах” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, холбогдох байгууллагад санал, зөвлөмж өгөх” гэснийг “үндэсний хэмжээний судалгаа хийх, зохион байгуулах, санал, зөвлөмж гаргах” гэж, 8.1.6 дахь заалтын “чиглэлээр үндэсний хэмжээнд лавлагаа лабораторийн үүрэг гүйцэтгэх” гэснийг “үндэсний хэмжээний лавлагаа лабораторитой байх” гэж, 8.1.7 дахь заалтын “урьдчилан сэргийлэх тарилга, био бэлдмэлийг” гэснийг “бүтээгдэхүүнийг” гэж, 8.1.8 дахь заалтын “чиглэлээр ажиллаж байгаа ажилтныг сургах, чадавхжуулах” гэснийг “ажилтныг чадавхжуулах, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах” гэж, 8.1.9 дэх заалтын “мэдээллийн санг цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг үндэсний түвшинд хэрэгжүүлэх” гэснийг “мэдээ, мэдээллийг цуглуулах, нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх, үндсэн үзүүлэлтүүдийг тооцох, эмхэтгэн түгээх, эргэн мэдээлэх” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.1, 8.4.1 дэх заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалтын “бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр” гэснийг “хөгжлийн бодлого, чиглэл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх асуудлаар” гэж, 8.2.7 дахь заалтын “аюулгүй байдал алдагдахаас” гэснийг “аюулгүй байдал, шим тэжээлийн зохистой байдал алдагдсанаас шалтгаалсан өвчлөл, хордлогоос” гэж тус тус өөрчилж, 8.2.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.2.2.хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх орчны хүчин зүйлийг тогтоох, тандалт, судалгаа хийх, урьдчилан сэргийлэх, хянах, холбогдох арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд төлөвлөн зохион байгуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 14

Бүгд: 38

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.4 дэх заалтын “нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын” гэсний өмнө “шуурхай удирдлагын нэгжтэй байх бөгөөд” гэж нэмж, 8.2.5 дахь заалтын “зонхилон тохиолдох” гэснийг, мөн заалтын “, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, мэдээлэх, хянах” гэснийг, 8.2.8 дахь заалтын “өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх,” гэснийг, мөн заалтын “, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх” гэснийг, 8.2.6 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 16

Бүгд: 38

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“12.2.7.сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөх нийгэм, орчны сөрөг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

12.2.8.нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт, үнэлгээ хийх;

12.2.9.нийгмийн эрүүл мэндийн лабораторийн үйл ажиллагаа эрхлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 14

Бүгд: 38

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.4.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 8.4.3 дахь заалтын “халдварт болон халдварт бус зонхилон тохиолдох өвчний” гэснийг, 8.4.4 дэх заалтыг тус тус хасах:

“12.3.1.дархлаажуулалтыг зохион байгуулж, хэрэгжүүлэх;

12.3.2.өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа зохион байгуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 14

Бүгд: 38

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.4.6 дахь заалтын “хүний эрүүл мэндэд” гэснийг “харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндэд” гэж, “зан үйл, эрсдэлт хүчин зүйлийг тандах, судлах,” гэснийг “эрсдэлт хүчин зүйлийг тогтоох, тандалт, судалгаа хийх,” гэж өөрчилж, 8.8 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 18
Бүгд: 37
51.4 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“12.4. Энэ хуулийн 11.1.4-т заасан нэгж, алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.4.1.тухайн эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтанд нийгмийн эрүүл мэндийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

12.4.2.тухайн эрүүл мэндийн байгууллагын төрөлжсөн чиглэлээр тандалт, судалгаа хийх;

12.4.3.тухайн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 15
Бүгд: 37
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.2.1 дэх заалтыг, 9.1.3 дахь заалтын “халдварт болон халдварт бус зонхилон тохиолдох өвчин, түүний эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх,” гэснийг тус тус хасаж, 9.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.3.нийгмийн эрүүл мэндийн асуудлаар холбогдох мэргэжлийн байгууллага, албан тушаалтанд хандах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 14
Бүгд: 37
62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“13.2.2.гэр бүл, хамт олны дунд эрүүл зан үйл, амьдралын зөв дадал хэвшлийг бий болгоход нөлөөлөх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 13
Бүгд: 37
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “тархвар судлалд” гэснийг “тандалт, судалгаа, тархвар судлалын асуумжид” гэж, 9.2.6 дахь заалтын “нөлөөллийн талаар нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад мэдээлэх” гэснийг “нөлөөлөл, сэжигтэй тохиолдлын талаарх мэдээллийг холбогдох байгууллагад мэдэгдэх” гэж тус тус өөрчилж, 9.2.2 дахь заалтын “, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх дадал хандлагатай байх” гэснийг, 9.2.5 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 16
Бүгд: 37
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “зөвлөгөө” гэсний дараа “, мэдээлэл” гэж нэмж, мөн заалтын “хамгаалах чиглэлээр мэргэжлийн байгууллагатай” гэснийг “дэмжих чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай” гэж өөрчилж, 10.1.3, 10.1.5, 10.1.7 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 14
Бүгд: 37
62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтын “орчин бүрдүүлэх” гэсний дараа “асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусган, хэрэгжүүлэх” гэж, мөн хэсэгт доор дурдсан агуулгатай заалт тус тус нэмэх:

“14.1.5.байгууллагын үйл ажиллагааны чиглэл, нутаг дэвсгэрийн онцлогт уялдуулан ажилтныг дархлаажуулалтад хамруулах арга хэмжээ авах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 13
Бүгд: 37
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Олон нийтийн оролцоо

15.1.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нээлттэй ил тод байх бөгөөд түүнд олон нийтийн оролцоог хангах, хяналт тавих боломжийг бүрдүүлсэн байна.

15.2.Энэ хуулийн 11.1.1-11.1.4-т заасан байгууллага нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ олон нийтийн оролцоог дараах байдлаар хангана:

15.2.1.байнгын ажиллагаатай цахим хуудсаар дамжуулан мэдээлэл хүргэх, санал авах;

15.2.2.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын сайн дурын оролцоог хангах, урамшуулах.

15.3.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд олон нийтийн оролцоог хангах, сайн дурын ажилтныг урамшуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 12

Бүгд: 37

67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.3 дахь хэсгийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

16.1.Хэвлэл мэдээллийн байгууллага нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар иргэд, олон нийтэд үнэн зөв, бодит мэдээлэл хүргэнэ.

16.2.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд үнэ төлбөргүй түгээнэ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 13

Бүгд: 37

64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 13.1.3 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.1.1.Эрүүл мэндийн тухай хуулийн 28.1.1, 28.1.4, 28.1.5-д заасан эрх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 13

Бүгд: 37

64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь заалтын “эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах,” гэснийг хасаж, мөн заалтын “дэмжлэг үзүүлэх” гэсний дараа “, мэргэжлийн асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгжид зааварчилгаа, зөвлөгөө өгөх” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“17.2.5.хүн амын эрүүл мэндэд аюул бүхий өвчин, хордлого, орчны сөрөг нөлөөллийн талаар холбогдох байгууллагад мэдээлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 13

Бүгд: 37

64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “ажилтан” гэсний дараа “энэ хууль болон” гэж нэмж, 14.2 дахь хэсгийн “нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “гэмт хэргийн шинжгүй” гэснийг “хуульд өөрөөр заагаагүй” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 15

Бүгд: 37

59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15.4 дэх хэсгийг хасах:

“19.1.Энэ хуулийн 19.2-т зааснаас бусад нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

19.2.Холбогдох хуульд заасны дагуу нийгмийн эрүүл мэндийн зарим тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын болон Эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлэх бөгөөд хандив, тусламж, дэмжлэг, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 12

Бүгд: 37

67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмж, 15.5 дахь хэсгийн “тусламж, үйлчилгээний” гэсний дараа “төрөл” гэж нэмэх:

“19.4.Нийгмийн эрүүл мэндийн байгууллагын зарим тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 12

Бүгд: 37

67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

48.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Иргэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, хуулийн этгээд нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах

үйл ажиллагааны талаар, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед” гэснийг “Нийгмийн эрүүл мэндийн асуудлаар” гэж өөрчилж, 16.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 14
Бүгд: 37
62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.Энэ хуулийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 16
Бүгд: 37
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, С.Чинзориг нар үг хэлэв.

50.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд зүйл, хэсэг, заалт нэмэх, хасах саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын “урьдчилан сэргийлэх” гэсний дараа, 5.2.3 дахь заалтын “хадгалах” гэсний дараа, 5.2.7 дахь заалтын “тандах” гэсний дараа “үйл ажиллагаа явуулна.” гэж, 6 дугаар зүйлийн 6.13.3 дахь заалтын “нутаг дэвсгэрийн” гэсний өмнө “харьяа” гэж, 8 дугаар зүйлийн 8.2.4, 8.4.5 дахь заалтын “ноцтой байдлын” гэсний дараа “үеийн” гэж, “арга хэмжээг” гэсний дараа “авч” гэж, 8.2.8 дахь заалтын “эрүүл мэндийн” гэсний өмнө “хүн амд” гэж, 8.9 дэх хэсгийн “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “батална” гэсний өмнө “хамтран” гэж тус тус нэмэх;

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “эрүүл мэндийн байдал” гэснийг “эрүүл мэнд” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтын “нөлөөлөх” гэснийг “үзүүлэх” гэж, “хариу арга хэмжээг” гэснийг “холбогдох арга хэмжээ” гэж, 3.1.7 дахь заалтын “тодорхойлж” гэснийг “тогтоож” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “олон хувилбартай байх” гэснийг “хэлбэр үл харгалзах” гэж, 4.1.4 дэх заалтын “хуулийн этгээдийн” гэснийг “аж ахуйн нэгж, байгууллагын” гэж, 4.1.7 дахь заалтыг “олон нийтийн, сайн дурын ажилтны

оролцоог хангах” гэж, 5 дугаар зүйлийн 5.2.2, 5.2.3, 5.2.7, 5.2.8 дахь заалтын “төрөлд” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд” гэж, 5.2.2 дахь заалтын “өвчлөл” гэснийг “өвчин эмгэг” гэж, 5.3.1 дэх заалтын “тандалт, судалгаа” гэснийг “тандах, судлах” гэж, 5.3.5 дахь заалтын “түншлэл, хамтын ажиллагаа” гэснийг “оролцоо, хамтын ажиллагааг хангах” гэж, 6 дугаар зүйлийн 6.8.2 дахь заалтын “бодлого, хөгжлийн чиг хандлага,” гэснийг “хөгжлийн бодлого, чиглэлийг болон” гэж, “тодорхойлох” гэснийг “тодорхойлж, хэрэгжүүлэх” гэж, 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.4 дэх хэсгийн “эрх үүргийг” гэснийг “чиг үүргийг” гэж, 8.2.7 дахь заалтын “тодорхойлох” гэснийг “тогтоох” гэж, 8.4.3 дахь заалтын “зохион байгуулах” гэснийг “зохион байгуулж, хэрэгжүүлэх” гэж, 8.4.5 дахь заалтын “бэлэн байдал” гэснийг “бэлэн байдлыг хангах” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтын “хуулийн” гэснийг “хууль тогтоомжийн” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалтын “боломж бүрдүүлэх” гэснийг “боломжоор хангах” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “эрхтэй” гэснийг “эрх эдэлнэ” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “ажилтанд урамшуулал олгох” гэснийг “ажилтныг урамшуулах” гэж, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “ангилал,” гэснийг “ангиллаар болон” гэж тус тус өөрчлөх;

3.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “хууль эрх зүйн” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалтын “хөдөлмөр эрхлэгч” гэснийг, 5.2.7 дахь заалтын “судлах,” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.1.4, 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь заалтын “амьдрах” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.13.4, 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “нийгмийн” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтын “, мэдлэг” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалтын “энэ хуулийн 3.1.11-д заасан” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “арга болон” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 18

Бүгд: 38

52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

Нэг.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх найруулгын санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмж, 1 дүгээр зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх:

“1 дүгээр зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.26 дахь заалт нэмсүгэй:

“3.1.26.“нийгмийн эрүүл мэндийн ажилтан” гэж Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 3.1.17-д заасан мэргэжилтнийг.”” саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 21

Бүгд: 38
44.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмж, 1 дүгээр зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх:

“1 дүгээр зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.26 дахь заалт нэмсүгэй:

“3.1.26.“нийгмийн эрүүл мэндийн ажилтан” гэж Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 3.1.17-д заасан мэргэжилтнийг.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “29.5 дахь” гэсний өмнө “29.2 дахь хэсгийн “эмнэлгийн мэргэжилтэн,” гэсний дараа “нийгмийн эрүүл мэндийн ажилтан,” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “24 дүгээр зүйлийн 24.6.4 дэх хэсэгт “нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа, арга хэмжээ болон гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлтийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, гамшигийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;” гэж” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“24.6.4.хуульд өөрөөр заагаагүй бол нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 14

Бүгд: 38

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “эрүүл мэндийн тухай хууль тогтоомж” гэснийг “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай” гэж өөрчилж, мөн зүйлийн “тус тус өөрчилсүгэй” гэсний өмнө “35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсгийн “энэ хууль” гэснийг “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 14

Бүгд: 38

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “13 дугаар” гэсний өмнө “7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 15

Бүгд: 38

60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд шинэ зүйл нэмсэнтэй нийцүүлэн төслийн дугаарлалтыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 18

Бүгд: 38

52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх найруулгын санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 18

Бүгд: 38

52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх найруулгын санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “6.29 дэх хэсгийг” гэснийг “6.31 дэх зүйл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Дөрөв.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх найруулгын санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “6.8 дугаар зүйлийн “6.28 дугаар зүйлийн 5 дахь хэсэг” гэсний дараа “6.29 дүгээр зүйл,”” гэснийг “1.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтын “7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг,” гэсний өмнө “6.31 дүгээр зүйл,”” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх найруулгын санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “нийтийг хамарсан халдварт өвчний” гэснийг хасаж, “нийгмийн эрүүл мэндийн” гэсний өмнө “дэгдэлт,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, С.Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн 29, 30 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Б.Дэлгэрсайхан нарын урилгаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Төмөр замын татах хэсгийн удирдлага, инженер, техникийн албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Г.Амартүвшин, Т.Доржханд нарын урилгаар Хан-Уул

дүүргийн 3, 10, 19 дүгээр хорооны иргэдийн төлөөлөл, Монгол Улсын Засгийн газраас зохион байгуулж буй “Урт хугацааны хөгжлийн бодлого-Иргэдийн оролцоо” сэдэвт сургалтад оролцогч иргэд, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм, Ж.Эрдэнэбат, Д.Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Сүхбаатар сумдын Ерөнхий боловсролын сургуулийн 12^а ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын урилгаар PUBG MOBILE цахим спортын тоглоомын дэлхийн аварга шалгаруулах тэмцээний аварга баг болон шагналт байр эзэлсэн багийн тамирчид, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын урилгаар Хустайн цогцолбор газрын албан хаагчдын төлөөлөл, Хөдөө аж ахуйн их сургуулийн Хөдөө аж ахуйн төв номын сангийн хамт олон, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаагийн урилгаар аутизмтай хүүхдийн асран хамгаалагчдын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 38 минут үргэлжилж, 72 гишүүнээс 49 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 13 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 14-ний өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Их
хуралдай” танхим 10 цаг 38 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Гишүүдийн амгаланг айлтгая. Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улс Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк болон олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл, зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газраас өргөн мэдүүлсэн. Энийг соёрхон батална аа. Бямбацогт сайдаа сайд нараа дуудаарай 39-өөр эцэслэн батална.

Хоёрдугаарт, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл. Энийг бас соёрхон батална аа.

Гуавдугаарт, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийг явуулна. Зарчмын зөрүүтэй 61 саналтай.

Дөрөвдүгээрт, Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах

зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна аа. Зарчмын зөрөөтэй 4 саналтай байна аа.

Тавдугаарт, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Одонтуяа нарын 10 гишүүн өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу өнөөдрийн чуулганаас эхлэх өдрөөс өмнөх 17 цагаас өмнө үг хэлэх хүсэлтээ албан ёсоор ирүүлсэн 4 гишүүн байна.

Ширнэнбандийн Адьшаа гишүүн байхгүй байна. Ингээд Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Эрхэм гишүүдийн амар амгаланг айлтгая аа. Одоо ч нохойн дуу ойртчихсон үед ч би ч нэг олон юм ярих сонирхол алга л байна. Тэгээд юм асуувал ч би хариулна буцахгүй шүү. Тэгээд хэлэх нэг шаардлагатай 2 юм гарчхаад байна аа. Одоо бол яах вэ үг нэг их хэлэх сонирхолгүй байгаа нь Улсын Их Хурал, Засгийн газар сонгууль ойртчихсон хийх ёстой юм байсан бол хийсэн байх ёстой, хийж чадаагүй бол чадаагүй. Ингээд л шаагилдаад л орно. Засаж залруулах гээд л шүүмжлэх гээд л одоо нэг л гоё үр дүн гаргах гээд л одоо тийм юм бол бага.

Тийм учраас иргэд сонгогчид дүнгээ тавих гээд л хүлээгээд байгаа байх. Миний гол өнөөдөр хэлэх гэж хэлэлцэх асуудалд оруулаасай гэж хүсэж байгаа нэг зүйл байна. Жижиг юм гэж битгий бодоосой. Өчигдөр энэ ордны энэ хаалганаас тавьхан метрийн цаана

байгаа үүдээр явж байгаад 6 сар болж байгаа нэг эмэгтэй хүнтэй л тэр эмэгтэйтэй би уулзлаа. Үгүй ээ яагаад ингээд удаад байна. Баахан л самбар тавьчихсан.

Сүхбаатар аймгийн хүн юм байна. Энхцэцэг гэж хүн байна. Би чам руу утсаар ярина шүү гэсэн. Ээ ах минь хар мянган хүн өр зээл гээд утсаар ярих гээд чадахгүй байна л гэсэн. Юу болсон юм бэ гэсэн би төрийн буруутай үйл ажиллагаанаас болоод хохирчихсон байна. Тэр машин дотор миний охин байгаа. Би 6 сар машин дотор амьдарч байна л гэсэн. Миний хэлэх гээд байгаа юм. Миний хүү яаж туслах вэ гэсэн үгүй ээ ах минь та тэр чуулган дээр эхэнд нь нэг хэлдэг үг байдаг юм гэсэн. Та энийг нэг хэлж тэр яам, тамгын газар эсвэл агентлаг нь надтай ирж нэг уулзаад өгөөч ээ. Би бас энэ асуудлуудаа яримаар байна. Тэнгэр хол газар хатуу болчихоод байна л гэсэн.

Энийг би уламжилж өгч байна эрх баригчид минь ээ. Тэр Энхцэцэг гээд хүнтэй Их Хурлын дарга аа үүрэг даалгавар болгоод энэ чинь бид чинь ард иргэдийн төлөөлөл шүү дээ. Засгийн газрыг бол ард түмэн сонгоогүй. Ерөнхий сайдыг, яамдуудын сайд нарыг. Улсын Их Хурлыг бол ард түмэн сонгосон. Тэдэнд нэг хэлж өгч туслаач ээ гэсэн 1 дүгээр асуудал байна.

Хоёрдугаар асуудал би өмнөх 4 дэх өдөр байх чуулган дээр үг хэлж байгаад бас үгээ таслуулчихсан юм, гүйцээгээд хэлье.

Өнөрөө сэтгүүлч өлсгөлөн зарлаад эхэллээ тэр нь би одоо бас тэр хувь хүний тухай яриагүй. Сэтгүүлч, сайд 2 хоорондоо үзэлцэнэ гэдэг бол хэдхэн өдрийн өмнө хүний эрхийн хүндэтгэлийн чуулган бид хийсэн шүү дээ. Энэ асуудал дээр яадаг ч бай сэтгүүлчийн зөв байж таар аа л гэж би итгээд байгаа. Тэгээд энэ асуудлыг хүний эрхийн хууль

тогтоомжуудын хэрэгжилтийн талаар Улсын Их Хурал дээр бас Цогтбаатар дарга Хууль зүйн байнгын хорооны дарга байгаа байх. Сонсгол хийж энийг нэг тийш нь болохгүй бол нийгэм 2 талдаа хуваагдчихаад байна. Нийгэм ороо бусгаа энд үймж байна гэдгийг Улсын Их Хурал дээр бас авч үзэж ярьж тэр тусгай Байнгын хороод нь энийг нэг ярилцаж сонсгол хийх юм уу, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийнхаа дагуу эрх мяндагтнууд ялангуяа сайд нар эрх мэдлээ хэтрүүлж хүний эрх зөрчиж байх вий гэдэг энэ асуудлаар Улсын Их Хурал зүгээр дүлий дүмбэ байж болохгүй ээ гэдэг ийм байр сууриа илэрхийлж байна аа.

Тэгээд холбогдох Байнгын хороод болон холбогдох газруудад нь би бас бичгээр албан бичгээр хандсан байгаа. Энийгээ Улсын Их Хурлын чуулган дээр бас энэ хэлэлцэх асуудал дээр оруулж өгөөч ээ гэдэг хүсэлт тавьж гишүүддээ уриалж байна аа.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун гишүүн үг хэлэх хүсэлт ирүүлсэн байна.

Х.Болорчулуун: Баярлалаа. Манай Улсын Их Хурал нэг зөв зүйтэй тогтоол батлан гаргасан. Энэ хүнсний хангамж аюулгүй байдлын тухай 36 дугаар тогтоол. Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих хийж чадаж байгаа, чадах зүйлээ дотоодоос хангах ийм бодлого бүхий тогтоолыг батлан гаргасан. Энэ тогтоолын дагуу одоо өнөөдрийн байдлаар хөдөө аж ахуй болон хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг компаниудад 700 тэрбум төгрөгийн 5-аас 6 хувийн хүүтэй зээл олгогдоод байна.

Зөвхөн зээл олгосноор энэ асуудлыг шийдэхгүй ээ. Хамгийн гол нь баялаг бүтээгчдэд маань хэлж байна. Үгүй ээ бид нар бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулахад бидэнд бас төрийн хамгаалалт хэрэгтэй байна аа.

Гаднаас нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн гаднаас орж ирээд цохилтод оруулаад байх юм аа. Энэн дээр тавхан хувийн татвар үнэхээр хамгаалалт болж чадахгүйг анхаарч үзээч ээ гэж хэлж байгаа юм.

Тийм ч учраас Засгийн газраар дамжаад хэлэлцэгдээд Их Хурал руу импортын татварын асуудал орно оо. Гэхдээ гэнэтхэн бүх юмны үнэд нөлөөлчихөөр импортын татварыг огцом тавихгүй. Одоо байгаа 5 хувийн татварыг жилдээ 5, 5 хувиар нэмээд 2026 он гэхэд 20 хувьд хүргэхээр Дэлхийн худалдааны байгууллагын өмнө авсан үүрэг амлалтынхаа хүрээнд нэмэгдүүлж тавина. Тэгэхгүй зүгээр хөнгөлөлттэй зээл өгөөд энэ 2 том үйлдвэрлэгчийн өмнө бол үнэхээр манай үйлдвэрлэгчид тэр тавхан хувийн татварын хамгаалалт болж үнэхээр чадахгүй байгаа.

Бид нар бол тэр цагаан будаа, ургамлын тос, элсэн чихэр гээд хийж үйлдвэрлэж чадахгүй ойрын хугацаанд тийм юмнууд дээр татвар тавиад яах юм.

Өнөөдөр бас нэг тариалангийн сэргэлтийн жил болгож 2023 оны зарласан бас төрийн бодлого энэ шийдвэрийн үр дүнд хүнсний ногоо гэхэд 85 хувиа анх удаа хангаад байна шүү дээ. 85 хувь. 90-ээс 100 хувь хангана. Яг л иймэрхүү хангаж байгаа хангамжтай ийм хүнсний ногоо болон хүнсний зүйлүүд дээрээ үйлчилсэн татвар тавих юм гэдгийг бас хэлэх байна.

Гэтэл зарим хүмүүс улс төржүүлээд төрийн өндөр албан тушаал хашиж байсан хүн юмны үнэ өсгөх нь, татвар тавих нь гээд зориуд улс төржүүлээд л ингээд над руу яам руу ингээд хандсан юм бич бичээд байх юм. Үгүй ээ бид алийн болгон гадагшаа, хямдыг нь, хямдыг нь гээд 5, 10 хувийн хямдыг бодоод гаднаас авах юм бэ? Төгрөгөөр авдаг бол хямдыг нь авах нь зөв.

Дандаа валютаар авдаг. Валютын хани нь жил болгон өсөөд мөнгөний ханшаа унагааж байдаг. Валютын хани нь уургын морь шиг уралдааны морь шиг зугтаж байдаг. Бид энэ 30 жилд үндсэндээ хэрэглээний орон болсон байхгүй юу. Үйлдвэрлэгч биш. Ард иргэдэд халамж биш, ажлын байр хэрэгтэй байна. Лангуу биш үйлдвэрлэл хэрэгтэй. Бид чадах зүйлээ, чадаж байсан зүйлээ төр бодлогоор дэмжих ёстой.

Тэгэхдээ импортын гаалийн татварыг бид ухаалаг үйлчилсэн байдлаар хангамжтайгаа уялдуулж тавина гэдгийг нөхдүүдэдээ бас хэлье ээ. Тэгээд энд орж ирэхэд та бүхэн бас дэмжээрэй гэдгийг бас хэлэх байна. Түүнээс гадна сая Ганбаатар гишүүн тэр гадаа, ордны гадаа зогсож байгаа эмэгтэйн талаар ярилаа.

Би бас яг өөртэй чинь адилхан хэлмэгдээд хохирсон юм байх гээд 4, 5 удаа уулзсан. 5 хоногийн өмнө ч хүртэл уулзсан. Энэ хүн бол энэ үед биш гэхэд 2, 3 жилийн өмнө би хохирсон. Мах гадагшаа экспортод гаргах гээд хохирсон гэж ярьдаг. Тэр хохирлынхоо хэмжээг бол хэлдэггүй. Яг ажлын хэсэг гараад яамнаас хүмүүс ажилласан. Өөрийн гэсэн үйлдвэр байхгүй, агуулах байхгүй, мах байхгүй.

Тухайн үед нь Мэндсайхан сайд махаа талбай дээр асгана шүү гэхэд нь бас 15 контейнерыг, тэр өөрийнх нь ч юм уу тэр Хятадуудынх нь ч юм уу хамт ажилладаг 15 контейнер махыг нь гаргаж өгч байсан юм билээ. Квоттой компанийн нэр дээр. Тэгээд чи хохирсон бол шүүхдээ өг өө. Шүүхэд өгөхгүйгээр ингээд 9, 10 тэрбум нэр нэхэмжлээд явдаг ийм энийг гаргах боломжгүй шүү дээ гэж хэлдэг байхгүй юу. Шүүхэд өгдөггүй.

Ингээд одоо учир битүүлэг шаардлага тавиад ингээд цохиод зогсоод байгаа. Энэ дээр бас эмэгтэй гишүүд маань бас бас сая хэллээ.

Тэгэхээр бол хуультай орон хуулийн дагуух энэ шүүхээр яваад шийдэгдэх асуудал шүү дээ. Тэгээд хохироосон юм бол байхгүй юм байна лээ. Урьд өмнө яамны зүгээс бол. Баярлалаа.

Г.Занданшатар: Энэ иргэн Энхцэцэгтэй холбоотой асуудал бол энэ мах бэлтгэлтэй холбоотой. Нөгөө Эмээлтийн махны үйлдвэрүүдэд нөгөө тусгай зөвшөөрөлгүй мах нийлүүлж байгаад л тэгээд л тэрэн дээрээ Мэргэжлийн хяналт энэ тэр ороод л хууль зөрчсөн үйлдэл гээд л ингээд ийм асуудал үүсчихсэн юм байна лээ. Тэгэхээр хуулийн дагуу л явахаас биш.

Болорчулуун сайд бол тодорхой хариулт өглөө. Тэгээд Ганбаатар гишүүн одоо хүлээж авч уулзаад шийд нэгтэй асуулт тавьсан юм чинь. Хуулийнх нь дагуу Болорчулуун сайд уулзсан ярьсан юм байна. Болорчулуун сайд ч гэсэн цуг уулзаж болно.

Тийм манай эмэгтэй гишүүд Сарангэрэл, Жаргалмаа гишүүд нар уулзсан, бас танилцуулсан. Хөдөө аж ахуйн яаманд мэдэгдсэн. Тэгээд нөгөө хуультай холбоотой асуудал учраас ийм байгаа. Тэгээд хуулийн доор л амьдрах ёстой шүү дээ. Хууль засагладаг юм юм чинь. Бусад асуудлууд ч гэсэн бид нар шүүхэд нөлөөлөх эрх байхгүй.

Үндсэн хуулиа баримтлах ёстой. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн үг хэлэх хүсэлт ирүүлсэн байна.

12 дугаар сарын 14-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлэх зөвшөөрөл олгож өгнө үү гэсэн байна.

Д.Өнөрболор: Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Улс оронд үүсээд байгаа энэ цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулаад ер нь хэд хэдэн асуудлууд дээр бас анхаарлаа

хандуулах шаардлагатай байна гэж үзэж бас үг хэлэх ийм боломж авсан юм. Тэгээд энэ сүүлийн өдрүүдэд шатахуун түлшний хомсдол мөн одоо энэ эрчим хүчний хязгаарлалт гээд л маш их асуудлууд ингээд үүсэж байна. Энэ бол өнөөдөр ганцхан үүсээд байгаа асуудал. Сүүлийн 20, 30 жил л энэ асуудлыг ингээд ярилаа.

Тэгэхээр одоо бид ер нь энэ эрчим хүчний нөөц, энэ эрчим хүчний одоо аюулгүй байдал энэ бие даасан байдлын тал дээр бид нар өнөөдөр сэргэлтийн биш бараг хувьсгалын шинжтэй ийм реформ хийх цаг үе нь болчихжээ гэж харагдаж байна аа. Тэр дундаа бол энэ дэлхийн улс орнуудын хийж хэрэгжүүлээд байгаа одоо яг энэ шилжилт нэн ялангуяа эрчим хүчний энэ энержи транзишн буюу энэ эрчим хүчний шилжилт рүү нэн яаралтай бид нар бас тооцоо судалгаатай зоригтой бас шилжих ийм шаардлага харагдаж байна аа.

Нөгөө нэг асуудал нь болохлоор чинь бол энэ эрсдэлийг бууруулах менежмент төлөвлөгөөтэй бид нар улс орон болох нэн шаардлагатай байна гэж бас харагдаж байна аа.

Бид өнөөдөр энэ эрчим хүчний нөөцийн эх үүсвэр мөн энийг түүнийг нөхөх асуудлаа бүрэн ингэж шийдэж чадаагүй байгаа тохиолдолд энэ эрсдэл өнөөдөр оршсоор л байна. Байсаар л байна. Тэгээд нэн ялангуяа хүйтний улирал ингээд ирчихлээ. Энэ өдрөөс өдөрт чангарч байгаа энэ цаг үед ийм эрсдэл үүсвэл яана аа. Энэ түлш, шатахуун энэ цахилгаан дулааны эрчим хүчний хангамжид магадгүй доголдол үүслээ гэсэн тохиолдолд үүнтэй холбоотойгоор нийгэм эдийн засгийн болон улс орны ард иргэдийн амьдралд маш их гарз хохирол учрах нөхцөл байдал үүсэх нь ээ. Тэр байтугай энэ олон улсын ачаа тээвэр, хил гааль, боомт, дээрээс нь энэ ард иргэдийн эрүүл аюулгүй байдал, амь насны эрсдэл, хүнсний хангамж, аюулгүй байдал гээд ингээд маш их олон тоо тоочоод байх юм

бол тоолж баршгүй хэмжээний ийм сөрөг нөлөөтэй асуудлууд энэ менежментийг бууруулах төлөвлөгөөгүй байгаагаас болж үүсэх ийм асуудал үүсэж байна аа.

Тэгээд Монгол улс өнөөдөр эрчим хүчний нийт хэрэглээний 22 хувийг импортоор авдаггүй. Авч л байгаа. Нэн ялангуяа энэ цэргийн ажиллагаатай байгаа эмзэг эрсдэлтэй байгаа энэ ийм улсаас ийм цаг үед үнэхээр юу гэдэг юм ингээд тэр тухайн улс нь тийм ээ нийлүүлэе гээд тэгсэн ч гэсэн нийлүүлж чадахгүй нөхцөл байдал үүсэх юм бол бид нар яах вэ?

Тэгэхээр бусад улс улс орнууд энэ дээр ямар стратегийн ач холбогдол бүхий баримт бичгүүдийг боловсруулж тийм ээ ард иргэддээ хүртэл зөвлөмж өгч энэ эрсдэлийг бууруулах менежментийн төлөвлөгөө гарын авлагыг боловсруулж энэ удирдамжаар хангаж боловсруулж ажиллаж байна гээд тэгэхлээр гэнэтийн одоо болзошгүй зүйлд бид нар хэрэв бэлтгэж тийм ээ энэ системийн доголдлоос сэргийлээд үнэхээр хурдан сэргээх, сэлгэх үр дүнтэй арга хэмжээ авах энэ менежментийн бодлогыг урьдчилан боловсруулаад шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлж энэ зохион байгуулалтаар хангах тэ хүний амь эрсдэх ийм бэлтгэлээ ингээд хангахгүй л юм бол хүний амь эрсдэх аюул учрах ийм хохирол учрах ийм нөхцөл байдал үүсэж байгаа юм аа. Түүний энэ хамгийн гол чухал нэг арга хэрэгсэл нь бол манайх шиг ийм тархай бутархай, алслагдсан аймаг, сум, орон нутаг, энэ суурьшсан иргэдийг энэ харилцаа холбоо тасрахгүй байх нөхцөлөөр хангах явдал хамгийн чухал асуудал болчихоод байгаа юм аа.

Өөрөөр хэлэх юм бол энэ бие даасан харилцаа холбооны системийг ашиглах явдал. Одоо энэнийг менежментийн тийм ээ хамгийн чухал суурь арга хэрэгсэл болгох ийм дэд бүтэц манай улсад байна уу? Миний ойлгож байгаагаар бол одоогоор байхгүй байгаа.

Тэгээд энэ тэр үеийн энэ гамшигийн осол аваар энэ аюулын эрсдэлийн асуудлуудаа энэ нөөцийн удирдлагаа эрэлт нийлүүлэлтээ яаж хангах юм, тээвэр ложистикоо яаж хангах юм? Ийм асуудлуудаа бол бид нар бас ингээд анхаарал хандуулж зохицуулалтад оруулах нэн шаардлагатай байна гэж харагдаж байна аа.

Зүгээр энэ ойрын 2 Солонгосын энэ зөрчилтэй 2 улсын энэ эрсдэлийн менежмент бууруулах менежментийн асуудлыг л ингээд аваад үзэхэд магадгүй Бүгд Найрамдах Солонгос улсад бөмбөг дэлбэрлээ гээд тэгэхэд ямар удирдамжаар ард иргэд нь хөдөлсөн байх ёстой юм төр засаг захиргааны нэгжүүд нь ямар заавар зааварчилгаагаар, ямар зөвлөмжийн дагуу хэн нь хаашаа хэн нь.

Г.Занданшатар: Манай Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн цаг үеийн чухал асуудал маань зарчмын байр суурь илэрхийлж байна. Энэ дээр энэ Засгийн газар сайд нар анхаарах хэрэгтэй байна аа. Энэ гал унтраах байдлаар ажилладгаа болих хэрэгтэй байна.

Тавдугаар цахилгаан станц, Тавантолгойн цахилгаан станц яасан Чойжилсүрэн сайд. 10, 20 жил л ярьж байна. Тэр гацаадаг гацаасан хүмүүс тэгээд эрчим хүчний асуудалтай болоод л тэгээд өнөө маргаашаа яах вэ гэж байдаг. Тэр эрсдэлийн менежментийн төлөвлөгөөтэй эрсдэлийг даван туулах төлөвлөгөөтэй байна гэдэг туйлын чухал шүү дээ. Тэгээд л нэг асуудал болохоор л болохоо болилоо гээд л. Шатахуун ч гэсэн тэр. Шатахуун бол тээвэр ложистикийн саатал цаад газар бол чөлөөтэй нийлүүлж байгаа юм байна лээ шүү дээ. Гол нь тээвэр ложистикийн саатал, дайн байлдааны нөхцөл байдал дотоодын зохиомол хомсдол үүсгэж байгаа гадаадын зарим компаниуд асар ихээр дизель түлш нөөцөлж зохиомол хомсдол үүсгэж байгаа гэсэн ийм мэдээ мэдээлэл байгаа шүү. Тэд нар гараад л ер нь энэ

зохиомол хомсдол байхгүй болох юм байна.

Ингээд хүмүүсийг цочирдуулаад бүх приус машин нэг өдөр шатахуун хомсдох нь гээд л банкаа дүүргэхэд манайх чинь 10 сая литр шатахуун шууд дутагдах юм байна лээ шүү дээ. Ийм эрсдэлийн менежментийн төлөвлөгөө байхгүй тэгээд л ингээд л ийм гал унтраах байдлаар шатахууны нөөцтэй болох хэрэгтэй.

Аль дээр л нөөцийн сав байсан никийн нөөцийн савыг төмрийн хогонд гадагшаа зарчихсан. Одоо нөөцийн сав байхгүй. Улсын стратегийн нөөц савтай байх хэрэгтэй байна. Энийг Засгийн газар, Монголбанк энэ тэр ярьж байгаад нөөцийн савыг санхүүжүүлэх хэрэгтэй байна.

Баруун зүүн бүсэд нөөцийн савуудтай байсан шүү дээ манайх. Энэ хойд Рашаантын өртөө энэ тэр дээр. Зээл хуулийн бодлогоор юм уу, энэ шатахууны бодлогоор шийдэх хэрэгтэй байна.

Үнэ тогтворжуулах хууль хүртэл баталж өгсөн. Тэгээд энэ дээр гал унтраах байдлаар биш дундын ойрын шийдлүүдийг хийх хэрэгтэй. Газрын тосны үйлдвэр яасан. Тэгээд л нэг үл үзэгдэгч л хамаг юмыг зогсоож байдаг цахилгаан станц ч тэр, газрын тосны үйлдвэр ч тэр. Тэр үл үзэгдэгч хүчийг хэн гэдгийг мэдэж байгаа шүү дээ бид нар. Бүгдээрээ энэ дээр шийдвэртэй арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улс Дэлхийн банкны олон улсын сэргээн босголт хөгжлийн банк болон олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар, Хассуурийн Ганхуяг, Салдангийн Одонтуяа нарын урилгаар БГД-ийн 29, 30 дугаар хорооны иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт Баянголчууд та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх сайн сайхныг хүсэн ерөөе өө.

Жамбалын Ганбаатар сайдаас шатахуун энэ тэр гээд л яриад гарсан зайлуул тэгээд. Ганбаатар сайд ШТС-уудаар орно гээд гарсан одоо ороод ирэх байх. Энэ зарим компаниуд нэрийг нь заагаад хэлбэл маш их хэмжээний дизель түлш энэ тэр нөөцөлчихсөн ийм мэдээллүүд байгаа шүү. Худалдаж аваад. Тэгээд хомсдол үүсгээд байгаа зохиомол. Ингээд хууль санаачлагчийн илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк болон олон улсын хөгжлийн ассоциацитай хамтран хэрэгжүүлэх Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төслийн зээлийн хэлэлцээрт Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 1 дүгээр захирамжийг үндэслэн 2023 оны 8 дугаар сарын 28-ны өдөр гарын үсэг зурсан билээ. Энэхүү төслийн зорилго нь Монгол Улсын хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсийн нэг болж буй авто замын дэд бүтцийг сэргээн сайжруулах улмаар улсын тогтвортой хөгжлийн тулгуур болох хөдөө аж ахуй түүний дотор мал аж ахуйн бүтээгдэхүүний тээвэр логистикийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн болно. Төслийн хүрээнд нийслэл хотыг баруун бүс, зүүн бүс болон хойд бүс

нутагтай холбосон улсын чанартай авто замын сүлжээн дэх нийт 361км хатуу хучилттай авто зам 8 байршил дэх нийт 1200 метр төмөр бетон гүүрийг шинэчлэн сайжруулах Засгийн газрын 2 мянга 2020-оос 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нутгийн зам төслийн хүрээнд хэрэгжих зарим сумдыг холбох зэрэг ажлууд хийж хэрэгжинэ ээ.

Энэхүү төсөл нь улсын чанартай гол авто замын сүлжээний насжилт өндөртэй ашиглалтын бэлэн байдлын түвшний үзүүлэлт буурсан. Улаанбаатар-Арвайхээр, Арвайхээр-Баянхонгор, Хархорум-Цэцэрлэг, Цэцэрлэг-Тосонцэнгэл, Улаанбаатар-Өндөрхаан, Өндөрхаан-Чойбалсан, Булган-Мөрөн чиглэлийн замын хэсгүүд болон тус чиглэл дагуух Хэрлэн, Орхон, Тамир, Гичгэн, Хануй, Бэлх, Лун, Түргэн зэрэг голуудын төмөр бетон гүүрүүдийг хамарч байгаа ба төсөл хэрэгжсэнээр авто замын сүлжээний аюул осолгүй, ая тухтай, үр ашигтай зорчих нөхцөл эрс дээшилж тээврийн ашиглалтын зардал буурах, цаг хугацаа хэмнэх, цаашилаад сүлжээний эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм аа.

Төслийг Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк банкнаас олгох 100 сая амдоллар олон улсын хөгжлийн ассоциациас олгох 7.3 сая зээлжих тусгай эрх буюу эрх буюу нийт 110 сая амдолларын санхүүжилтээр хэрэгжүүлнэ ээ. Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь хэсэгт гадаад улс Олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ нь Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах олон улсын гэрээ мөн гэж заасан билээ.

Иймд тус зээлийн хэлэлцээрийг Соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна аа. Индэрт урьж байна.

Н.Энхболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 11 сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улс Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк болон олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 12 сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Байнгын хорооны дарга Б.Энхамгалан нь Засгийн газарт хүргүүлсэн уг төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцсэн тухай Байнгын хорооны санал, дүгнэлтэд зээлийн хөтөлбөрийн төслийг сайжруулах талаар өгсөн 9 чиглэлийг төсөлд тусгасан эсэх, зөвшилцөх төсөлд 311 км замын засвар шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэхээр байсныг 361 км болгож өөрчилснийг тодруулан асууж төслөөс эмэгтэй малчдад платформд оролцох цахим хэрэгсэл, ур чадвар, мэдлэгээр дэмжих, сургах гэснийг хасах талаар ажлын хэсэгт анхааруулсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар 2024 оны улсын төсвийг хэлэлцэхэд Улаанбаатар Даланзадгад чиглэлийн замын их засварыг Дэлхийн банкны 100 сая амдолларын зээлийн хэрэгцээнд хийхээр ЗТХЯ-наас мэдэгдэж байсан боловч энэ төсөлд тусгагдаагүй

байгаа талаар асуулт асууж хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд хэлэлцээрийн төслийн өрийн дээд хязгаарт багтсан байдал, ач холбогдлыг харгалзан үзээд дэмжиж байгаагаа илэрхийлэн урьд нь авч байсан гаднын зээлийн талаарх асуудлыг байнгын хорооны хуралдаанаар зөвшилцөх үед Засгийн газарт тодорхой үүрэг чиглэл өгдөг байсан боловч энэ удаагийнх шиг төслөө сайжруулж өөрчилж ирдэг нь ховор байсныг дурдаад цаашид төслийг эцэслэн батлахаас өмнө Байнгын хорооноос өгсөн үүрэг чиглэлийн биелэлтийг сонсдог байх нь зүйтэй бөгөөд зөв хандлага ахиц гарч байгааг тэмдэглэсэн болно оо.

Монгол Улс Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах нь зүйтэй гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төслийн хэлэлцээр зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Баярлалаа.

Г.Занданшатар: Хэлэлцээрийг соёрхон батлахад нийт гишүүдийн

олонхоор буюу 39-өөс дээш гишүүн батална.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Дашдондогийн Ганбат гишүүнээр тасаллаа. Норовын Алтанхуяг гишүүн асуулт асууна.

Н.Алтанхуяг: Өглөөний амгаланг айлтгая энэ гадаадаас 110 сая доллар авна гээд л нэлээн удаан ярьсан юм аа. Тэгээд өнөөдөр Байнгын хороо дэмжээд ороод ирлээ. Би Байнгын хороон дээр эсрэг байр суурьтай учраас ороогүй ээ. Надад ийм асуулт байна. Зам тээвэртэй холбоотой, нөгөөдөх нь энэ өртэй холбоотой.

Нэгдүгээр асуулт бол энэ бол төгрөг рүү шилжүүлбэл 380 гаруй тэрбум төгрөг төгрөг юм байна. Тэгээд дөнгөж сая төсөв баталсан байдаг. Энийг төсөв дотроо тавиад шийдчихгүй яасан юм. Их Хурлын гишүүдийн мөнгө гээд 200, 300 тэрбум төгрөг ингээд л тавьсан шүү дээ. Тэгээд ингээд айлаас дахиад зээл авч энэ зам засна гэдэг ийм асуудал утгагүй. Энэ сонгууль болтол та нар ийм юм хиймээргүй л байна. Өр нэммээргүй байна. Би дотор нь зүгээр жижиглээд асуучихъя. 51 км орон нутгийн зам гэж алийг хэлж байгаа юм тэрийгээ нэг тодорхой хэлээдэх. Одоо байна шүү дээ энэ Бямбацогт сайд аа, энэ танай засаг, энэ Ардын намд ер нь бодлого гэдэг юм алга болж дээ. Одоо уг нь аймгийн төвүүдийгээ холбочихсон юм чинь дараачийн ээлжид аймгийн төвийг хилийн боомттой холбох ёстой. Би үндсэн гарсан бичиг баримтыг ярьж байна шүү. 2010 оны Их Хурлын хөтөлбөрийг ярьж байна.

Дараа нь аймгийнхаа төвүүдийг холбомоор байна шүү дээ. Тэр Баян-Өлгий, Ховд 2-ыг холбогдохсон юм. Увс юу байна нөгөө аймгуудаа хоорондоо

холбооч дээ. Аймгийн төв нөгөө хүн ихтэй газруудаа хоорондоо холбооч дээ.

3 дугаарт нь хэвтээ тэнхлэгийнхээ 2 замыг хойгуур явсан зам, урдуур явсан 2 замыгаа хаагуур нь ч байдаг юм зохимжтой газраар нь холбооч. Бодлогын бичиг баримт чинь ингээд гарчихсан байхад сум руу зам тавиад л дахиад явчихсан замын хажуугаар давхар зам тавиад яасан их мөнгөтэй айл вэ. Тэгээд яагаад айлаас зээл авч энийгээ хийх гээд байгаа юм. Өмнөговь, Дундговийн зам гээд арайхийж нэг зам боссон чинь том тээврийн машинаар нүүрс тээвэрлүүлсээр байгаад ингээд будаа болгоод хаячихсан. Одоо тэгээд тэрнийгээ засах гээд айлаас зээл авна. Ингэж болохгүй ээ засаж болно. Та нар байна шүү дээ айлаас битгий зээл ав.

Өөрийнхөө энд асар их хэмжээний төсөв баталсан шүү дээ энэ Жавхлан чинь. Энэ мөнгө энэ айл шүү дээ энэ айл жаахан юмаа арвилан хэмнээч дээ. Үгүй ээ арвилдаггүй юм гэхэд үрэлгэн байдлаа алга болгооч дээ.

2 дахь асуулт нь бол малчид тэр дундаа эмэгтэй удирдлагатай малчдад платформд оролцох цахим хэрэгсэл, ур чадвар, мэдлэгээр дэмжинэ. Болиоч ээ энэ юу гэсэн үг юм? Одоо байнгын хороон дээр энийг ярьчаад ингэсэн. Анхаарууллаа гэнэ Энхболдоо бас боль л доо. Энэ залуучуудыг битгий ингээд бай. Анхааруулснаар тэр өөрчлөгддөг юм уу, өөрчлөгддөггүй байхгүй юу. Тэгээд тэр бичиг цаас чинь өөрчлөгдөхгүй явна.

Гурав дахь нь надад задаргаагаа хэл. Яг хаанахын ямар ямар замуудын хэдэн километрийг ямар мөнгөөр засах гээд байгаа юм? Одоо энэ нэгэнт далан тавьчихсан газар дээд талыг засах бол мөнгө бага орно шүү дээ.

Өрийн хязгаар өнөөдөр Сангийн яамны тарааснаар 224 хувь болчихоод байгаа ДНБ-ий. Энэнийг өрийн хязгаар

дотор багтаж байна гээд л худлаа хэлээд л, худлаа хэлээд л яваад байх юм. Энэ Жавхлан юу ер нь байхгүй Хүрэлбаатар хоёр. Ийм ийм юмаа та нар маань бас нэг үгүй ээ бид нар чинь нэг айлын нэг улсын иргэд биз дээ. Энэ улсын мөнгө төгрөг одоо өнөөдөр хар л даа шатахуун, өнөөдөр хар л даа цахилгаан. Үгүй ээ нэг номерын асуудалдаа мөнгөө өгдөг шүү дээ тэ.

Яагаад ингээд 1 дүгээрт нь бичигдэх асуудлыг 77-д нь биччихээд, тэр 77 дахь асуудлыг нэгд нь авчирч мөнгө өгөөд байдаг юм бэ? Нэг ийм ийм юмаа нэг хий л дээ. Одоо би хэлсээр байгаад сүүлдээ манай нутагт бол муутан боллоо. Намайг битгий олон юм ярьдаг болсон хүн ганцхан чи л орилох юм болиоч дээ гээд.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт сайд хариулна.

С.Бямбацогт: Алтанхуяг гишүүний асуултад хариулъя.

Төсөв дээр тавихгүй яасан бэ гэж. Төсөв дээр бид нар шинэ замууд барих нэлээн мөнгө тавьсан. Бас уул нь яах вэ төсөв хэлэлцэж байх үед бид энэ замуудын засварт бас мөнгө тавимаар байна гэдэг асуудал нэлээн ярьсан боловч бас төсвийн бололцоо боломж байхгүй гээд тавигдаагүй. Энэ жилийн төсвийн онцлог Монгол Улсын ерөнхий сайд 21 аймгаараа тойрч ажилласан, иргэдийн санал бодлыг сонссон. Их Хурлын гишүүдийн саналууд голцуу тусгагдсан. Салбарын яамдын бодлого бас харьцангуй их бага туссан. Бид нар зам барих 30 жил зам барьсан. 30 жил зам бариад бид нар үндсэндээ 21 аймгаа Улаанбаатар хоттой ямар ч байсан хатуу хучилттай замаар холбосон. Тэгтэл 20 жилийн өмнөх замууд 30 жилийн өмнөх замууд маань эвдрээд эхэлсэн. Энэ эвдэрч байгаа замуудыг засахад бас нэлээд их хөрөнгө хэрэгтэй.

Урсгал засварт нь жил болгон бид нар бас авто замын сангаас 50 орчим тэрбум төгрөг тавьдаг. Тэрүүгээр бид нар зөвхөн замын нөхөөс хийдэг. 10 жил хүртэл хугацаанд 5-аас 10 жил болоод бид нар ээлжит засвар хийх ёстой. 10 жилээс дээш хугацаанд бид нар их засвар хийх ёстой. Гэтэл их засвар ээлжит засварт ерөөсөө түүхэндээ мөнгө тавьж байгаагүй юм байна лээ.

2023 онд бид нар 35 тэрбум төгрөг тавьсан тэрүүгээр Хэнтий чиглэлийн, Дундговь чиглэлийн замууд дээр нэг жоохон тав, аравхан километр зам зассан. Ингээд цаашидаа бол өмнө нь байсан 20 жилийн өмнөх, 30 жилийн өмнөх замуудаа засах ийм шаардлагатай болсон учраас энийг тодорхой хэсгийг нь Дэлхийн банкны 100 сая доллароор санхүүжүүлж засъя гэдэг асуудлыг 2020 оноос ингээж ярьсаар байгаад үндсэндээ шийдэгдэж байгаа юм. Үлдсэн хэсгийг нь бас зайлшгүй засах шаардлагатай байгаа. Ер нь замын их засварт нэг их засварт 1 их наяд төгрөг хэрэгтэй байгаа. Өмнө нь барьчихсан замуудыг засахад 1 их наяд.

Гэтэл энэ жил бид нар төсөв дээр мөнгө тавиагүй. Одоо ганцхан энэ замуудын их засварт энэ саяын орж ирж байгаа энэ 100 сая доллар буюу энэ 360, 370 орчим тэрбум төгрөг л тавигдаж байгаа юм аа. Энэ замуудын өртөг ямархуу өртөгтэй байна вэ гэдэг дээр авто замын их засвар хийгдэх нь 236 км замын их засвар хийгдэнэ. Нэгж өртөг нь 293 мянган ам доллар буюу нийт 69 сая доллар энд зарцуулагдана. Авто замын ээлжит засварт 125 км зам ээлжит засвар хийгдэнэ. Үндсэндээ 5-аас 10 жил хүртэл настай зам гэсэн үг. Энэ дээр 110 мянган доллар 1 километрийнх нь өртөг. Энэ 13 сая доллар гүүрний засварт 1200 метр гүүрийг 7400 доллар 1 метрийнх нь урт нь. Ингээд 8, 9 сая доллар. Орон нутгийн зам гээд түрүүн та асуусан 51км зам хаана баригдах вэ гэдэг. Архангай аймгийн Булган сум, Өвөрхангай аймгийн Хужирт байх аймгийн 2 сумд нутгийн зам

хөтөлбөрийнх нь сум холбох зам тавигдах юм. Энд нь 11 сая доллар. Тэгээд ийм байдлаар үндсэндээ хуваарилагдсан байгаа.

Засгийн газраас бас цаашидаа ер нь бас бид нар энэ 21 аймгаа бас 20 жилийн хугацаанд мянганы зам бүтээн байгуулалт хийгээд холболоо. Энд бас Алтанхуягийн Засгийн газрын үед бас нэлээд их ажил хийгдсэн. Бас нэлээн эрчимтэй явагдсан. Ингээд холбоод дууссан. Одоо цаашидаа бид нар Монгол Улсаа Ази, Европ, Орос, Хятадыг холбосон 5 босоо замтай болгох. Урьд нь 70 жилийн хугацаанд бид нар Алтанбулаг, Улаанбаатар, Замын-Үүд ганц замтай байсан.

Өнгөрсөн жил бид нар Цагааннуур, Ховд, Булган гэсэн 2 дахь босоо замаа нээсэн. Цаашидаа бид нар Завханыг, Говь-Алтайг Орос, Хятадтай холбох, Булган аймаг, Өвөрхангай аймгийг Өмнөговьор ингээд холбоод Орос, Хятадтай холбох, мөн бас зүүн талдаа Дорнод, Сүхбаатарыг, Орос, Хятадтай холбох ийм авто замууд барьж байгуулна. Ийм байдлаар үндсэн 5 босоо зам. Нөгөө талдаа бид нар Дорнодын Халх голоос Баян-Өлгий энэ Цагаан нуур хүртэл тийм Улаанбаатараар дайрахгүй нэвт яваад ингээд очих ийм хэвтээ тэнхлэгийн, Хэнтийн Ульхнаас Дадал сумаас Ховдын Булган сум хүртэл тийм Улаанбаатар дайрахгүй явах ийм тийм хэвтээ тэнхлэгийн ийм замууд барина.

Энэ хүрээндээ үндсэндээ бол аймгуудыг хооронд нь холбох таны сая ярьж байгаа Улаангом, Ховдыг холбох зам жишээ нь 2024 онд эхэлнэ. Завхан Улиастайг холбох зам бас 2024 онд эхэлнэ. Мөн одоо бас Сайншандаас Улаанбаатараар дайрахгүйгээр Чойр, Дундговь, Өвөрхангай гээд баруун аймгуудаар явдаг болох ийм бас бүтээн байгуулалтын ажил ирэх онд эхлэхээр ингээж төсөв дээр хөрөнгө оруулалтууд тавьсан байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах уу, Нэмж хариулах юм уу тэ. Бямбасүрэнгийн Энх-Амгалан Байнгын хороон дарга нэмж хариулъя.

Б.Энх-Амгалан: Алтанхуяг гишүүний асуултад нэмж хариулъя.

Энэ төсөлтэй холбоотойгоор Төсвийн байнгын хороо дээр нь бол Эдийн засгийн байнгын хороо санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлсэн. Энэ төсөл 2 удаа буцсан. Нэг удаад нь болм Засгийн газрын гишүүд саналаа нэгтгэлгүй орж ирж байж нэг буцсан. Та санаж байгаа байх. Хоёр дахь удаад нь бид нар бол энэ Байнгын хороодын бүх саналыг нэгтгээд 9 ширхэг чиглэл өгсөн гэрээнд тусгах. Тэрний 6 дээр бол энэ эмэгтэй малчдын платформд оролцох үйл ажиллагааг сургалтыг дэмжих гэсэн нэг ийм зүйл заалт байсан. Тэгээд энийг бол хас чиглэл өгсөн. Энэний дагуу төслийг хууль санаачлагч хасаж оруулж ирсэн. Тэгээд өчигдрийн хурал дээр энийг тодруулж асуугаад хассан шүү гэдгийг тодорхойлоод ингэж орж ирж байгаа гэдгийг бас энэ дээр хэлье.

Хоёр дахь нь Засгийн газрын өрийн тухай хуулийн төсвийн тусгай шаргалд нийцүүлэх ёстой гэдэг зүйлийг 8, 9 дүгээр зүйлээрээ өгсөн. Ам.долларын хани блд 21.5 хувиар суларсан энэ үед цаашидаа өрийн дарамт нэмэгдэх вий энийг онцгой анхаар гэсэн. Энийг бол яг энэ нөхцөлд нийцүүлж оруулж ирсэн гэдгийг Засгийн газрын гишүүн хэлсэн. Эдийн засгийн үр ашиг, өгөөжийг сайжруулж тооцох ёстой зураг төсөл, ТЭЗҮ-ээ нарийвчилж хийх ёстой гэдэг бүх зүйлүүдийг хэлээд энэ бүх зүйлүүд хангагдсан гэдэг үндэслэлээр өчигдөр Байнгын хороон дээр дэмжсэн.

Таны хэлж байгаа тэр өмнө Өмнөговийн чиглэлийн зам бол бас үнэн. 2018 онд энэ зам дээр 7.4 тэрбум

төгрөгөөр засвар хийгдсэн, 2019 онд 9.3 тэрбум төгрөгөөр засвар хийгдсэн. Одоо дахиад энэ зам эргээд уначихсан дахиад засвар хийх шаардлагатай гээд тэр нутгаас сонгогдсон гишүүн нь санал тавьсан. Яагаад гэвэл энд нөгөө медлинг гээд утаагүй түлшний нүүрс зөөж байгаа учраас хүнд даацын автомашин явдаг Засгийн газрын тогтоолтой энэнээсээ болоод эвдрээд байгаа гэдгийг бас энэ хуралдаан дээр хэлсэн. Энэ дээр бол дараагийн санхүүжилт дээр энэ дотор хэлэлцээрт орохдоо бас Зам, тээврийн яам анхаарч үзье ээ гэдэг ийм асуудал ярьсан гэдгийг танд хэлье ээ.

Л.Мөнхбаатар: Норовын Алтанхуяг гишүүн тодруулж асууя.

Н.Алтанхуяг: Би энэ үрэлгэн зардлаа багасгаад мөнгө төгрөгөө жаахан хэмнээд энэ ард түмний ахуй амьжиргаанд наалдацтай юм руугаа жаахан анхаараач ээ л гэж хэлж байгаа юм. Өчигдөр би Байнгын хорооны хуралд ороод бүртгүүлчихсэн шүү дээ Энх-Амгалан дарга аа. Тэгэхдээ би өрөөнөөсөө Байнгын хорооны хуралд оролцсон.

Яагаад гэхлээр Монгол Улсын гадаад өрийг би шууд нэмэгдүүлээд баймааргүй байна гэдэг агуулгаар ирцийг чинь бүрдүүлээд өрөөнөөсөө би хуралд оролцсон. Тэр хурал дээр чинь юу гэж ярьсан гэхээр малчид тэр дундаа эмэгтэй удирдлагатай малчдад платформд оролцох цахим хэрэгсэл ур чадвар юун авто зам болж байсан юун малчин эмэгтэй болоод явчхав аа. Энд бас гадаадын зээл тусламж аваад хэдэн малчин эмэгтэйчүүдийг яана ч гэнэ вэ? Энийг хасаагүй байхгүй юу. Одоо надад байгаа төсөл дээр хассан юм уу? Та нар яг хэл хассан юм уу, хасаагүй юм уу? Өчигдөр хасаагүй байсан. Хасах гээд байгаа юм уу эсвэл хасахгүйгээр ингээд явах гээд байгаа юм уу? Ер нь Их Хурал жаахан ингээд эрхээ авмаар байх юм.

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя Алтанхуяг гишүүний. Хэн хариулах юм? Сангийн яамны төлөөлөлд хариулт хэлье. Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье.

С.Тулга: Сангийн яамны хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Тулга гишүүний асуултад хариулъя аа. Байнгын хорооноос өгсөн чиглэлээр бол эмэгтэй малчдад сургалт зохион байгуулах гэдэг энэ агуулгыг хас гэсэн байгаа. Дэлхийн банктэй Зам, тээврийн яамнаас, Сангийн яамнаас хийсэн хэлэлцээрээр Байнгын хорооноос ийм чиглэл өгсөн тулд энийг хасъя гэдэг санал дэвшүүлсэн. Тэгээд Дэлхийн банкнаас болохлоор хүйсийн тэгш оролцоог хангах нь зээлдэгч байгууллагын өөрийн дүрэмд байдаг учраас тэр эмэгтэй малчдад сургалт зохион байгуулах гэдэг хэсгийн оронд ложистикийн байгууллагад болон малчид тэр дундаа эмэгтэй малчдад платформд оролцох цахим хэрэгсэл ур чадварыг мэдлэгээр дэмжих энэ агуулгаар оруулсан байгаа.

Тэр эмэгтэй малчдад сургалт гэдэг хэсэг нь хасагдсан.

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай юу Алтанхуяг гишүүн ээ. Алтанхуяг гишүүн тодруулж асууя.

Н.Алтанхуяг: Нэг иймэрхүү л байдалтай бид нар ажиллаад байгаа байхгүй юу даа. Би түрүүн дутуу хэлчихлээ. Энх-Амгалан гишүүн та нэг дарга царайлаад л, Байнгын хорооны дарга би нэг гишүүн царайлаад л ийм л байхгүй юу. Хаа байгаа юм бид нар нөгөө нэг хууль тогтоож байгаа. Засаг дураараа л дургиж байгаа биз дээ. Бид нарын толгойд хумьж боогоод л ингэчихсэн, тэгчихсэн. Бодитойгоороо хийгээгүй байхгүй юу.

Хоёрдугаарт энэ сангийн яамныхан яг одоо хариулаадах. Танай Сангийн яамны тараасан Их Хурлын

гишүүд тараасан цааснаас би асууж байна. Өнөөдөр ДНБ-д гадаад өрөө эзэлж байгаа хувь 224 хувь байгаа. Танай сайд чинь үргэлж энийг болж байгаа гэдэг тоо хэлээд байгаа. Би үнэн хэлээд байна уу, танай сайд үнэн хэлээд байна уу? Эсвэл чи яг энэ тоо хэд болчихсон юм хэлээдэх. Одоо энэ Их Хурал дээр дандаа худлаа ярьдаг боллоо шүү дээ энэ чинь. Худлаа ярьчихаад тэгээд гараад алга болчихдог. Энэ чинь эд нарын энэ Жавхлангийн, Хүрэлбаатарын асуудал биш энэ Монгол Улсын Монголын ард түмний.

Л.Мөнхбаатар: Асуултад нь хариулъя. Би би үнэн хэлээд байна уу? Танай сайд үнэн хэлээд байна уу гэхээр сайд л үнэн хэлсэн болж таарах байх даа. Ажлын хэсэг хариулъя. Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье.

С.Тулга: 2023 оны 3 дугаар улирлын байдлаар өрийн статистикийн тоо гарсан байгаа. Энэ дээр ДНБ-д эзлэх Засгийн газрын өрийн хэмжээ 44.3 хувьтай байгаа. Улсын нийт гадаад өрийн хэмжээ 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 195 хувьтай байгаа. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-Т өрийн хязгаар байдаг тэр хязгаар нь болохлоор Засгийн газрын гадаад өрийн хязгаар.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшин, Борхүүгийн Дэлгэрсайхан нарын урилгаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Төмөр замын татах хэсгийн удирдлага инженер техникийн ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүгдийн ажил хөдөлмөрт өндөр амжилт, сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе өө.

Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар асуултаа асууя.

С.Ганбаатар: Энэ олонхоороо соёрхон батлаад явчих байх аа. Зам засна

гэдэг буруу нь юу байх вэ? Гэхдээ тодруулж асуух зүйлүүд хэд байна аа? Ер нь чөтгөр тэгээд л деталь дотор л нуугдаж байдаг юм даа. Бэлгийн морины шүдийг үзэхгүй гээд л хэдүүлээ ч ингээд л давхиад л байдаг. Зээл аваад л яваад байдаг. 25 жилийн дараа Монголын хүүхдүүд Монголын үр хойч биднийг хараах вий дээ. Тэгээд энэ дээр ийм байгаа л даа. Төсөл хэрэгжүүлэгч хугацаа бол 2026 онд гэж байна 4 жил. Зүгээр эргэн төлөлт энэ 100 сая, 7.3 сая зээлжих эрх олон улсын ассоциациас, олон улсын банкнаас олон улсын банк санхүүгийн байгууллагуудаас бол 100 сая. 110-аад сая доллар. Хүү нь сопер дээр нэмэх нь 1.3 хувь хувьсах хүү гэж байгаа юм. Тооцвол 5.35 хувь дээр нэмэх нь 1.3 хувь гэж би ойлголоо. Одоо хэдүүлээ тооцоогоо нягталъя. Энэ чинь одоо зүгээр нэг бэлгэ э гэж бодож андуурав та нар. Бэлгийн морины шүд үзэхгүй гэж нүдний булай болов оо. 6.63 хувийн хүүтэй байна. Миний бодлоор тооцоогоо нийлнэ шүү. Хэдүүлээ 6.63 хувийн хүүтэй юм бол 25 жилийн дараа эргэн төлөгдөнө. 5 жил нь үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөж байгаа юм байна. Үгүй ээ мөн харж үзэж байна аа. Үгүй ээ мөн сайхан юм аа.

Тэгэхээр энэ 25 жилийн дараа яг хэдэн төгрөг Монголын ард түмэн Монголын хүүхдүүд төлөх вэ? Би тооцоогоо гаргачихсан. Одоо хэдүүлээ мөргүүлъя. 110 сая доллар хэдэн сая доллар болж буцаж төлөгдөх вэ? Үр хойчийн маань нуруун дээр хэдэн төгрөг болох вэ? 1 дүгээр асуулт.

Тооцоогоо нийлүүлъя.

Хоёрдугаарт тэр зээлжих зэрэглэлийн хүү байна шүү дээ. Хүүгээс хүү бодох уу? Компанид брэд гэж яриад байгаа тэр нь үү зүгээр жирийн хүүлэх юм уу? Яаж хүүлүүлэхээ бас мэдье л дээ хэдүүлээ. Энэ дээр яг тодорхой хариулна шүү. Би бас энэ Англи хэлтэй нь тулгаад байж байна. Яагаад ингэж асуугаад байгаа вэ гэвэл үгүй ээ та нар бод доо.

Засгийн газрын 2013 оны 56 дугаар тэмдэглэл ингээд бас Засгийн газар, Ерөнхий сайдын захирамж. Зээлийн санал 4 Байнгын хороогоор орсон байгаа юм. 6 яамны сайдын үзэл баримтлал зэрэг нарийн маш баримт бичгээр баталгаажуулсан. Шат дарааллаар орсон. Олон олон цалин авдаг хүмүүс харсан байж таараа. Миний асуулт ингэх гээд байна л даа.

Зээлийн хэлэлцээрийн зүйл 2 дугаар зээл 2.5-д байж байгаа юм. Хуудас нэг шүү. Тэрэн дотор 2.05 гэж байна. Хүүгийн хэмжээ нь лавлах суурь хүү дээр хувьсах хүүг нэмсэнтэй тэнцүү байх буюу ерөнхий нөхцөлийн 3.02 е гэж байгаа. Хаалт дотор Е хэсэгт заасны дагуу хөрвүүлсний дараа ашиглаж болох хувь хэмжээ байна гэжээ. Гэтэл 3.02 е гэдэг энэ хэсэг нь зээлийн хэлэлцээрийн монгол англи хувилбарт байхгүй байна. Надад ингэж өгсөн үү энэ олон яамдуудаар явахдаа алга болчихсон уу? Энийг хариулж өгөөч ээ. Би дахиж хэлэх үү үгүй юу ойлгосон уу.

3.02 е гэдэг дотор зээлийн хүүгийн талаар хувь хэмжээг нарийвчлаад заачихсан гэсэн. Энэ заалт нь 2 хувилбар дээр англи, монгол дээр хоёулан дээр нь алга байна. Миний цаасан дээр ийм байна уу? Таных дээр ийм байна уу?

Тэгэхээр 2 дугаар асуулт. Яах вэ уг нь мөнгө олдог зээл аваад хийчихлээр маргаашаас нь ашигтай ажиллаад мөнгө олдог салбар луу оруулъя л гэж нэг жанжин шугам бариад байгаа ухаантай шүү дээ. Тэгсэн тэгээд л тэгээд л хэдүүлээ тэгээд л зарлага руугаа л явуулж байна. Ядарч байна даа Монгол Улс. Тэгэхээр зээлийн мөнгө шууд олдог төсөлд үйлдвэр тэр байгууллагад гарсан бол үгүй ээ мөн сайн байсан.

Л.Мөнхбаатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Хэн хариулах вэ? Сандагийн Бямбацогт сайд хариулъя. Ажлын хэсэг нэмж хариулж болно.

С.Бямбацогт: *Зээл бид нар энэ олон зээлээр л замууд барьж байгаа л даа. Улсын төсвөөс ч зам барьж байгаа. Гаднын зээл тусламжаар ч зам барьж байгаа. Одоо хамгийн сайн хэрэгжиж байгаа төсөл гэж хэлэх юм бол би сая түрүүн хэлсэн. Баруун босоо зам 750 км замыг бид нар Азийн хөгжлийн банкны зээлээр бариад дуусаад ашиглалтад оруулсан. Энэ ОХУ, Хятад улстай Монгол Улсаар дайруулаад Баян-Өлгий Ховд аймгийн нутгаар дайруулаад ингээд холбочихсон зам. Энэ зам дээгүүр Монголын иргэн болгон одоо очиж зорчсон иргэн болгон энэ шиг сайхан зам тавих юм юмсан энэн шиг зам хэрэгтэй байна гэж л ярьж байгаа юм л даа.*

Өнөөдөр гэнэтхэн бид нар өнөөдөр гэнэт зээлээр зам барих гээгүй. Ийм байдлаар Дэлхийн банкнаас, Азийн хөгжлийн банкнаас Европын сэргээн босголтын банкнаас зээл аваад замууд бариад л байгаа. Дарханы зам байж байгаа, Дарханы зам дээр, бид нар Европын сэргээн босголтын банкнаас Азийн хөгжлийн банкнаас бас зээл аваад л энэ замыг барьж байгаа. Улсын төсөвт мөнгө гарахгүй байгаа шүү дээ. Тэгээд ингээд л үндсэндээ ингээд урьд нь явж байсан жишигийн дагуу л барьж байгаа. Улсын төсөвт мөнгөний хүрэлцээ байхгүй байгаа учраас бид нар энэ Дэлхийн банкны 2020 оноос хойш яригдсан юм байна лээ. 2018 оноос хойш яригдсан тийм байна лээ.

Ингээд л зам тавьж байгаа. Энэ замуудын зээлийн хүү бол иймэрхүү л жишигтэй урьд нь тавьж байгаа замуудын бас зээлийн хүүнүүд яг энэ жишигээр. Урьд нь бас Монголд зам тавьж байгаа замуудын жишиг үүнээс нэг их өөр болсон юм байхгүй ээ. Тийм болохоор та бүхэн бас энийг зөв ойлгооч ээ. Зам засахад одоо түрүүн хэллээ. Яах аргагүй баруун чиглэлдээ явж байгаа

аймгууд руу энэ Лунгийн гүүр нураад уначих юм бол баруун аймагууд юм уу арваад аймаг Булган, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Увс, Ховд, Баян-Өлгий, Завхан гээд энэ аймагууд чинь бүгд ерөөсөө зорчиж чадахаа больчихно. Үндсэндээ ийм байдалд орчихсон байгаа. Энийг шийдэхэд бидэнд мөнгө байхгүй. Яг хэрвээ энэ нурчих юм бол тэрнээсээ эссэн юм болно. Гэх мэтийн ач холбогдолтой. зүүн талдаа бид нар Дорнодын тамын 50 гэж олон хүний амь нас авсан энэ замыг зайлиггүй засах шаардлагатай байх. Хэнтий, Сүхбаатар аймгийн хооронд байдаг, Дорнод аймгуудын хооронд хойшоогоо бид нар тэр бүх хүн болгон мэддэг Түлүүгн даваа гээд. Энд бас л Булган, Хөвсгөл аймгийнхан маш их зорчдог. Энэ замуудыг засах шаардлагатай л байгаа юм л даа.

Тийм л агуулгаар авч байгаа юм. Урьд нь явж байсан жишигийн дагуу яаж байгаа гэдгийг хэлье танд бас.

Тэр ерөнхий нарийвчилсан асуултуудад Сангийн яам тэгээд тэр зээлийн хүүнүүд тэр юунууд дээр нь нарийвчлаад хариулчих уу?

Л.Мөнхбаатар: *Ажлын хэсгээс нэмж хариулъя. Тулга дарга хариулах уу? Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье.*

С.Тулга: *Ганбаатар гишүүний асуултад хариулъя аа.*

Ганбаатар гишүүний эхний асуулт хүүгээс хүү тооцох уу гэсэн. Хүүгээс хүү тооцохгүй байгаа. Энэ зээл маань 2 эх үүсвэрээс байгаа 100 сая амдоллар маань болохлоор олон улсын сэргээн босолт хөгжлийн банкнаас, олон улсын хөгжлийн ассоциациас 7.3 сая зээлжих зэрэглэлийн тусгай эрх буюу энэ нь болохлоор ам.доллартой харьцуулах юм бол 10 сая орчим амдоллар байгаа юм. Эргэн төлөлтийн хувьд 25 жилийн хугацаанд эргэн төлнө. Эхний 5 жил бол үнэ үндсэн

төлбөрөөс чөлөөлөгдөхөөр байгаа. Хүүгийн хувьд болохоор олон улсын сэргээн босголт хөгжлийн банкнаас авч байгаа энэ сопер дээр нэмэх нь 1.3 энэ нь болохлоор хөвөгч хүү юм. Тэгэхлээр хөвөгч хүү сопер юунаас хамгаалж байна гэхлээр АНУ-ын федиин бодлогын хүүнээс хамаарч байгаа учраас өнөөдөр 5.3 хувьтай байгаа. 2022 оны 3 сард болохлоор сопер энэ хөвөгч хүү нь бараг 0-тэй тэнцэж байсан үе байдаг учраас яг өнөөдрийн байдлаар энэ нь ингээд тогтмол хүү мэт зогсоод 30 жилийн дараа бид нар тэдийг төлөх вэ гэж тооцох нь болохлоор бас жоохон учир дутагдалтай байгаа 7.3 сая зээлжих тусгай эрхий хувьд бол энэ тогтмол хүүтэй. Энэ нь болохлоор 2 хувийн хүүтэй ийм ийм байгаа. 25 жилийн дараа харин яг өнөөдрөөр ингээд тогтоно гэсэн ийм байгаа ассампшн авч шууд тооцох бас боломжгүй байгаа юм аа гишүүн ээ. Энэ хөвөгч хүү учраас. 2024 оноос бол АНУ-ын бодлогын хүү буурах хандлагатай гэсэн шинжээчдийн дүгнэлт байгаа.

Тэгэхээр яг энэ ингээд тогтоно гэсэн үг биш.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл, Ганибалын Амартүвшин, Тогмидын Доржханд нарын урилгаар Хан-Уул дүүргийн 10, 19 дүгээр хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил амьдралд нь хамгийн сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе өө.

Та тодруулах юм уу? Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Ерөнхийдөө ард иргэдэд бас тодорхой байх ёстой. Оюу Толгой дээр компанд рейд гэж бүүр

хамгийн зэрлэг улс орныг эзэлдэг хүүгээс хүү боддог рэйд байсан. Энд бас харж үзсэн байна хөвөгч хүү. Тэгээд тодорхой байхгүй бол болохгүй ээ. Яг одоогийн байдлаар бол 110 сая бол 140 сая буюу одоо бид үндсэндээ 250 саяыг өнөөдрийн байдлаар зүгээр хөвөгч хүүгээр бодож ингэж төлнө гэсэн үг шүү. Энэ маш их мөнгө шүү дээ. Зам засахад засалгүй л яах вэ. Дээр нь нэмээд та нар Лайбер гэдэг нөгөө Оюу Толгой дээр авсан хүү чинь яг авч байх үедээ нэг хувь байсан. Энэ өөрчлөгддөг юм гээд л бултаад байсан. Тэгсэн одоо 8 байж байгаад харин буугаад 6.3 болсон байгаа. Нийт хүү нь үндсэндээ 8 болчихсон. Биднийг зүгээр хүүлж алж байгаа шүү дээ.

Тэгэхлээр би тодруулж асуух гээд байгаа юм гэвэл миний тэр 3.02 е гэдэг юм байна уу байхгүй юу. Та нар хариулсангүй.

Хоёр гэрээний хаана нь байгаа юм бэ? Би тодорхой ярьсан шүү.

Хоёрдугаарт та нар түрүүн тэр Алтанхуяг гишүүний асуулт минийхтэй давхардсан учраас та нарыг хариулах болов уу гээд хараад байсан. Тэр яг маршрут руу нь хэлээд өг л дөө. Зам засварын маршрут нь одоо Улаанбаатар, Арвайхээр, Хархорин, Цэцэрлэг, Цэцэрлэг, Тосонцэнгэл гээд тэрийг нь Монголын ард түмэн өнөөдөр сонсохыг хүсэж байгаа шүү дээ. Энийг нь дэлгэрэнгүй яриад өг.

Гуравдугаарт миний асуулт. Мөнгө олдог, мөнгө олдог замууд дээрээ эхэлж энэ засвар мөнгө энэ гаднаас зээлтэй сүүлд нь бидний гогдох мөнгийг мөнгө олдог замууд дээрээ эхлээд яг чухалчлал хийж тавьсан уу. Мөнгө арай бага олдог замууд дээр 2 дугаарт тавьсан уу гэдэг энэ чинь бидний хөрөнгө оруулалтын, гаднын зээл, тусламжийн хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн бодлого дотор байдаг зүйл шүү дээ. Энэ чухалчлалуудаа хэр хийсэн юм бэ? Энэ яг одоо.

Л.Мөнхбаатар: Ганбаатар гишүүний тодруулгад хариулъя. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 84 дүгээр микрофоныг өгье. Нэр албан тушаалаа хэлээд хариулаарай.

Ц.Эрдэнэ-Очир: Ганбаатар гишүүний асуултад хариулъя аа.

Үндсэндээ энэ эдийн засгийн үр өгөөжийн хувьд хамгийн шаардлагатай байсан замууд уу гэж асууж байна. Үнэхээр тийм. Энэ замууд маань үндсэндээ 20-оос 30 жил болчихсон. Хамгийн ард иргэдийн маань хамгийн өндөр зорчдог замууд байгаа юм аа. Тэгээд энэ замууд маань үндсэндээ урсгал зарцуулалт арчлалтын хүрээнд засварлаад бэлэн байдлыг хангах боломжгүй нөхцөл байдал үүссэн учраас тухайн замуудын хамгийн өндөр туршилт судалгаагаар, үнэлгээгээр гарчихсан хамгийн өндөр эвдрэлтэй, насжилт нь өндөр болсон замууд дээр бид нар ээлжит болон их засварын ажлуудыг хийхээр төлөвлөчихсөн байгаа юм.

Тухайлбал Улаанбаатар-Арвайхээр чиглэл дээр ээлжит засвар 72 км-т, их засварын 33 км-т байгаа юм. Улаанбаатараас-Өндөрхаан чиглэлд 68 км байгаа. Цаашаа Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50 км замыг түрүүний дурдаад.

Л.Мөнхбаатар: Болчихсон уу? Сангийн яамны төлөөлөл нэмээд хариулчихъя. Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье.

С.Тулга: Энэ нь болохоор зээлийн хэлэлцээрт Дэлхийн банкны нөхцөл женерал кондшин гэсэн зүйлчлэл байдаг. Энэ нь болохлоор зээлжихэд бүх улсад тавигддаг ерөнхий нөхцөл байгаа. Энэ санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн 3 дугаар хавсралтад энийг дурдсан байгаа. Ерөнхий нөхцөл гэж 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн өдрийн олон улсын хөгжлийн ассоциацийн санхүүжилт болон хөрөнгө оруулалтын төслийн

санхүүжилтэд хамаарах олон улсын хөгжлийн ассоциацийн ерөнхий нөхцөлийг хэлнэ ээ гээд зүйлдээ заачихсан байгаа.

Энэ яах вэ нөгөө нэг ерөнхий бүх зээлдэгчид тавьдаг ерөнхий нөхцөл учраас энийг зүгээр зүйлчлээд заачихсан байгаа. Тэгээд Ганбаатар гишүүн энийг ингэж заасан ч гэсэн ерөнхийдөө түрүүн миний хэлсэн зээлийн хүү энэ нөхцөлүүд яг сопер дээр нэмэх нь 1.3 тэгээд нөгөөдөх нь болохлоор 2 хувийн тогтмол хүүтэй энэ дээр ямар ч өөрчлөлт байхгүй. гэрээн дээр шаардлагагүй ээ энэ зүгээр.

Л.Мөнхбаатар: Гонгорын Дамдинням гишүүн асуултаа асууя.

Г.Дамдинням: Зам мэдээж тавилгүй яах вэ. Тэгэхдээ энэ гишүүд бас тодорхой асуугаад байна шүү дээ. Би дахиад нэмээд асуучихъя. Монгол Улсын эдийн засаг уур уурхайгаас хамаатай тэгээд бас энэ хойд урд хилээ хооронд нь холбох ёстой гэж бид нар зөндөө л ярьж байгаа.

Өнөөдрийн байдлаар бол замын стандартаа мөрдүүлж байна гээд нэг тэнхлэг дээр явах даацыг хязгаарласнаас болоод бензин түлшний хэрэгцээ асар ихээр өсөж өөрөөр хэлбэл энэ хүнд даацын машинууд явж чадахгүй байдалд ороод энэ босоо тэнхлэгийн зам буюу төвийг Өмнөговь аймагтай, төвийг хойшоо Алтанбулагтай холбодог энэ замууд дээр хязгаарлалт аваачаад яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ эдийн засгийн үр өгөөжөө тооцоод тээвэр ложистик талаасаа бодоод энэ зүг чигээ тавихгүй яасан юм болоо. Одоо энэ өгч байгаа таницуулгаас харах юм бол Улаанбаатар-Арвайхээр, Хархорин-Цэцэрлэг, Цэцэрлэг-Тосонцэнгэл, Улаанбаатар-Өндөрхаан, Булган-Мөрөн, Арвайхээр-Баянхонгор, Өндөрхаан-Чойбалсан гэсэн чиглэл байгаа байхгүй юу. Эдийн засагт мөнгө оруулж ирдэг гол урсгалууд руугаа яагаад энэ замаа тавихгүй байгаа юм бэ? Улаанбаатараас

гараад Өмнөговь аймаг хүрэхэд өнөөдөр маш олон том техник хэрэгсэл зөөцгөөдөг. Машиныуд нь юмаа зөөж чадахгүй байгаа. Улаанбаатар хотын утааг арилгах энэ медлинг гээд энэ орж ирж байгаа түлшийг бид нар энүүгээр зөөж байгаа. Зам нь ямар ч нэмэр байхгүй. Энэ зам руугаа яагаад тавихгүй байгаа юм. Энэ зам руу хийвэл энэ эдийн засгийн үр өгөөж нь аягүй хурдан ирмээр санагдаад байх юм. Энэ эдийн засгийнхаа тооцолдлыг та нар яаж хийсэн юм. Алтанбулаг-Дарханы чиглэлийн замыг яагаад оруулчихаагүй юм.

Дарханы зам яах вэ нэг хэрэлдэж хэрэлдэж нэг юм Улаанбаатар-Дарханы хооронд 204 км, 2 урсгал, 4 эгнээ зам ирэх онд нэг юм бүрэн дуусах биз. Тэгээд энэ замаа урагшлуулаад урд хил рүүгээ холбох чиглэл рүүгээ яагаад энэ мөнгөө тавихгүй байгаа юм. Оросоос Хятадын хооронд тээвэр хиймээр байна шүү дээ.

Ингэхэд энэ Сэлэнгэ, Дархан тэгээд төв энэ урагшаагаа ингээд энэ говийн аймгууд руу явсан зам бид нарт энэ бусад замуудаас илүү үр өгөөжтэй л санагдаад байх юм. Энийг 1 дүгээрт асуумаар байна.

Энэ замууд дээр хэзээ хийх юм, ажлууд хийгдэх юм.

Хоёрдугаарт энэ зээл ингээд авах нь ээ. Энэ нэр дурдагдсан замууд тавигдах нь ээ. Энэ деталь дотор нь байгаа энэ техникийн үзүүлэлтүүдээ сайн харсан уу? Дарханы замаас бол хэд хэдэн сургамж байна шүү дээ. ТЭЗҮ-ээ хийгээд гаргахтайгаа зэрэг Баруунхараагийн гүүрийг нь мартчихсан. Дарханы зам дээр. Баруунхараагийн гүүрний зураг байхгүй. Төсөв байхгүй. Анх зээл авахдаа энийг оруулаагүй учраас хийх мөнгө байхгүй. Тэгээд нөгөө 7 жил явж байгаа зам нь нэг гүүр нь дутуу үлдчихэж байгаа байхгүй юу. Тэгээд одоо манай Зам, тээврийн яам, Сангийн яамныхан энэ мундаг хэлэлцээр гэрээ яриад л олон улсын

дүрэм журам яриад л байх юм. Энэ техникийн үзүүлэлтүүдээ хянасан юм уу та нар. Эцэст нь мартсан байна лээ шүү дээ гээд нэг ийм юм гарах вий дээ, сайн хянасан уу?

Гуав дугаар асуудал нь энэ Монгол орныхоо нөхцөлд таарах юм хийж байгаа юу? Энэ замууд дээрээ. Дарханы замын голоор байгаа энэ цементэн хаалт байна шүү дээ. Энэ олон улсын стандарт нь ийм байдаг юм гээд л анх би 2020 онд гишүүн болсноос хойш хэрүүл хийгээд л яваад байсан. Тэгэхэд энэ ЗТЯ-ныхан төслийнхөө олон улсын стандарт нь ийм юм л гэсэн. Одоо та нар цас орчихсон байхад нь очоод хар.

Хоёр урсгалын чинь нэг нь цасанд хаагдчихсан. Ганцхан урсгалтай зам болчихсон байгаа байхгүй юу. Ямар ч ашиглалт байхгүй. Энэ ТЭЗҮ-ээ энэ замууд дээрээ тооцсон уу? Дарханы замын энэ алдаа шиг юмнуудаа засаж оруулсан уу? Ийм 3 асуулт байна.

Л.Мөнхбаатар: Дамдинням гишүүний асуултад хариулъя.

Зам, тээврийн хөгжлийн сайд Бямбацогт хариулъя.

С.Бямбацогт: Тийм ээ бас нөгөө замууд дээрээ бид нар бас эдийн засгийн үр өгөөж ач холбогдлуудаар нь эрэмбэлэх ёстой. Яг энэ эрэмбээрээ ч гэсэн эрэмбэлээд үндсэндээ Дархан-Улаанбаатарын зам хамгийн өндөр ачаалалтай учраас хамгийн эхэлж, 4 эгнээтэй 2 урсгалтай болгоё гээд Европын сэргээн босголтын банк Азийн хөгжлийн банкнаас зээл аваад тэр санхүүжилтээр үндсэндээ зам бариад үндсэндээ дуусаж байна. Тэгээд өнгөрсөн 5 жилийн хугацаанд 50 хувь нь хийгдсэн байсан бол 2023 онд үндсэндээ 40 гаруй хувь нь хийгдээд 45 орчим ирэх 2024 оны 5 сарын 1 гэхэд бүрэн хэмжээгээр ашиглалтад оруулах гээд бид нар ажиллаж байгаа.

Цаашаагаа Дарханаас Алтанбулаг чиглэлийн зам дээр бид нар концесс зарласан байна ОХУ-ын хил хүртэлх. Энэ дээр улсын төсвийн мөнгө байхгүй учраас. Нөгөө талдаа бид нар Налайхаас Замын-Үүд хүртэлх зам. Энэ замыг бас концессын сонгон шалгаруулалтаар өөрөөр хэлэх юм бол өөр нөхцөлөөр барих ашиглах шилжүүлэх нөхцөлөөр зарласан байгаа. Мөн бас Улаанбаатар хотыг тойруулаад Налайхаас Баянгаас нөгөө Рашаант өртөө хүртэл хугацаанд Богд уулын урдуур Хөшигтийн хөндийгөөр дайруулаад бас нэг зам барих ийм бас концесс зарласан байгаа. Мөн бас Туул голын дагуу Баянзүрхийн товчооноос 22-ын товчоо хүртэл Улаанбаатар хотод тууш зам барихаар ийм ийм байдлаар үндсэн томоохон төлөвлөлтүүд хийгээд улсын төсөвт бас бололцоо байхгүй учраас энийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийхээр Засгийн газар ингэж төлөвлөж ажиллаж байгаа.

Ийм байдлаар үндсэндээ бол ач холбогдолтой замууддаа илүү анхааръя гэдэг. Бусдаар юу гэдэг юм бидний зам зөвхөн 44 тонн нэг тэнхлэг дээр 11 тонн гэдэг чинь дэлхий нийтийн стандарт. Орост ч, Хятадад ч тийм, Америкт ч, Японд ч, Германд ч яг энэ стандартаар л тээвэр хийж байгаа. Энэ стандартаас давсан тээврийн хэрэгсэл хүчин чадалтай тээврийн хэрэгслүүд оруулж ирээд зам дээгүүр тээвэр хийгээд түүнээсээ болоод замаа эвддэг.

Хэрвээ 44 тонн дээр ингээд явах юм бол ямар ч тохиолдолд зам эвдрэхгүй. Зам засах гэж бид нар мөнгө тавих асуудал үүсэхгүй. Тийм болохоор цаашидаа бид нар бас стандартаа яаж өөрчлөх юм уу эс үгүй бол тусгай зориулалтын зам тавих уу гэдэг дээр бид нар бас үндсэндээ бодлого гаргаад уул уурхайн бас чиглэлд бид нар тусгай зориулалтын замаар л тээвэрлэгдэж байх шиг ийм зарчмаар явна аа. Өмнөговь-Дундговийн замыг яах аргагүй шатахуун даац хэтрүүлж

тээвэрлээд дээрээс нь медлинг даац хэтрүүлж тээвэрлээд үндсэндээ эвдчихсэн. Үүнийг бид нар засахад бас тодорхой хөрөнгө санхүү тавих ёстой. Энэ нэг зээлийн хэлэлцээр баталсны дараа Сангийн сайдтай бид нар Дэлхийн банкттай ярьсан нэг зүйл бол энэ Өмнөговь Дундговийн зам руу бас тодорхой санхүүжилт эх үүсвэрийг гаргах тал дээр анхааръя аа.

Өөрөөр хэлэх юм бол түрүүн тэр ярьсан 2 сум руу тавих зам байж байгаа. Архангайн Булган сум гэсэн. Тэр сумуудын замыг үндсэндээ санхүүжилтийг энэ Дундговийн замыг Засаг дарга руу шилжүүлэх ийм байдлаар бас зохицуулалт хийе гэдэг байдлаар ярьж байгаа. Энийг бол ингэж зохицуулалт хийх бололцоотой гэж Сангийн сайд дээр өнгөрсөн намар 9 сард болсон уулзалтаар төсөв батлагдахын өмнө ингэж бас ойлголцсон байгаа гэдгийг бас танд хэлье.

Ер нь бол цаашидаа бид нар бас Өмнөговь, Дундговийн зам дээр энэ даац хэтрүүлдэг асуудлыг байхгүй болгосон. Өөрөөр хэлэх юм бол медлингийг бид зөвхөн төмөр замаар тээвэрлэж байгаа. Шатахууныг бид нар бас төмөр замаар тээвэрлүүлж байгаа. Ийм байдлаар цаашидаа үндсэндээ даац хэтрүүлж Өмнөговь руу Улаанбаатараас тээвэр хийдэг асуудлыг бас засаж байгаа. Дарханы зам дээр гарсан алдаануудыг давтахгүй биз дээ гэж алдаанууд давтагдахгүй ээ. Яах аргагүй Дархан дээр таны хэлж байгаа бас алдаанууд гарсан юм байна лээ.

Гүүр байхгүй Баруунхараагийн гүүр дахиад төсөвт мөнгө тавих гээд ингээд явж байгаа. Дахиад тэр замын цементэн хашилага энэнээс болоод цас их хунгарлаж байгаа. Энэ дээр удаа дараа шаардлага тавьж байгаа. Зураг төсөл зохиож байгаа авторын тавь гэж хэлсэн. Тавь гэж шаардсаны дагуу л бид нар явах ёстой. Энийгээ сольё гэсэн шаардлага тавьсан эцсийн хариуцлагыг би хүлээн ээ

гээж. Эм Си Пи Си юу билээ бас Батсайхан гээж захиралтай компанийнхан зураг хийсэн юм байна лээ. Бид солихгүй бид мэдэж байна. Энүүгээрээ хийлгэнэ ээ гээд ингэчихсэн. Үндсэндээ ингээд цас хунгарлоод байнга цасыг нь цэвэрлэдэг ийм хүндрэлтэй байдалтай байж байгаа. Иймэрхүү байдлаар нөгөө зураг төсөл зохиосон хүн нь тийм эцсийн хариуцлагыг хүлээнэ ээ гээд байхад нь бид нар үгүй ээ наадхаа өөрчил гээд ингээд шаардаад өөрчлүүлж чадахгүй байгаа. Гэхдээ тэр хүн хариуцлагаа хүлээх ёстой гэж харж харж байгаа. Одоо нэгэнтээ амласанд асуудалгүй болгох юм байлгүй дээ.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газраас зохион байгуулж буй урт хугацааны хөгжлийн бодлого иргэдийн оролцоо сэдэвт сургалтад оролцогчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил амьдралд нь сайн сайхан бүхний дээдийг хүсэн ерөөе өө.

Гонгорын Дамдинням гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаатар: Мөнхбаатар дарга та ер нь нэг намайг асуулт асуух бүрд нэг ийм дундуур нь тасалдаг нэг ийм ажлаа больчихоорой. Энэ 3 дахь удаагийнх нь шүү тийм.

Саяын Бямбацогт сайдын хариулт дээр энэ Дарханы зам дээр гарсан алдаануудаа давтмааргүй байна аа. Одоо тэгээд тэр компанийн зохиогч нөхөр хариуцлага хүлээнэ гээд бид нар тэрийг шоронд аваачиж хийх үү, торгох уу мэдэхгүй шүү дээ. Ингээд энэ Дарханы замын цас арилахгүй. Ингээд энэ Дарханы замын дундах энэ цементийн асуудал шийдэгдэхгүй. Тэгэхээрээ хууль дүрэм өөрчлөх, норм дүрэм өөрчлөх эрх бол танд бүрэн байгаа. Зам, тээврийн сайд.

Тэгэхээр энэ дээр та нар маань нэг анхаараад одоо энэ зээлийн хэлэлцээр дээр орж ирж байгаа төсөл нь ялгаагүй л яг ингээд л орж ирж байгаа байх. Тэгээд л олон улсын стандарт нь ийм байдаг юм. Бид нар мэдэж байна гэсээр байгаад л ингээд л амьдралгүй юм хийгээд л дуусаж байгаа байхгүй юу. Одоо тэр зам засвар арчлалтынх нь зардал бол дийлдэхээ байна. Энэ даваа гүвээтэй газрууд дээр. Энийгээ анхаараарай л гэж хүсье.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг дэгийн дагуу удирдаж байгаа. Тийм учраас Дамдинням гишүүний хэлж байгааг ойлгосонгүй шүү. Баагаагийн Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Энэ төсөл бол зүйтэй энэ төслийг авахыг дэмжиж байна бас хүү боломжийн эвтэйхэн ийм төсөл байна аа. Хамгийн гол нь энэ гаднын зээлийг их оновчтой л салбарт авах ёстой юм байгаа юм л даа. Тухайлбал манай уур уурхайн салбар чинь ДНБ-ий 33, 34 хувийг бүрдүүлдэг экспортын 90-ээс илүү хувийг бүрдүүлж байгаа мөртөө ажлын байрны 5 хувийг бүрдүүлж байгаа шүү дээ. Ажлын байр гэдэг юм бол өнөөдөр их чухал болчихсон байгаа. Тэгэхээр энэ ажлын байрыг бий болгодог, энэ үйлдвэрлэлийн салбарт, ялангуяа энэ ЖДҮ-лэлийн салбарт урт хугацаатай бага хүүтэй зээл үнэхээр ус агаар шиг хэрэгтэй байгаа юм л даа.

Тэгээд энэ чиглэлд ер нь ямар юм байдаг юм доо? Зээлийн юуг бид ч энэ маш их баталж байна шүү дээ. Энэний урд талд нэг баахан л 725 сая доллар. Энэ ХАА-н чиглэлийн зээлийг бид нар баталсан. Дотор нь оновчтой оновчгүй юмнууд зөндөө байна. Тийм манай энэ сайд нарын энэ энэ яах вэ Бямбацогт сайдаас өмнө л яригдаад л баригдаад л хийсэн байх. Энэ төслийн зорилго гэсэн чинь зам тээврийн бие холболтыг сайжруулах замаар Монгол Улсын махны

өртгийн сүлжээний логистикийн үр ашгийг дээшлүүлнэ ээ. Мах л энүүгээр зөөнө тэгээд хүн зөөхгүй. Тийм ээ сүү зөөхгүй ийм л болох юм байна л даа тэгээд.

Энэ орчуулга энэ тэр юмнуудаа их сайн бодмоор байна. Гадныхны хийж өгсөн юмыг Монгол хөрсөн дээрээ буулгамаар байна шүү дээ энэ чинь. Мах тээнэ л гээд л. Ингээд л энэ тувтан мах гээд л явчихсан байх юм. Энэ юу гэж байгаа юм бэ энэ чинь зам тавих гээд байгаа юм уу, зам засах гээд байгаа юм уу мах махны асуудал яваад байгаа юм уу? Тэгээд л малчин өрхийн платформ ч гэх шиг бүр нэг хачин хачин юмнууд ингэдэг. Тэгээд юу хийцгээгээд байна та нар энэ яамны улсуудаас асууж байгаа юм. Сайд бол яах вэ дээ. Энийг урьд нь яригдсан юм ингээд л яваад л оруулаад ирж байгаа байх л даа. Энэ эдийн засгийн өсөлт нөгөө зам дагаж хөгжил ирнэ ээ гэж үг байдаг юм. Эдийн засгийн өсөлт бий болдог салбарт та л оруулмаар байгаа юм.

Манай энэ зээл тусламж бол дандаа буруу ерөөсөө оновчгүй яваад байгаа байхгүй юу. Нөгөө загатнаагүй газар маажсаад. Загатнасан газар нь маажсаач. Тэр нь юу гэхээр үйлдвэрлэлийн салбар ажил бий болгодог, өсөлт бий болгодог салбаруудаа л авмаар байгаа байхгүй юу. Тэгээд энэ төслийн энэ үр ашгийг дээшлүүлэх ёстой. Төслийн дотоод өгөөж нь 18.7 хувь байна гэж байна. Яаж тооцдог юм энийг нэгдүгээрт хэлж өгөөч.

Хоёрдугаарт энэ олон улсын тэгш байдлын индекс гээд ERE гээд тэ энийг ер нь манайхан мөрддөг юм уу? Энэ зам хүлээж авахдаа энийг ашигладаг юм уу? Ер нь хэд ч хэчнээн хувьтай байдаг юм? Энэ хүлээж авсан Дарханы зам байна шүү дээ. Дарханы зам дээр энэ ERE нь хэд байдаг юм. Энэ бусад ашиглалтад оруулж байгаа замуудаар ямар байдаг юм ер нь. Энэ Монгол Улсын энэ ERE гэдэг үзүүлэлт ер нь ямар байдаг юм. Энийг хэлээч?

Тэгээд цаашаагаа энэ нэг гаднаас нэг ийм зээл авахаар нэг төслийн нэгж гээд нэг баахан улсууд гаднын нэг хар, цагаан толгойтой улсууд, шар толгойтой улсууд ирээд суучихдаг. Баахан аппарат гээд бүрдүүлдэг. Маш их өндөр цалин авдаг. Том том машин аваад уначихдаг нөгөө төслийнхөө хэдэн төгрөгийг энэ тэр төслийн нэгж нь идчихдэг. Ийм л байгаад байгаа байхгүй юу. Энэ одоо энэ дээр тэр юу нь алга байна ямар төсөл хэрэгжүүлэх нэгжид ямар зардал гарах юм.

Энэ тоонууд зөрөөтэй байна. Тухайлбал энэ гадаад өрийн хэмжээ ДНБ-д 2024 онд 42.7 хувь байна гэж байгаа юм. Аль хэдийн 60 хувь болчихсон юм шүү дээ. Тэгээд ийм ийм тооцоонуудаа сайн үзэж харахгүй бол нэг л гаднын юмыг л нэг л учир утгагүй нэг маш муу орчуулгатай ямар ч бодлогогүй юм орж ирэх юм.

Энийгээ засах ийм шаардлагатай зас гэж энэ яамны энэ улсууд цалинжиж сууж байгаа биз.

Л.Мөнхбаатар: Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт хариулъя.

С.Бямбацогт: Зам дагаж хөгжил гэж бас та яг зөв томъёолж хэлж байна бас. Яах аргагүй замтай байж байж улс орон хөгждөг юм байна лээ. Одоо чинь ерөөсөө иргэд очихоор ерөөсөө сургууль, цэцэрлэг, эмнэлэг гэхээсээ илүү ерөөсөө зам тавьж өгөөч ээ л гэж байна шүү дээ. Эрчим хүч тогтой баймаар байна. Замтай баймаар байна, шатахуунтай баймаар байна. Тийм болохоор яах аргагүй эдийн засгийн өсөлт эдийн засгийн хөгжилд зам бол маш чухал ач холбогдолтой. Энэ тээвэр логистик байж байж хөгждөг гэдгийг бас харсан. Бид нар цар тахлын үед ч гэсэн тэгж харагдсан. Хил хаагдсан, зам тээвэр зогссон. Түүнтэй холбоотой бараа бүтээгдэхүүн нь тэнгэрт хартал өссөн. Хил нээгдсэн, зам тээвэр чөлөөтэй болсон.

Өнөөдөр Эрээнээс Улаанбаатар руу орж ирж байгаа бараа бүтээгдэхүүн нь 10 дахин буурсан. 10 дахин 25 мянган воноор нэг машин явдаг байсан бол 2500 юанаар явдаг болсон.

Тэрийг дагаад үндсэндээ тээвэр логистикийн тийм үү эдийн засагт оруулж байгаа үр өгөөж энийг дагаад хүн болгонд хэрэгцээ байна. Зорчих хэрэгцээ байна дээрээс нь бараа бүтээгдэхүүн тээвэрлэх хэрэгцээ байна. Тэр нь өртөг зардал багатай байснаараа бараа бүтээгдэхүүн үнэд эдийн засгийн өсөлтөд бас нөлөөлдөг. Энэ агуулгаараа үндсэндээ зам дагаад хөгжлөө, зам дагаад анхаарах ёстой юм байна лээ. Дорнодын тамын 50 гэж байнга л маш их ярьж байсан шүү дээ та бүхэн мэдэж байгаа. Барьж идчих гээд хүн болгон очоод л Дорнодын тамын 50-ийг ерөөсөө лайв хийдэг нэг л инфлюзер болгон очиж од больё, тод больё гэхээр ерөөсөө л Дорнодын тамын 50-д очиж энэ замаа засаач ээ гээд. Өмнөговь, Дундговийн зам дээр очиж лайв хийдэг. Ард түмэн нь алгаа ташаад хүлээж авдаг. Энэ чинь яаж байна гэвэл тэнд бас нийгмийн хүсэл хүлээлт байна тийм үү. Зайлиггүй шийдэх ёстой асуудал байна гэдгийг л харуулж байгаа юм. Ийм л замуудаа засъя гэж байгаа юм. Энийг эдийн засгийн хувьд хамгийн ач холбогдолтой гэж үзэж байгаа. Үйлдвэр барихад тийм үү ажлын байр бий болгоход бас хэр хөрөнгө хэрэгтэй. Тэр хувийн хэвшлийнхэн хөрөнгөө гаргаад хийгээд л явж л байгаа байх. Явдаг тэгээд л тэр ч ашгийг л авж байгаа. Хөгжлийн банкнаас зээлүүд өглөө, томоохон үйлдвэрүүд томоохон үйлдвэрүүд бас баригдлаа, зарим баригдсангүй. Өөр улсын төсвөөс үйлдвэр барих бололцоо байхгүй. Гаднын зээл тусламжаар үйлдвэр барих бололцоо байхгүй. Энийг бас манай гишүүд бас ойлгох байх гэж бодож байгаа.

Зээлийн хүүгийн хувьд бас ярьж байгаа.

Ер нь бол дэлхий нийтээрээ л зээлийн хүү бас өсчхөөд байгаа шүү дээ. Түрүүн хэллээ тийм үү тэр овернайт хүү урд нь бараг 0-тэй тэнцэж байсан бол АНУ-ын төв банкны бодлогын хүү нь үндсэн 5, 6 хувьтай түүнийг дагаад өсөж байна гэж. Монголд ч гэсэн бас Монголбанкны бодлогын хүү 6 хувьтай хүртэл бууж байсан. Бид нар зээлийн хүүг нэг орон тоо тоонд оруулах гээд Баттөмөр гишүүн бид нар бас зүтгээд бас орж байсан. Одоо дэлхий нийтээрээ өсчихсөн. Ингээд ч Монголбанкны бодлогын хүү 13 хувь болчихсон арилжааны банкны зээлийн хүү, 20 хувь болчихсон л байж байгаа шүү дээ.

Тийм болохоор энэ бас нэг цаг үетэйгээ холбоотой энэ хөвөгч хүү маань бас нэг жсоохон өндөрдүү талтай байгаа гэдгийг бас та бүхэн ойлгох байх гэж бодож байна. Тээвэр логистикийн индексээр Монгол Улс Дэлхийн банкны тийм үнэлгээгээр өнгөрсөн жилтэй харьцуулахад 127 дугаар байрнаас 92 дугаар байр руу орж 30 гаруй байраар урагшилсан байгаа. Өөрөөр хэлэх юм бол Монгол Улсын тээвэр логистикийн сүлжээ сайжирч байна. Өсөж байна. Ийм хэмжээгээр бас одоо бас тодорхой үр дүн гарч байгаа гэдгийг бас харагдаж байгаа байх гэж бодож байна.

Тэгээд тэр өрийн харьцаа тэр ERE эд нар дээр манай ажлын хэсэг хариулчих нэмээд.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн 86. Ажлын хэсгийн 86 дугаар микрофоныг өгье.

Ц.Эрдэнэ-Очир: Баттөмөр гишүүний асуултад нэмж хариулъя.

Олон улсын хучилтын тэгш байдлын индексийг бол шинээр баригдсан болон ашиглагдаж байгаа замууд дээр хэмжиж байгаа. Энэхүү олон улсын индексийг тусгай тоноглолоор

тоноглосон 2 машинаар хэмжэдэг. Шинэ авто зам дээр энэ олон улсын индекс бол 2 хувьтай байх ёстой. 2 гэдэг үзүүлэлттэй байх ёстой. Одоо энэ засахаар оруулж ирж байгаа замууд дээр дандаа 6-аас дээш буюу тэги байдал алдагдсан маш их хэмжээний эвдрэлтэй замууд байгаа болохлоор бид нар энэ дээрээс 2021, 2022 онуудын хийсэн хучилтын тэги байдлын судалгааны үндсэн дээр бол энэ замын чиглэлүүдийг бас мөн сонгож оруулсан байгаа.

Л.Мөнхбаатар: Та нэмснийх нь дараа юу? Нэмж хариулъя. Сангийн яам, Тулга дарга хариулъя.

С.Тулга: Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье. Гишүүний асуултад хариулъя.

Баттөмөр гишүүнн энэ 60 хувь давчихсан гэдэг нь таны ярьж байгаа энэ улсын секторын өрийг хэлж байгаа юм. Бид нарын нөгөө 44.3 гэдэг нь 2023 оны 3 дугаар улирлын байдлаар Засгийн газрын гадаад өрийн хэмжээ 42.7 хувь гэдэг нь 2024 онд Засгийн газрын гадаад өрийн хэмжээ ийм болно оо. Гишүүний ярьсан 60 хувь давчихсан шүү гэдэг чинь 2023 оны 3 дугаар улирлын байдлаар улсын секторын нийт өрийн хэмжээ Жи Ди Пи-ийн 62.2 хувьтай тэнцэж байгаа. Энэ засгийн улсын секторын өр гэдэг маань Засгийн газрын өр дээр Төв банкны өр тэгээд төрийн өмчийн өрийг нэмсэн ийм тоо байгаа юм аа.

Л.Мөнхбаатар: Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууя.

Б.Баттөмөр: Энэ он бол 2 долоо хоногийн дараа шинэ он гарлаа. 2024 оны төсөв батлахад улсын өр, Засгийн газрын өр 60 хувь гээд батлагдсан байгаа шүү. Энийг уншаарай нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ бид чинь гаднаас л хөрөнгө оруулалт хийж л бүтээн байгуулалтаа л хийдэг болчихлоо л доо.

Төрийн зардлыг багасгах хэрэгтэй. Төрийн зардал зад занхайж байгаа шүү. Ийм учраас энд төрийн зардлыг багасгах замаар хөрөнгө оруулалтаа илүү хөрөнгө оруулалт хийх ёстой гэж. Эдийн засгийн шууд өсөлт бий болгодог салбарт хөрөнгө оруулах ёстой. Энэ 30 жилийн хугацаанд нэг бодитой зүйл бол Дарханы төмөрлөгийн үйлдвэр гэдэгт хийсэн хөрөнгө оруулалт үлгэр жишээ болно.

Бусад нь бол үндсэндээ алга. Замыг эрэмбэлнэ гэдэг зүйтэй. Тэгээд энэ Дархан, Сүхбаатар-Замын-Үүдийг холбосон энэ зам ямар түвшинд явж байна аа? Замын хураамжийн асуудал байна. Энийг 1000 төгрөг.

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя. Сандагийн Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Энэ гол 70 жилийн хугацаанд бид нар Орос, Хятад, Ази Европыг холбосон ганцхан замтай байсан авто зам. Энэ зам бол Алтанбулаг, Улаанбаатар, Замын-Үүд. Үүнийгээ үндсэндээ бид нар Налайх хүртэл нь 4 эгнээ болгочихсон. Дархан хүртэл нь 4 эгнээ болгочихсон. Одоо цааши нь үргэлжлээд Дарханаас Алтанбулаг хүртэл 4 эгнээ болгох, Налайхаас Замын-Үүд хүртэл 4 эгнээ болгох ийм шаардлагатай байгаа. Энэ дээр үндсэндээ төр хувийн хэвшилээр концесс зарласан. Одоогийн байдлаар 9 компани материал авсан байна аа. Өөрөөр хэлэх юм бол бид нар энэ замыг 4 эгнээнд нэн яаралтай болгох ийм бодлого зорилго дэвшүүлээд ажилдаа орчихсон явж байгаа гэдгийг танд хэлье.

Хоёрдугаарт нь замын хураамж мянган төгрөг дэндүү бага байгаа. Дэндүү бага. Бид нар бензинд зарцуулахдаа мянган км-т 300 орчим мянган төгрөгийн бензин хийгээд явдаг мөртөө замын хураамжтай мянган км-т бид нарын 3 мянган төгрөг хүрэхгүй мөнгө төлж байгаа юм. Тэгвэл дэлхийн бол жишиг

үндсэндээ бензид зарцуулж байгаа мөнгөтэйгөө тэнцэх хэмжээний хураамжийг л төлдөг юм байна лээ. Өөрөөр хэлэх юм бол мянган км давхиад 300 мянга орчим хураамж төлж.

Л.Мөнхбаатар: Бямбацогт сайд гүйцээгээд хариулчихъя.

С.Бямбацогт: Тэгж замын хураамжийг үндсэндээ бол нэмж байж тэр замаа засах, их засвар хийх, ээлж засвар хийх, урсгал засвар хийх санхүүжилт нь гардаг. Ингэж байж зам нь одоо тэгш байдал нь гадаргуу нь тэгш аваар осол гарахгүй, хагархай цоорхойгүй, халтиргаа, гулгаагүй болох бололцоо бүрддэг юм байна лээ л дээ. Тэгээд энэ дээр харьцангуй бид нэлээн хоцрогдчихсон явж байгаа.

Тэгэхээр цаашидаа бид нар замын хураа хураамжийг хэрхэн яаж бас ард иргэддээ дарамт болохгүйгээр нэмэгдүүлэх вэ, яаж замаа засахад шаардлагатай санхүүжилт эх үүсвэр босгох вэ гэдэг дээр бас томоохон бас бодлого гаргах ийм шаардлагатай байгаа.

Өнөөдөр замын хураамж үнэхээр бас харамсалтай байгаа байх. Хоолондоо бид нар 30 мянган төгрөг зарцуулдаг мөртөө замын хураамжид нь 3 мянган төгрөг зарцуулдаг, бензидээ 300 мянган төгрөг зарцуулж байгаа юм. Мянган км явахад тийм болохоор энийг бас манай иргэд бас ойлгож байгаа байх. Цаашидаа бас энэ замын хураамжийг бас нэмэгдүүлэх тал дээр бас бодлого гаргана гэдгийг бас хэлье ээ.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны дарга Жигжидийн Батжаргал асуултаа асууя. Баярлалаа.

Ж.Батжаргал: Тэгэхээр энэ аливаа бодлого, хууль тогтоомжуудад бодит байдлаар юмнуудаа илэрхийлж тусгах тухай асуудал байгаад байгаа юм байна. Тэр Засгийн газрын гадаад өр,

ДНБ-ий 60 хувь гэдэг чинь хуулиар байж болох дээд тааз. Гэтэл бид нар төсвийн хүрээний мэдэгдэл төсөөлөлдөө яг тэр тоогоороо тавьчихаад байгаа байхгүй юу. Бодит байдал дээр өнөөдөр бид нар 44.2, энийгээ биднүүс 42-оос 44 гэсэн хэлбэлзлээр авч үзээд яваад байдаг. 2024 онд энүүнийг 39-өөс 42-ын хооронд байж болох юм байна гэсэн ийм л төсөөлөл харагдаад байгаа шүү дээ энэ чинь. ДНБ чинь өөрөө өсдөг. Тэгэхээр зэрэг тэрэн дотор эзлэх гадаад өрийн чинь хэмжээ бас өөрөө нэг ийм хэлбэлзэл дотор явж болох юм байна гэж. Ер нь цаашид энэ нэг юмнуудаа их бодитой болгож тавихгүй бол ард түмэнд ч худлаа ойлголт мэдээлэл өгөөд байгаа байхгүй юу. Гадаад өр нь 60 хувьтай байгаа юм шиг ийм ойлголт өгөөд байгаа.

Энэ зээлийн хэлэлцээрийг соёрхон батлахыг дэмжиж байгаа. Яагаад гэхээр зэрэг хөгжлийг тэтгэсэн дэд бүтцийн салбар луу бид авч байгаа. Анх энэ хэлэлцээр ерөнхий хэлэлцээр явахдаа ХАА-н бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн дэд бүтэц тээвэр ложистикийн сайжруулах гэсэн ийм нэршилтэй явж байсан юм аа.

Тийм ч учраас тэр мах гэдэг үг маш олон орсон байх ёстой. Наад дотор чинь. Анх тэгж явсан эд байхгүй юу. Гэтэл явц дунд нь нэр ус юмнуудыг нь өөрчлөөд байгаа явдал л гарч ирээд байгаа. Замаа засалгүй яах вэ засъя. Гэхдээ яг үндсэн хэлэлцээрийнхээ үзэл санаанд тулгуурлаж тэр ахиу бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бүс нутгуудынхаа дэд бүтцийг сайжруулахад тодорхой хэсгийг нь зарцуулъя гэж Төсвийн байнгын хороон дээр зориуд саналаа илэрхийлсэн. Гэтэл энэ одоогийн орж ирчхээд байгаа зээлийн хэлэлцээр дотор чинь энэ үг өгүүлбэр чинь байхгүй болчихжээ. Байхгүй байна. Энүүнийгээ анзаараач ээ. Яах аргагүй энэ Монголын чинь мах, сүү, ногоо бүх юмыг бэлдэж байгаа энэ Булган, Сэлэнгэ, Дархан төвийн энэ бүс нутгийн гол

үйлдвэрлэлийнхээ бүсүүдийг дэд бүтэцжүүлэх ажил дээр бас тодорхой хэсгийг нь зарцуулъя аа.

Дийлэнхийг нь бол одоогийн байж байгаа замуудынхаа засвар руу чиглүүлж тэр бүс нутгуудаас орж ирэх ХАА-н бүтээгдэхүүний дэд бүтэц, тээврийн асуудал дээр шуурхай байдлыг нь хангая гэдэг ийм л юм ярьсан шүү дээ. Тэгээд яагаад энэ асуудал орхигдоод байгаа юм?

Дараагийн нэг зүйл байна. Энэ бодлого стандарт бүх юмаа барьдаг төрийн төв байгууллагууд нь цаг үеийн ажил асуудлуудыг явуулах гээд стандарт зөрчиж янз бүрийн үйл ажиллагаа явуулсантай холбогдоод энэ замуудын чинь эвдрэл үүсээд байгаа юм аа. Улаанбаатар Даланзадгадын зам бол яг ингэж үүссэн зүйл байхгүй юу. Орон нутгийн удирдлагууд газар гэсэх цаг үеэр тэнхлэг дээр байх даац тохируулгыг барих гэж оролдоод Засгийн газартаа загнуулаад тамаа цайж байж хагас эвдрэлтэй авч үлдсэн. Тэгээгүй бол наадах чинь бүтэн эвдрэх байсан. Одоо харин энэ үйл явцаа бүрэн засах ёстой. Дээр нь энэ ээлжит засвар их засварыг яг цаг хугацаанд нь хийх замаар энэ хөрөнгө үрэн таран хийдэг юмыг л болиулах ёстой юм. Тэгж байж бид энэ замын насжилтыг нэмэгдүүлэх ёстой. Энэ рүүгээ бүүр онцгой анхаарч ажиллах ёстой.

Тийм учраас энэ төсөл дотор зүгээр ер нь протокол дотор тусгана гэдгээр бид яримгүй байна аа.

Улаанбаатар Даланзадгадын зам засвар дээр одоо энэ зээлийн хэлэлцээр дээрээ нэр усыг нь зааж оруулах ёстой. Тэгж байж энэ замын нөхцөл сайжрах ёстой, энэ замаар дамжих ачаа.

Л.Мөнхбаатар: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Зам тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт хариулъя.

С.Бямбацогт: Батжаргал гишүүн бас нөгөө зээлийн хэлэлцээр анхнаас нь нөгөө түүхийг нь сайн мэдэж байна. Бас нэлээн оролцож явсан байх. Манай гишүүдийн бас шүүмжлээд байгаа тэр янз янзын үгнүүд гэдэг юм уу махны л сүлжээ логистик, малчин эмэгтэйчүүд ХАА-н бүтээгдэхүүн гээд замаа засаж байгаад зам зассан зам дээгүүр чинь махаа ч тээвэрлэнэ, хүнээ ч тээвэрлэнэ, сүүгээ ч тээвэрлэнэ, нүүрсээ ч тээвэрлэнэ гэж л байгаа л даа. Ер нь бол тийм.

Энэний агуулга анхных нь агуулга нь тэр ХАА-н бүтээгдэхүүн тээвэр логистикийн сүлжээг сайжруулах төсөл гэдэг нэртэй явсан юм байна лээ. Ингэж орж ирээд Их Хурал дээр орж ирээд буцсан нэг шалтгаан тэр Өвөрхангайд махны агуулах барих гэж байна. Та нар хувийн хэвилийнхэн хийх ч 20 сая доллар байтугай тэрнээс хямдхан зардлаар хийчих юмыг ингээд махны агуулах хийх гэж байгаа энэ рүү чиглэсэн юм явуулаа гэж шүүмжлээд Их Хурлын гишүүд буцаасан.

Байнгын хороон дээрээс 2 удаа бас чиглэл өгч буцаагдаад үндсэндээ нэлээн шүүгдээд явж байгаа. Ингээд явахдаа яах вэ дээ тэр Өвөрхангай агуулахыг явуулахын тулд тухайн үед төслийг оруулж ирж байсан нөхдүүд юу гэдэг юм нэг чимэг зүүлт байдлаар янз янзын гоё нэр хэллэг томьёо оруулаад ирчихсэн тэрнүүд нь ингээд хасагдаад гэхдээ хасагдаж дуусаагүй ингээд л явж байгаа. Иймэрхүү байдлаар нэг жсоохон шүүмжлэл дагуулсан үгнүүд л явж байгаа байх. Одоо тэр яриад байгаа тэр малчин эмэгтэйчүүдийг тийм удирдлага, удирдлагад сургах сургалт гээд энд төсөвлөсөн тодорхой мөнгө байхгүй шүү дээ. Зөвхөн л юу гэдэг юм Их Хурлын гишүүдийг нэг жсоохон од болгох юу гэдэг юм ялгарч харагдуулах ийм байдлаар олз болох л тийм нэг шүүмжлэлтэй үгнүүд орчихсон. Энүүгээрээ бид нар хасахгүй ингээд л шүүмжлүүлээд сууж байгаа.

Тэгээд иймэрхүү л алдаануудыг ялангуяа яг ажил хариуцсан нөхдүүд маань бас анхан шатандаа бас нэгж дээр гаргамааргүй л байгаа юм. Энэ агуулгаараа ярих юм бол нөгөө тэр 20 сая доллар бид нар хассан. Үүнийх нь оронд зам орж ирсэн. Одоо үндсэндээ энэ цэвэр энэ 100 сая доллар бол цэвэр 100 сая доллар бүгдээрээ 110 сая доллар бүгд замд зарцуулагдаж байгаа. Дорнодын тамын 50-д 20 сая доллар тавигдаж байгаа. Ингээд цааш нь бас Сангийн сайдтай бас ярьсан. Бид нар таны ярьж байгаа тэр Даланзадгадын зам, Өмнөговийн зам, Мандалговийн зам яах аргагүй бас эвдчихсэн учраас засах ёстой. Монгол Улсын ерөнхий сайд уулзалт хийхдээ бас засна гээд амлалчихсан. Энийг бас шийдье ээ гээд. Тэгээд улсын төсөвтөө суулгах гэж нэлээн явсан харамсалтай нь амжаагүй.

Энийг бид нар шийдэхдээ Дэлхийн банкны тэр хэлэлцээр батлагдсаны дараа Дэлхийн банкттай бас тийм үү ярилцаад энэ дээр эх үүсвэрийг тийм үү түрүүн тухайлж хэлэх юм бол зарим сумууд руу тавих замуудыг тийм үү сумууд руу тавихыг нь болиулаад энэ замын засвар оруулах байдлаар шийдье ээ гэдэг ийм бас агуулгаар Сангийн сайдтай Сангийн сайд, Сангийн яамны ТНБД-д бас зээл тусламж хариуцсан газрын дарга нартай бид нар бас яг манай яамныхан уулзаад ингэж бас протоколдож бас ярьсан байгаа гэдгийг танд бас хэлье ээ.

Тэгэхээр энэ дээр бас илүү анхаарч ажиллана гэдгийг танд хэлье. Ээлжит засвар, их засварт ер нь зайлиггүй мөнгө тавьж байх ёстой юм байна лээ. Бид нар ерөөсөө зам бариад л хаячихдаг. Тэгээд урсгал засварт нь тийм үү өвөлд нь халтиргаа гулгаатай үед нэг жоохон мөнгө тавьдаг. Зунд нь хагархай цоорхойгоо нөхөх гэж нэг жоохон мөнгө тавьдаг. Тэгээд ерөөсөө мөнгө тавьдаггүй. Тэр нь нэг жилд 7400 км, улсын чанартай 14 мянган км зам байгаа. Энэ дээр 50 гаран тэрбум төгрөг л тавьж

байгаа юм. Тэгвэл бид нар их засварт нийтдээ үндсэндээ их засварт нь нэг их наяд, эл засварт нь дахиад 1 их наяд 2 их наяд төгрөг тавьж байж үндсэндээ энэ замуудыг стандартын шаардлага хангасан, тэгш гадаргуутай, аваар осол гаргахгүй, аятай тухтай зорчих нөхцөл бололцоотой болгох ийм юм байна лээ. Ийм юм ерөөсөө хийж ирээгүй түүхэндээ.

Бид нар 20, 30 жил зам барьсан мөртөө ингэж замаа засаж үзээгүй. Одоо анх удаагаа бид нар энэ 360 орчим тэрбум төгрөгөөр энэ зам засах гэж байгаа. Энэ замын хөрөнгө бас урьд нь хөнгөлөлттэй зээл авлаа гэхэд чинь тал нь сургалт, зөвлөгөө, томилолт бичиг цаас гээд ингээд алга болчихдог бол энэ үндсэндээ 110 сая доллар, бараг бүгдээрээ замд зарцуулагдана. Зөвхөн одоо энэ дээр хуваарийг нь хэлэхэд би танд яг энэ бодитой ажилдаа 110 сая доллароос үндсэндээ 104 орчим сая доллар яг шууд бүтээн байгуулалтын ажилд зарцуулагдана.

Ийм байдлаар бас мөнгөнүүд бас хуваарилагдсан байгаа гэдгийг та нарт хэлье ээ.

Л.Мөнхбаатар: Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Тийм ээ зээлийн ерөнхий хэлэлцээрийн үзэл санаанд тулгуурлаад нийт орж ирж байгаа эх үүсвэрийн тодорхой хувийг нь яах аргагүй тэр ахиу үйлдвэрлэл бий болгоод байгаа бүс нутагтаа хийе ээ гэдэг энэ саналыг их тодорхой ярьсан юм аа. Тэгээд тэр нутгийн зам мах сүүний ногооны эрчимжсэн аж ахуйнууд байршигчхсан Төв аймгийн энэ Сүмбэр сумын зам засварын ажлыг энүүнд багтааж өгөөч ээ. Энэ зам юм нь эвдрээд бараг 10 гаруй жил болж байна гэдэг саналыг Энхболд гишүүн бид 2 бүр албан ёсоор энэ ерөнхий хэлэлцээрийн үеэр саналаа тавьж байсан юм.

Тийм учраас эдгээр асуудлуудаа судалж бас шийдэх үнэхээрхийн зайлиггүй шаардлагууд байгаад байгаа юм.

Хоёр дахь нь яах аргагүй энэ Улаанбаатар-Даланзадгадын чиглэлийн авто замыг бол засварлах ёстой бид. Энүүн дээр тов тодорхой.

Л.Мөнхбаатар: Санал хэллээ Батжаргал гишүүн.

Байнгын хорооны дарга Бямбасүрэнгийн Энх-Амгалан.

Б.Энх-Амгалан: Энэ зээлтэй холбоотой асуудлаар ажлын хэсгийнхэн нэг юм анхаараарай. Анх энэ зээл орж ирэхдээ бол Хөдөө аж ахуйн яаман дээр 30 сая доллар нь зарагдахаар орж ирсэн шүү. Тэгээд Болорчулуун сайд Байнгын хорооны хурал дээр энэ зээлээс татгалзлаа.

Манайх энэ зээлийг ашиглахгүй бид нар өөр эх үүсвэрээр явна, надтай зөвшилцөөгүй гэдэг асуудал ярьж байгаад энэ болиод тэгээд Зам, тээврийн яаман дээр энэ асуудал тавигдаж тэгээд цэвэр ложистикийн төсөл боллоо шүү. Тэгээд тэр үед бид нар асууж байсан юм. Юун малчин эмэгтэйд энэ платформд оролцох вэ, яах гээд байгаа юм? Мах яаж эвдэхийг нь зааж өгөх гээд байгаа юм уу, эсвэл махаа яаж ачиж хүргэж ирэхийг нь зааж өгөх гээд байгаа юм уу? Юу гэсэн үг юм гэж байгаад энэ хасагдсан юм. Тэгсэн сая Сангийн яамныхан бас дахиад энэ дээр оруулаад ирчихсэн нөгөөхийгөө өөрчлөөд 2.2 дээрээ та нар эмэгтэй удирдлагатай малчдад платформын сургалтад хамруулна гээд малчин эмэгтэйчүүд гэж нийтдээ хандаж байсан. Сүүлдээ эмэгтэй удирдлагатай гээд оруулаад ирчихсэн ийм хачин юм явуулахгүй шүү. Бид нар Байнгын хороон дээр дэмжихдээ энийг чинь хасъя гэдэг нөхцөлөөр дэмжсэн шүү протоколд байгаа шүү. Та нар энийгээ зөвшөөрөөд тэгийг гээд асуултад хариулаад, сайд энийг хаслаа гэдгээ хэлээд

тэгээд дэмжигдсэн төсөл шүү. Та нар нөгөө нэг за за зөвшөөрчих, заавал биелүүлэх албагүй эхлээд соёрхон батлуулчихъя тэгээд дараа нь дотор нь гэрээгээ эцэслэн батлахдаа өөрчилчихье гэдэг ийм хандлагаар Улсын Их Хурлыг хуурах гэж байгаа бол ийм хандлагаар Байнгын хороог Улсын Их Хурлын гишүүдийг хуурах гэж байгаа тийм юм байхгүй шүү.

Сүүлд нь хариуцлага хүлээнэ шүү та нар. Ингэж төслийг дотор нь засдаг юм бол. Энэ төсөл энэ дээр байхгүй гэдгийг би сонсмоор байна. Протоколд үлдээхийн тулд, нэг дэх асуудал.

Хоёрдахь асуудал. Нэг зүйлийг анхаараарай. Наад хөвөгч хүү чинь явж байгаад нэг энэ зээлийг чинь авсан хүүнээсээ өндөр болчих вий дээ. Энийг анхаар гэдэг юм энэ төслийн бид нар та нарт өгсөн чиглэлийн 8, 9 дээр маш тодорхой байгаа шүү. Засгийн газрын өрийн тухай хуулийн төсвийн тухай шаардлагад нийцүүлэх ёстой. Ам.доллартой төгрөгтэй харьцах харьцаа 21.5 хувиар суларсан байна. Цаашид энэ нэмэгдэх хандлагатай байна шүү. Энийгээ анхаараарай гэдэг юмнууд хэлсэн. Та нар энийг хангаад ороод ирлээ л гэж хэлээд л энийг батлуулж байгаа шүү дээ. Энийгээ анхаараарай.

Гуравдахь асуудал. Энэ төслийн нэгж хяналтын нэгж, зураг төслийн нэгж, зөвлөх компани энэ тэр гээд нэг баахан юм авдгаа энэ дээрээ болиорой. Танай Дарханы зам дээр ийм юмнууд гээд олон улсын жишигээрээ тийм байдаг юм гээд л.

Тэгээд л эндхийн компани тэр зураг төслийн юмнууд авчхаад тэрийгээ засаж ч чадахгүй, сольж ч чадахгүй, яаж ч чаддаггүй юм байна лээ шүү дээ. Тэгээд сүүлд нь буруутан нь болохоор Зам, тээврийн яамны хэдэн хүмүүс болж хувирдаг. Төслөө анхнаасаа байгуулахдаа тэгж зөв байгуулаагүйгээс болоод тэр

чинь байгуулагдсан гэрээнийх нь дагуу явахаас өөр ямар ч аргагүй байдаг юм байна лээ шүү дээ. Энийгээ та нар онцгой анхаараарай гэдгийг би 2 санал хэллээ. Нэг асуултдаа хариулт авъя. Протоколд үлдээхийн үүднээс.

Л.Мөнхбаатар: Зам тээврийн хөгжлийн сайд Бямбацогт хариулъя.

С.Бямбацогт: Тийм Энх-Амгалан гишүүнтэй санал нэг байгаа. Анх энэ 110 сая долларын зээлийн тодорхой хувь нь тэр 30 орчим сая доллар нь бол хөдөө аж ахуйн салбарт зарцуулагдахаар байсан. Тэр нь махны логистикийн сүлжээг сайжруулах, түүнтэй холбоотойгоор малчин эмэгтэйчүүдийг дэмжих гэсэн агуулгатай юм бас байсан. Үүнээс татгалзаад энэ төсөл бол үндсэндээ энэ 110 сая доллар цэвэр зам руу орж байгаа замын их засвар, зам барих гүүр рүү. Тийм болохоор зөвхөн энэ агуулгаар явах ёстой. Энэ агуулгаар. Түрүүн би хэлсэн тодорхой батлагдсаны дараа бас тодорхой зохицуулалтууд хийнэ ээ гэж. Энэ зохицуулалтууд хийхдээ таны хэлсний дагуу энэ зөвхөн замынхаа. Ер нь одоо ч гэсэн энэ дээр мөнгө байхгүй байгаа. Ерөөсөө энэ 110 сая доллар цэвэр зам барихад, зам засахад гүүр барихад зарцуулагдана гээд тавьчихсан. Тэр малчин эмэгтэйчүүдийг сургах дадлагажуулах гэдэгт мөнгө ерөөсөө төсөв байхгүй.

Ганцхан тэр илүү өгүүлбэр явж байгаа тэр илүү өгүүлбэр хасвал асуудалгүй гэдгийг бас албан ёсоор хэлчихье ээ. Энд ирээд анхаарч ажиллая.

Ер нь бол бас тийм замын зөвлөх үйлчилгээ замын зураг төсөл зохиох гэж олон улсын байгууллагууд гээд ингээд олон янзын шаардлага тавьдаг, хяналт тавьдаг. Энэ дээр үнэхээр Энх-Амгалан гишүүн урьд нь бас сайд Зам, тээврийн сайд гэж зовлонг нь мэдэж байна. Энэ Дарханы замыг үндсэндээ Зам, тээврийн хөгжлийн яамны хэдэн ажилтнууд л

барьсан, хяналт тавьсан. Тэр зураг төсөл зохиосон нөхдүүд нь юу хийж байгаа юм бүү мэд. Төслийн нэгж нь юу хийдэг юм бүү мэд.

Дээрээс нь тэр хяналт тавих гаднын компаниуд юу хийдэг юм бүү мэд. Ийм байдлаар ерөөсөө тэгээд ажлаа хийхгүй, хамаг ажлын өмнөөс нь шатахуунгүй болно ЗТЯ-ныхан нь шатахуун олж өгдөг цементгүй болно. Цементийг нь олж өгдөг, гааль дээр ачаа Зам, тээврийн яамныхан авчирч авч өгдөг. Ийм байдлаар явж байж үндсэндээ зам орж байгаа. Гэтэл цаад талд нь тэр тодорхой цалин авдаг, төслөөс мөнгө санхүүжилт авдаг тэр өчнөөн байгууллагууд ажлаа хийдэггүй. Ийм алдаануудыг бид нар цаашид гаргуулахгүй байх талд анхаарна аа. Энэ ийм алдаа бол яах аргагүй Дарханы замд гарсан. Энэ алдаа цаашидаа гарах ёсгүй. Тэгээд л мөнгийг нь авдаг улсууд нь тусдаа гаднынхан ирээд л тэр Энэтхэгийн Ай Си Ти компани гэдэг ч юм уу, Монголын нэг компани гэдэг ч юм уу, зураг төслийн компани, дахиад дээрээс нь төслийн нэгж баахан улсууд цалин авдаг, баахан улсууд тэр зардлаас санхүүждэг тэгсэн мөртөө яг эцсийн хариуцлага гүйцэтгэгч компани. Зам, тээврийн яам л хийдэг.

Ийм нэг тийм сул талууд бас байдаг юм байна лээ зохион байгуулалтын хувьд. Тэгээд энийг бид нар бас засаж байгаад цаашид ийм асуудал гаргахгүй ээ.

Л.Мөнхбаатар: Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороон дарга Гочоогийн Ганболд асуултаа асууя.

Г.Ганболд: Төслийг дэмжиж байна. Манайх чинь сүүлийн үед нөгөө бүх аймгуудыг холбоно гэж явсаар байгаад дээр үед холбогдсон нэртэй байсан. Энэ төвийн аймгуудын зам бол 80, 90-ээд оны үнэхээр хуучирчихсан л даа. Улсын төсөв дээр олигтой мөнгө тавигддаггүй. Дандаа нэг нөхөөсний ажил тавигдсаар байгаад харин их зөв ажил руу хуваарилсан байна

гээж бодож байгаа юм. Их засвар шаардлагатай маш олон хуучирсан замууд байна. 20 жил, 30 жил болсон. Тэгээд энэ замууд дээр зүгээр яах вэ, тэр аймаг, энэ аймаг л гээд байна л даа зүгээр шууд улсын чанартай замынх нь дугаараар л тавьчихгүй 03, 01 гээд л. Энэ бол зөвхөн нэг аймгийн зам биш. Бүхэл бүтэн улсын чанартай дээгүүр нь 10-аад аймгуудын дамжин өнгөрөх замууд байгаа юм. Тэр нь ч яах вэ тэгээд энийг явуулах нь зүйтэй гэдгээр дэмжиж байна.

Хамгийн гол нь бид нар нөгөө олон улсын банкнаас зээл авахаараа яг өөрөө зээлээр авсан хөрөнгөө удирдаж чаддаггүйд л гол учир байгаа юм. Азийн хөгжлийн банк ч юм уу, бусад газрууд орж ирэхээрээ Зам, тээврийн яам 1 тендер шалгаруулчихдаг. Тэрний нөгөөдүүл нь Азийн хөгжлийн банк гэхэд шалгаруулсан компанийг нь шалгаруулдаггүй, зөвшөөрдөггүй энэнээсээ болоод хугацаа алддаг ийм зүйлүүд байгаа.

Тэгэхээр яг энэ авч байгаа зээл дээр яг хөрөнгөө яг хэн шууд удирдах юм бэ? Зам, тээврийн яам одоо 100 хувь удирдаад аваад явах уу? Эсвэл бас л нөгөө банк нь хүүтэй зээл өгчхөөд одоо энэ бол сая сонсож байхад бас тийм бага хүү биш доллароор гэхэд бол хөдөлгөөнтэй дунджаар 6 хувийн хүүтэй гэдэг бол тийм бага хүүтэй мөнгө биш шүү дээ. Тэгээд банкнаас бас нэлээн өндөр хүүтэй мөнгө авчхаад тэгээд тэр гүйцэтгэх шалгаруулалтад нь оролцдог ийм зүйлүүд байна уу? Ийм юмнаас л жаахан хол байхгүй бол манайхны хамгийн том алдаа бол энэнээс болж хугацаа алдахаас гадна өөрсдөө одоо энэ хөрөнгө мөнгөө удирдаж чадахгүй зүйл байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бол зүгээр Бямбацогт сайд яг яам 100 хувь энийгээ удирдаад явах уу гэдгийг би асуух гээд байгаа юм.

Л.Мөнхбаатар: Бямбацогт сайд хариулья.

С.Бямбацогт: Тийм Ганболд гишүүн бас чухал асуулт тавьж байна.

Энэ замуудыг ингээд тавьчихаар аймгууд манай аймгийн нэр алга тэр аймгийнх орчихсон байна гэж хараад байх шиг байгаа юм. Эшшээ нь Лүнгийн гүүрэн дээгүүр гардаггүй баруун аймгийн машин гэж байхгүй. Лүнгийн гүүрэн дээгүүр. Одоо энэ Бэлхийн гүүр ингээд, Түргэний гүүр гээд энэ гүүр, Хэрлэн Орхоны гүүр гээд энэ замаар гүүрэн дээгүүр явдаггүй бас аймгийн машинууд байхгүй л дээ. Тийм болохоор бид нар үндсэндээ улсын чанартай зам энэ зам дээгүүр үндсэндээ бүхий л, баруун чиглэлдээ, зүүн чиглэлдээ, хойд чиглэлдээ, урд чиглэлдээ явж байгаа. Машиныуд бүгд явж байгаа. Энийг бас манай гишүүд бас тэгж тэр өнцгөөс нь хараасай гэж үзэж байгаа.

Улаанбаатар, Арвайхээр чиглэлийн жишээ нь 105 км замыг засна. Улаанбаатар-Өндөрхаан чиглэлийнхэн энд 70 км зам засна. Энэ зүүн аймгийнхан Дорнод Сүхбаатарын зам дээрээс л явна шүү дээ. Хархорин-Цэцэрлэг чиглэлийн 30 км, 40 км зам Булган-Мөрөн чиглэлийн 13 км, Цэцэрлэг-Тосонцэнгэл-Архангай чиглэлийн 50км зам.

Арвайхээр, Баянхонгор чиглэлийн 35 км, Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50 км. Ингээд нийтдээ 361 км зам болж байгаа.

Ийм байдлаар үндсэндээ замууд засагдах юм аа. Өөрөөр хэлэх юм бол энэ зам дээгүүр Монгол Улсын иргэн болгон зорчиж байгаа ачаа бараа болгон тээвэрлэгдэнэ ээ. Энд хэн нэгэн аймагт тусгайлан ялгаж зориулсан зам биш ээ гэдгийг бас гишүүд маань ойлгож байгаа байх аа.

Тендэртэй холбоотой асуудал. Энэ бас хэл амтай асуудал аа.

Дарханы зам дээр гэхэд Хятадын баахан компани цүнхтэй компаниуд шалгаруулчихсан. Азийн хөгжлийн банк руу явуулдаг. Буцаад тэрийг шалгаруул гэсээр байгаад үндсэндээ тэд нар шалгардаг. Үүнээсээ болоод энэ бас их гарсан компаниуд нь ажлаа хийхгүй гэрээ цуцлагдсан ч асуудлууд байна. Ажлаа муу хийж байгаа асуудлууд ч байна. Дахиад бөөн асуудал болчихсон энэ нөхдүүд ч байж байгаа. Үндсэндээ юу гэдэг юм зээл өгчхөөд зээлийнхээ араас хэт их оролцдог. Энэ бас гол нь зохимжгүй юм байгаа юм. Тэртээ тэргүй Монгол Улс тэр зээлийг авчхаад Монгол Улс тэр зээлийг төлнө. Тийм болохоор бид нарт авсан зээлээ буцаагаад яаж үр ашигтай байлгах вэ, яаж чанартай байлгах вэ яаж хурдан хийлгэх вэ гэдэг дээр бид гол нь эрхээ эдэлдэг баймаар байгаа юм.

Гэтэл зээлээ тулгаад араас нь юу гэдэг юм зөвлөх үйлчилгээ араас нь тулгаад баахан томилолт, гадаад дотоод томилолт араас нь тулгаад тэр компани, энэ компанийг шалгаруулах. Иймэрхүү зүйл байх ёсгүй ээ. Дэлхийн банкны энэ төсөл дээр яг ийм байдлаар хандана. Манайхан бас дотооддоо бас асуудалтай. Бас салбар салбарын бодлогоо яаманд нь хариуцсан байж байдаг. Гэтэл Төрийн худалдан авах ажиллагааны газар гэнэ. Газар дээр тендер зарлаад явчихдаг тэр нь эзэнтэй болдоггүй ажил нь хийгдэхгүй. Тухайлах юм бол хулихны зам 2 жил гаран явж байна.

Дорнодын хавиргын зам бас 2 жил гаран явж байна. Тендер шалгардаггүй. Эцэст нь хариуцлага хүлээхгүй нөхдүүд дээр авч аваачаад ажлыг зохион байгуулчихдаг. Сүүлд нь би мэдэхгүй тэр компани тэр шалгаруулсан, тэр компанитайгаа асуудлаа ярина биз гэдэг эцэст нь юу гэдэг юм салбар хариуцсан яам нь ажилд нь, асуудал дээр нь их унадаг иймэрхүү асуудал бас байгаад байдаг.

Тэгэхээр иймэрхүү асуудал бас гаргахгүй байх ерөөсөө нөгөө эрхээ ч эдэлдэг, үүргээ ч биелүүлдэг, хариуцлагаа ч хүлээдэг.

Ингээд эрхийг нь өөр хүмүүс эрхийг нь эдэлчхээд үүргийг нь өөр хүмүүс биелүүлчхээд дахиад өөр хүмүүс хариуцлага хүлээдэг ийм л онгорхой, цоорхой юм, салан задгай, бие бие рүүгээ булчихсан ийм байдалтай бас байж болохгүй.

Тийм болохоор бас энэ замыг бас мэдээж Зам, тээвэр хөгжжлийн яамнаас бас хариуцаж байгаагийн хувьд хийлгэсэн шиг хийлгээд бас зээлийг аль болох хурдан хугацаанд үр ашигтай зарцуулах, энэ замыг чанартай тавиулах тал дээрээ илүү бас анхаарч ажиллана гэдгийг бас танд хэлье ээ.

Л.Мөнхбаатар: Гочоогийн Ганболд гишүүн тодруулж асууя.

Г.Ганболд: Би ажлын хэсгээс асууя.

Бямбацогт сайд мэдээж тэр гаднынхныг тэрэнд оролцуулахгүй байхыг л зорино л доо. Тэгээд гэрээндээ яг яаж заасан юм. Гэрээндээ одоо энэ зээл өгч байгаа тал нь Сэргээн босголт хөгжлийн банкнаас гүйцэтгэгч дээр нь заавал тэднийхтэй зөвшилцөх юм уу, үгүй юу, тэднийх нь зөвхөн мөнгөө өгөөд орхих юм уу. Энэ дээр гэрээн дээрээ л тусгах хэрэгтэй. Гэрээн дээрээ нарийн зааж л явахгүй бол бүх л зээл өгч байгаа газрууд оролцож байгаа шүү дээ. Тэгээд л оролцоод ирэхээрээ манайхан хугацаа хамгийн багадаа нэг жилээр хойшилно.

Тэгэхээр зөвхөн энэ биш цаашид ер нь бол Их Хурлаар орж ирж байгаа Засгийн газрын авч байгаа энэ зээлүүд бол ер нь бүгдийг нь нэгэнт хүүтэй зээл авч байгаа учраас манайх өөрөө л хөрөнгө мөнгөө удирддаг тендерээ шалгаруулдаг ийм хэлбэрээр л гэрээнд тусгаж байж

зээл авах нь зүйтэй шүү. Тэгэхгүй бол өмнөх зээлүүд бүгдээрээ манайх өөрөө бүрэн удирдаж чадахгүй байгаа. Тэгэхээр яг энэ гэрээн дээр яаж тусгагдсан юм, ажлын хэсгийнхэн хариулаад өг.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг нэмж хариулъя. Ажлын хэсгийн 86 дугаар микрофоныг өгье.

Л.Баянзул: Гишүүний асуултад нэмж хариулъя.

Зээлийн гэрээний дагуу гүйцэтгэгчийг болон сонгон шалгаруулалтын ажлуудыг хэрэгжүүлэгч байгууллага буюу Зам, тээврийн хөгжлийн яам шалгаруулж гэрээ байгуулна. Гэхдээ шалгаруулсан үнэлгээний хорооны тайлангаа бол Дэлхийн банкаар хянуулж зөвшөөрөл авах ёстой байгаа.

Зөвшөөрөл авна. Үнэлгээний хорооны тайлан дээрээ.

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу? Гочоогийн Ганболд гишүүн тодруулж асууя. Нэг минут.

Г.Ганболд: Үгүй ээ харин тэгэхээр чинь наадах чинь явахгүй шүү дээ. Одоо гэрээгээ эхлээд та нар тэгвэл тохирч байж оруулж ир л дээ дахиж. Наадах чинь хэтэрхий жижигхэн ажил байгаа байхгүй юу. Өмнөх Дарханы ажил чинь бол нэг том тендер байсан. Одоо наадах чинь тэгээд л нэг муу цэцэрлэг чиглэлийн, Хархорин цэцэрлэг чиглэлийн 13 км замын энэ муу арчилт гэхээр чинь нэг жоохон мөнгө байгаа шүү дээ. Тэрийг бас л хянуулна. Маш олон жижгэрчихсэн юмыг чинь бүгдийг нь тэгээд энэ Дэлхийн банкаараа ингээд хянуулаад явах юм бол наад ажил чинь мөд бүтэхгүй шүү дээ.

Эхнээсээ наад гэрээг нь тэгвэл тийм болгож байж оруулж ир л дээ. Тэгээд тийм боломж байгаа юу?

Л.Мөнхбаатар: Сая хэн хариулсан билээ? Нэр албан тушаалаа хэлээд хариулаарай. Протоколд бас тусаж үлдэх ёстой байгаа шүү.

Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Энэ өр Монгол Улсын өр нэмэгдэх нь ээ. Тэгээд өрийн асуудал болохоор л нөгөө АН-ынхан тийм ч бонд, ийм ч өр нэмэгдүүлсэн гээд л ярьдаг. Тэгэхээр энэ Засгийн газар дээр энэ асуудлаа бас яаж ярьсан юм. 110 сая доллар гэдэг бол бага мөнгө биш. Монгол Улсын иргэн бүрийн дөнгөж төрсөн хүүхэд бүрд ноогдож байгаа. Одоо энэ 33 сая төгрөг дээр дахиад иргэн бүрд 110 мянган төгрөг нэмэгдэх нь ээ. Өчигдөр сошиал орчинд нэг иргэн пост бичиж байна лээ. Одоо бид нарыгаа ингэж зовоож байхаар энэ өөр улсуудад хуваагаад өгчхөөч ээ гээд. Доод талд нь коммент хэсэгт нь зарим нь бид нарыг утаагүй, зарим нь түгжрэлгүй, зарим нь дайнгүй улсуудад хуваа гээд. Шог ч гэсэн бас энэ үнэн сонсогдож байна.

Тэгэхээр бид хэд иргэдээ бас ингээд зовоогоод баймааргүй байна аа? Өрийг нь нэмээд баймааргүй байна. Тэр улсын төсөв дээрээ бас хэдүүлээ яриад энэ замын арчлалтын асуудлаа шийдчихэж болох байсан. Төсөв батлагдаад сар болоогүй байна шүү дээ. Энэн дээр тэгэхээр Засгийн газар энэ өр нэмэгдүүлэх гэдэг тал дээр ямар байр суурь баримталсан юм болоо гэдгийг бас асууя.

Хоёр дугаар асуудал дээр нь энэ зам дээрээ одоо бид нар нэг арай л буруу бодлогоор яваад байх шиг санагдаж байгаа юм. Жишээлбэл Дарханы зам дээр одоо хэрвээ 4 эгнээ болгох байсан юм бол эхлээд тэр 2 эгнээг хуулдаг нь ямар учиртай юм.

Шинээрээ 2 эгнээгээ шинээр барьчаад дараа нь тэр хуучин замаа хуулаад 4 болгожхож болох л юм байсан

юм байна лээ шүү дээ. Тэгэхээр иймэрхүү бодлого ингээд буруу явж байна. Тэр шинэ Нисэх рүү явж байгаа зам. Энийг яагаад тэр хуучин Нисэхийн уулзвар дээрээс эхлээд 2 зам зэрэгцээд давхиад байгаа юм. Энийг явуулаад зүүн талаар явуулаад тэр Дундговь салдгаар уруудуулаад тэгээд тэндээс нь шинэ Нисэх рүү яагаад зам тавьчихаж болоогүй юм. Төв аймгийн Зуунмодын иргэд тэр шинэ замаар явж болох л тийм нөхцөл байдал байсан шүү дээ. Бусад улсуудад тэр Хятад энэ тэр чинь нисэх буудлууд руугаа явах зам энэ тэрээ иргэд нь давхар яваад болоод л байдаг юм байна лээ шүү дээ.

Тэгэхээр иймэрхүү алдаа бас замын бодлогууд дээр гарах вий дээ. Одоо та сая хэлж байна. Энэ Налайхаас цааших, Дарханаас цааших замуудыг 4 эгнээ болгоно гэж байна. Тэгэхээр энэ дээр бас энэ өмнөх энэ байдлуудыг бас бодолцож үзээрэй, бодолцож үзэх үү гэдэг ийм асуулт байна. Энэ замууд дээр одоо жишээлбэл энэ Төв аймгийн сумдууд руу Төв аймгууд дээр гээд хүмүүс бас яриад байна. Энэ сумын зам гээд арай ондоо шүү. Ачаалал өндөртэй дээрээс нь түрүүн хэлсэн ХАА-н гаралтай цэвэр бүтээгдэхүүн хүнсээр нийслэлийн иргэдийг хангах гэдэг энэ асуудал байгаа юм. Зам байж байж энэ цэвэр шинэ бүтээгдэхүүн иргэдийн хүнсний хэрэгцээнд орж ирнэ. Тэгэхээр энэ асуудлууд дээр нэлээн хэдэн зам явж байгаа. Тэгэхээр энэ дээр онцгойлж 2, 3 зам асууя аа.

Замын асуудал орж байгаа дээр. Энэ Төв аймгийн Жаргалант сумын салдгаас Орхоны зам. Бид хэд бас ярьж байгаад Европын сэргээн босголт хөгжлийн банкныхантай уулзчихаад энэ зам ингээд явчих юм шиг байна л даа. Явахаар ингээд шийдэгдчихсэн байгаа. Тэгэхээр энэ зам бол бараг 97 км жишээлбэл Орхон хүртлээ татуу зам болж таарах гэж байгаа. Тэгэхээр энэ бодлого энэ тэр чинь бас янз бүрийн байдлаар өөрчлөгдчихгүй биз дээ. Энэ

дээр нэг яг сайдын албан ёсны хариултыг нэг сонсчихъя.

Төв аймгийн Мөнгөнморьтын зам гээд одоо нэг аль хэвийн эхлээд мөнгө нь даваад яваад одоо бүүр эзэн ч үгүй болчихсон нэг ийм зам нутгийн иргэн болгон асууж байна. Энэ зам маань юу болчхов гээд. Энэ дээр сайд нэг яг албан ёсны нэг эцсийн хариулт, тэгэх нь ээ гэдэг хариултыг өгөөдхөөч. Би удахгүй Мөнгөн морьт орно.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулсны дараа асуултад хариулаарай.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам, Жаргалтулгын Эрдэнэбат, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Сүхбаатар сумын ЕБС-ийн 12^а ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Хүүхэд залуучууд та бүгддээ сурлагын өндөр амжилт, сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе өө.

Асуултад хариулъя Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт хариулъя.

С.Бямбацог: Нөгөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан нөгөө өрийн шаардлага энд хязгаартай бол нийцэж байгаа юм байна лээ. Сангийн яамныхан түрүүн бас хэд хэдэн удаа хариулах шиг боллоо. Ер нь бол бид нар нөгөө гаднаас зээл авахдаа тэр авч байгаа зээлийнхээ үр өгөөж эдийн засгийнх нь болон бусад шууд болон шууд бус гээд олон утгаас нь харах ёстой байх. Энэ замууд барихдаа ч гэсэн бид нар улсын төсвийн хөрөнгөөр барьж байгаа улсын төсвийн хөрөнгөөр барихаас гадна гадаадын зээлээр, тусламжаар бас барьж байгаа. Ийм байдлаар л барьж байгаа. Улаанбаатар хотод барьсан гүүр гэхэд чинь жишээ нь 2 давхар гүүр, нарны

гүүр, Японы хөнгөлөлттэй зээлээр, энэ сарны гүүр гэж замын цагдаагийн гүүрийг чинь бас Хятадын хөнгөлөлттэй зээлээр ч гэдэг юм уу. Гадагшаа гэх юм бол баруун босоо зам Азийн хөгжлийн банкны зээлээр 750 км зам, Орос, Хятад, Ази, Европ холбосон сайхан замтай болчихсон байна.

Дархан, Улаанбаатар, Эрдэнэтийн замыг бас Азхийн хөгжлийн банк, Европын сэргээн босголтын банк санхүүжүүлж барьж байгаа. Ийм байдлаар үндсэндээ бол зам бол чухал юм аа. Эрчим хүч чухал юм аа. Энэ томоохон дэд бүтцийн асуудлууд ерөөсөө ингээд төсвийн хөрөнгө оруулалт болон бас гаднын зээл тусламжаар барьдаг бодлого өнгөрсөн 30 жилийн хугацаанд явж ирсэн. Одоо ч энэ бодлого хэвээрээ. Энд юу гэдэг юм Ардын намын үед, Ардчилсан намын үед гэж ярих шаардлагагүй байх. Энэ бол үндсэндээ ингээд л явж байгаа. Яагаад гэвэл зайлиггүй одоо төр хариуцах ёстой, төр шийдэх ёстой төр шийдэх гээд оролдоход төсөвт мөнгө төсвийн ачаалал хүрэхгүй байгаа учраас гаднын зээл тусламж авдаг. Өмнө нь ч ингэж явж байсан одоо ч ингэж явж байгаа.

Яг л энэ жишгийн дагуу л үндсэндээ энэ замуудыг зайлиггүй шинэчлэх их засвар хийх шаардлагатай байна. Энэ замын эдийн засгийн үр өгөөж нь Монгол Улсын ард иргэддээ аж ахуйн нэгжүүддээ хэрэгтэй юм байна гэдэг агуулгаар үндсэндээ энэ төсөл маань яригдаад олон жил яригдаад ингээд орж ирж байгаа юм байна лээ. Тэр зам барих технологи дээр Дарханы замыг хуулахгүй байж болохгүй. Тантай яг санал байна. Ер нь Дарханы зам дээр бид нар алдчихсан юм байна лээ. Хуучин байсан зам нь эвдэрхий ч гэсэн байж байх ёстой. Хажуугаар нь тийм үү шинэ 2 урсгалтай нэг эгнээ замаа барьчихаад дараад нь дахиад нөгөөдхийг нь бариад. Ингээд ийм байдлаар яваад үндсэндээ Дарханы чиглэл миний харж байгаагаар 6 эгнээ зам байх бололцоотой байсан. Тэр 2, 2 эгнээтэй шинэ барьсан зам нь төлбөртэй явдаг.

Дарханы зам нь тийм хуучин зам төлбөргүй явдаг. Ард иргэд нь төлбөргүй явдаг. Ийм байдлаар шийдэх ёстой байсан юм байна лээ.

Энэ дээр шийдэл жаахан алдаа гарсан юм байна лээ. Бид нар урагшаа тавих Замын-Үүдийн замыг бас Налайхаас Замын-Үүд хүртэлх замыг ийм байдлаар тавих гэж байгаа. Одоо байгаа зам нь байдгаараа байж байна. Тэр замынх нь хажуугаар бид нар төлбөртэй зам барина. Ингээд иргэд нь хурдан замаар тийм өндөр даацын ачаатай явъя гэх юм бол төлбөртэй зам дээгүүр явж болдог. Төлбөргүй ингээд явъя гэх юм бол төлбөргүй замаар явж болдог ийм байдлаар үндсэндээ цаашидаа зам тавина аа.

Цаашилаад ч гэсэн бид нар Лүн чиглэлд 4 эгнээ зам та бүхэн мэдэж байгаа. Цагаан сарын дараа, наадмын үеэр үндсэндээ хэдэн хоног бид нар Лүн хүртлээ түгжирдэг. Цаашаагаа Эрдэнэсанта хүртэл түгжирдэг. Энэ замуудыг бас 4 эгнээ болгох ийм өндөр ачаалалтай замуудыг 4 эгнээ болгох ажлуудыг бас үе шаттайгаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон гаднын зээл тусламжаар шийднэ ээ. Ийм бодлого барьж байгаа шүү гэдгийг танд бас хэлье. Зам байж цэвэр шинэ бүтээгдэхүүн Улаанбаатарын ард иргэдийг хангадаг гэж тантай санал нэг байна аа. Яах аргагүй Төв аймаг, Сэлэнгэ тийм манай газар тариалангийн бүс нутгаас экологийн цэвэр шинэ хямд бүтээгдэхүүн тэр зам сайтай байж л орж ирж байгаа. Зам сайтай байж байж, зам муу байх юм бол тэр Жаргалантын зам эвдэрхий байх юм бол тэндээс сүү, мах нь тэрийгээ дагаад өртөг нь өндөр. Өндөр үнэтэй сүү, өндөр үнэтэй мах, өндөр үнэтэй төмс, хүнсний ногоо орж ирдэг. Энэ агуулгаар бид нар замыг аль болох хүрэлцээ нийлүүлэлт нэмэгдүүлэх хэмжээгээрээ илүү тээвэрлэлт нь хурдан болно, тээвэрлэлт

нь хурдан болох хэмжээгээрээ зардал нь бага болох хэмжээгээрээ үнэ нь буурна.

Энэ агуулгаар үндсэндээ эдийн засагт шууд бус өгөөж нь зам дагаж хөгжил гэж агуулга нь ийм агуулгаараа бас хэрэгтэй байх.

Тийм учраас энэ замаа л ерөөсөө сайжруулж байх ёстой юм байна лээ. Аль болох ахиу зам барих, аль болох барьсан замуудаа засах.

Г.Занданишатар: Ажлын хэсэг нэмж хариулъя. 84.

Ц.Эрдэнэ-Очир: Туваан гишүүний асуултад хариулъя.

Дарханы зам маань Жаргалантаар салаад Орхоны гүүр орж байгаад Эрдэнэт рүү хамгийн дөт зам гэж төлөвлөж байгаа зам л даа. Энэ бол улсын төсөвт бол тусгагдсан байгаа. Та түрүүн мэдэж хэлж шиг байна явахаар болж байх шиг байна гэдэг нь энэ жилийн 2024 оны улсын төсөвт тусгагдсан. Харин Мөнгөнмортын 60 км замын хувьд бол барилгын ажлын шатанд маргаан гарсан. Үндсэндээ яг хариуцлага алдсан учраас гэрээ цуцлагдсан асуудал байгаа юм аа. Тэгээд энэ асуудал нь бид нар шүүхэд хандчихаад байгаа юм.

Г.Занданишатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн тодруулж асууна. Нэг минут.

Ц.Туваан: Ажлын хэсгээс нэг хэдэн зүйл тодорхой асуучихъя. Энэ Батсүмбэрийн зам байгаа. Ахмадын асрамжийн зам. Би бас буруу ойлгосон байж магадгүй. Энэ зам арчлалтын энэ батлагдахгүй сумдууд руу тавих замыг бас болиулна гээд. Тэгэхээр улсын төсөв батлагдсан юм чинь арай тэгэхгүй байх. Тэгэхээр Батсүмбэрийн зам дээр хойд талаараа явна гэдэг концепц нь хэвээрээ ажлын хэсэг бүүр нэг микрофонд хариулаад өгөөрэй. Дараа нь

өөрчлөгдчихөж магадгүй гэж бодоод. Угтаал, Цээл, Заамарын зам яг хэдэн онд дуусах вэ? Мөнгөнмортын зам шиг ингээд зогсоод хүмүүс нь алга болоод шүүхийн шат руу гээд энэ бүүр заваарсан юм болох юм. Тэгэхээр яг энэн дээр хэзээ дуусах вэ?

Дараагийн нэг тодорхой асуулт нь Төв аймаг, Дундговь, Өмнөговийн замын эвдэрсэн асуудал дээр энэ зээлийн мөнгөнөөс хэдэн төгрөг тусгагдах вэ гэсэн ийм тодорхой 3 асуултад хариулт авъя. Ажлын хэсэг.

Г.Занданишатар: Бямбацогт сайд хариулна.

С.Бямбацогт: Улсын төсөвт тусгагдсан хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ бол яг тэр юундаа зарцуулагдана аа? Энийг ямар нэгэн байдлаар өөрчлөхгүй ээ. Өөрчлөх тохиолдолд зөвхөн Улсын Их Хурал өөрчилнө. Тийм болохоор та юу гэдэг юм Батсүмбэрийн зам тавигдахгүй болчих вий гэдэг санаа битгий зовоорой. Яг тэрнийхээ дагуу зарцуулагдана.

Тэр Жаргалантаас нөгөө шар хөтөлөөр даваад Орхоны чиглэлийн нөгөө төсөв тавигдсан байгаа. Энэ бас үр аш ашигтай зам. Заавал зөвхөн Жаргалант гэхгүй цаашаа Булган, Эрдэнэт, Хөвсгөл явж байгаа иргэдэд бас хэрэгтэй. Тийм болохоор Даханаар тойрохгүйгээр явах энэ зам ирэх жил хийгдэнэ. Мэдээж хуучин Тендерийн худалдан авах ажиллагааны тухай хуульд өөрчлөлт орсон. Энүүгээр ерөөсөө гүйцэтгэх компаниудыг хар жагсаалтад оруулдаг. Хар жагсаалтад оруулахдаа зөвхөн тухайн компанийг биш, тухайн компанитай хамааралтай тэр хүний хамааралтай бүх компаниудыг төрийн худалдан авах ажиллагаанд оролцуулахыг хориглож байгаа. Ийм байдлаар үндсэндээ бол хуульд өөрчлөлт орсон. Үүнтэй холбоотойгоор үндсэндээ энэ төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ

худалдаж авах гүйцэтгэж байгаа компаниуд илүү хариуцлагатай, илүү ажлаа чанартай хийх болно.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: Баярлалаа. Дэлхийн банкны санхүүжилттэй 100 сая доллар 110 сая долларын асуудал яригдаж байна аа. Энэ анх төлөвлөсөн байдал нь бол манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдэрийн яаманд 28 сая доллароор төлөвлөсөн байсан. Энэнээс манай яам татгалзсан. Тийм татгалзсан бичгээ Зам, тээврийн яам энэ Дэлхийн банканд Сангийн яаманд өгсөн. Учир нь яагаад татгалзсан гэхээр хөдөө аж ахуйн ложистикийн төв байгуулна. Тэр Өвөрхангайд эмэгтэй малчдыг сургана гээд. Яг тооцоод үзэхээр хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд ХАА-н салбарт олигтой юм үлдэхээр юм байхгүй байсан юм.

Тийм учраас энэ манай хөдөө аж ахуйн салбарт зарцуулна гэсэн. Манайхтай бодлогын хувьд нийлээгүй. Энэ зээлээ тэр зам засварт зам тавих ажилд тавь. Тэгээд Бямбацогт сайдтай ярилцсан. Тэр тамын 50 гэж олон хүний амь нас эрүүл мэндээр хохироосон ийм зам байдаг юм. Энэ дээр тавихыг зөвшилцөн ингээд тавина гэсэн. Харин Бямбацогт сайдаас яахад яг тамын 50 дээр хэдэн төгрөгийг нь тавиад байна? Бүрэн тавьж байгаа биз дээ? Ирэх жил дуусгах уу? Ер нь тендерийг нь эртхэн зарлаад эртхэн сайн ажлыг явуулах хэрэгтэй шүү гэдгийг хэлье ээ. Энийг асууя.

Тэр олон жил хүмүүсийн зовоосон эрүүл мэнд амь насаар зовоосон энэ замыг засах цаг нь болсон. Бид нар төсөв дээр бүрэн тавьж чадахгүй байсан. Энэ талаар Бямбацогт сайдаас хариулт сонсьё.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учралын урилгаар Пабжи

мобайл цахим спортын ДАШТ-ий аварга баг болон шагналт байр эзэлсэн багийн тамирчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Энэ спорт цахим спорт цахим эдийн засаг болсон цахим эдийн засаг дэлхийн ирээдүйн чиг хандлагыг тодорхойлж байгаа. Цахим спорт цахим эдийн засгийн нэг хэсэг болж бараг 3.8 тэрбум долларын ийм эргэлттэй эдийн засаг болсон. Энэ чиглэлд манай энэ цахим тамирчид, цахим спортын тамирчид маш амжилттай оролцож байгаа.

Энэ **IATA - АНС**, ер нь энэ дэлхийн аваргын цахим спортын дэлхийн аварга болоод Зевс баг байхдаа 3 дугаар байранд, 4 дүгээр шатлалд 4 дүгээр байранд манай энэ цахим спортын тамирчны багууд бас идэвхтэй орж байгаа. Сталворд баг байна. Эйч Си-гийн баг байна. Тэгээд энэ Зевс баг байхдаа эд нар ингээд орж байсан. Ийм дэлхийд энэ том эдийн засагт хүчээ сорьж байгаа энэ залуу тамирчдадаа өндрөөс өндөр амжилтыг хүсэж, Монголынхоо нэрийг дэлхийд цахим ертөнцөд дурсах болтугай гэж хүсэн ерөөе. **АЖС** спортын 2019 оноос Зевс баг байхдаа 2020 онд 3 дугаар байр эзэлж байсан, 2 дугаар байр стал боард и спортс 2022 онд 4 дүгээр байр эзэлж байсан. 4 дүгээр байрыг Фор Мерикал Вайбс гэдэг багт орж байсан. Ийм бас их залуучууд байгаа. Бямбацогт сайд асуултад хариулна аа.

Сандагийн Бямбацогт сайд хариулна.

С.Бямбацогт: Энэ зээлийн хэлэлцээр үндсэндээ 2018 оноос хойш судалгаа хийгдээд 2020 оноос тодорхой шийдэл гараад Их Хуралд 2022 онд өргөн бариад Их Хурал дээр нь жил гаруй хэлэлцээд 2, 3 буцаж байж орж ирж байгаа л даа. Ингэхэд бас манай Болорчулуун сайд тэр хөдөө аж ахуйн салбарт тэр махны ложистикийн агуулах хэрэггүй ээ энэ салбарын тэр зээлээс татгалзъя гэдэг санал гаргасан. Мөн бас

Өвөрхангай аймагт хэрэгжүүлэхэд нь бас Өвөрхангай аймгийн гишүүд маань бас хүлээцтэй хандаад бас зам руугаа зарцуулах нь зөв юм байна аа. Дорнодын тэр тамын 50 гэсэн замыг засахад эх үүсвэр байхгүй тэр рүү зарцуулах нь зөв өө гэсэн бас ийм саналууд хэлж байсан.

Ингэсний үр дүнд үндсэндээ бүрэн хэмжээгээрээ энэ 110 орчим сая доллар бүгд авто замын их засвар гүүр барьж байгуулахад энэ ажилд зарцуулагдахаар болсон. Дорнод энэ хүрээндээ үндсэндээ тэр Өндөрхаан Чойбалсан чиглэлийн тэр тамын 50 гэж нэрлэгддэг энэ 50 км замын эх үүсвэр шийдэгдсэн. Уул нь эх үүсвэргүй байсан. Ингэж шийдэгдсэн байгаа. Ингээд үндсэндээ 1 км-ийг нь их засвар 300 орчим мянган доллар буюу 50 км замыг 15 сая орчим доллароор ингэж засаж бүрэн хийж дуусгана. Ийм байдлаар мөнгө нь суусан байгаа гэдгийг танд хэлье ээ. Өөрөөр хэлэх юм бол олон жил ард иргэдийг зовоосон олон хүмүүсийн амь нас авсан Монголын хамгийн их эвдрэлтэй зам. Уг нь баригдахдаа бол байна шүү дээ 2015, 2016 онд баригдсан юм байна лээ. Тэгээд баригдаад л 5, 6 жил болоод л эвдэрчихсэн ерөөсөө.

Хариуцлага тооцоод шүүхэд өгөөд шүүхээс 7 тэрбум төгрөгийн хохирол барагдуулсан. Тэр замыг засахад 60 тэрбум төгрөг хэрэгтэй. 60 тэрбумыг шүүхдээд зам дээр бид нар шүүхдээд 5, 6 жил шүүхдэж байж 7 тэрбум төгрөг л олж авсан юм байна лээ. Ийм байдлаар ингээд шийдэж байгаа. Тэгээд үндсэндээ Дорнодын тамын 50 бол засагдана аа. Тэр компани үндсэндээ хар жагсаалтад оруулахаар саналаа өгсөн. Хар жагсаалтад орсон. Тэр замыг барьсан Чайна Жое инженер гэж компани хар жагсаалтад орсон. Монголд дахиад үйл ажиллагаа тендерт орохгүй.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Ойрд их юм ярьсан ч үгүй асуусан ч үгүй. Ер нь энэ улс орон чинь болж байгаа бүтэж байгаа юм ер нь их цөөхөн байгаа юм биш үү? Тэгээд л ахиад л бас нэг өр тавих гээд л ингээд л ороод ирж байх шиг байна. Тэгээд энэ сүүлийн үед зээлийн хүү аягүй өндөр байгаа шүү дээ. Тэгээд нөгөө нэг Чингис бондыг л байнга л яриад байдаг. Чингис бонд чинь маш бага хүүтэй байсан шүү. 3.5 ч байна уу, 3 ч байна уу тийм л байсан. Хугацаа ч урт байсан. Одоо наадах чинь хүү мүү нь ямар юм бэ?

Тэгээд л нэг 7, 8 хувийн хүүтэй зээл олж ирчхээд л тэрийгээ нэг их гавьяа байгуулчихсан юм шиг юм яриад л. Эцэст нь Монголын ард түмэн төлдөг болохоор яав л гэж дээ гэсэн ийм л байдалтай юманд хандмааргүй байна аа. Тэгээд энэ юмнууд чинь хэр оновчтой юм бэ? Энэ юмаа нэг оновчтой болгомоор байна. Авч байгаа зээлээ зориултаа. Ийм зүйлүүдийг би асууж байна. Тэгээд энд тэнд тараад л бутраагаад л тэгээд хийсэн ажил болгон чинь нэг янз янзын нэртэй болчихоод байна шүү дээ. Мухар замууд, мухар төмөр замууд, хамгийн 18 дугаар үеийн гучхан километрийн хурдтай төмөр замтай иймэрхүү нөхцөл байдалтай л энэ улс орон ингээд явж байна.

Бензин ч байхгүй, цахилгаан тог ч байхгүй. Юмны үнэ нь өндөр болчихсон. Шинэ жилийн өмнө иймэрхүү юмаар л бэлэг барьж байна даа Монголын ард түмэнд. Гэхдээ энэ мэдрэмжийг бол Монголын ард түмэн мартажгүй ээ. Энэ чинь 30 жил тийм юм үзээгүй хараагүй явж байсан ард түмэн чинь 8 жил засагчхаад ийм юмыг үзүүлж байгаа байхгүй юу.

Гайхамшиг ингээд үргэлжлээд байх юм байна л даа. Тэгээд энэ мөнгөө энд тэндгүй яасан их тарж бутрааж тавьдаг юм бэ. Аль болохоор хүн очихгүй явахгүй газар дээр хэдэн төгрөг тавиад үр дүн нь мэдэгдэхгүй юмнаас

сонгуулийнхаа мөнгийг босгодог, тэр юм руу шилжих гээд байна уу. Баруун аймаг руу явдаг зам байгаа. Арвайхээр, Баянхонгор гээд. Энэ замаа нэг мөсөн сайхан засчих л даа. Та нар тийшээ чинь Ховд руу явж байна, Баян-Өлгий рүү явж байна бүгд дамжиж байна шүү дээ. Ийм зүйлүүдийг хиймээр байна аа.

Нөгөө талаар тэр малчин эмэгтэйчүүдэд үгүй ээ тэр платформ гэж ярьж байх шиг байна. Хоорондоо тэгээд найр тавиад л ийм ийм сайхан болчихсон гээд л бие биеэ магтаад л байх юм. Үгүй ээ нэг үр дүнтэй ажил хий л дээ. Тухайлбал хорт хавдар гаарчихсан, ходоодны хорт хавдраар гэхэд Монгол Улс нэг номерт орчихсон байна шүү дээ дэлхий дээр. 7, 8 жилийн өмнө нэг хэдэн битон тараасан одонтой ээжүүддээ, хувийнхаа мөнгөөр. Тэгээд бас хэдэн хуванцар шанагыг нь сольж өгсөн. Одоо манай Баянхонгор аймаг хорт хавдраар Монгол Улсдаа хамгийн бага нь байна шүү дээ. Тэр платформ гэж юу яриад байгаа юм бэ? Ямар платформ яриад байгаа юм? Иймэрхүү үр дүнтэй ажлуудыг эрэмбэлж хиймээр байх юм нөхдүүд ээ.

Бид нар чинь одоо тэгээд нэг их тэгээд гарлагадаа гарчихсан илүү дутуудаа гарчихсан ийм мөнгөтэй ийм улс орон ч биш. Энэ дээр нөхдүүд юу бодож байна вэ? Та тэр одоо Бямбацогт сайд Монголын төмөр зам дээр анхаарал тавиад байгаа юм шиг юм шиг байна лээ. Тэр зөв шүү. Тэр хамгийн хоцрогдсон салбар гэж өөрөө ярьж байх шиг байна лээ дэлхий дээр, Монгол Улсдаа. Тэр дунд шатны хэдэн дарга нар авлигад идэгдсэн шүү дээ энэ дээр. Энэ зам ч гэсэн Дарханы замыг хар. Хэчнээн жил хийлээ ямар үр дүнтэй юм боллоо. Ер нь та нар наад зээл мээлээ больчихоод энэ сонгуулийн дараа болбол яасан юм. Авбал авчихъя, тэрийг нь хугацааг нь хойшлуулчихъя. Айн байгаа юу? Тэр нь шалихгүй юм байна билээ.

Л.Мөнхбаатар: Ганбат гишүүн ерөнхийдөө байр сууриа илэрхийлээд үг

хэлчихлээ гэж ойлгох уу? Асуултад хариулъя. Тэгвэл Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Яах вэ энэ зээл авахгүй нөгөө Баянхонгор явах зам засагдахгүй л дээ. Өвөрхангай, Арвайхээр, Арвайхээр, Баянхонгор гээд үндсэндээ 150-аад километр зам байгаа. Тэгээд Баянхонгор луу явж байгаа, Ховд руу явж байгаа, Говь-Алтай руу явж байгаа, Өвөрхангай руу явж байгаа олон иргэд бүгдээрээ л энэ зам дээгүүр зорчиж байгаа. Энд бас хамгийн их нь Баянхонгорынхон их явдаг байх. Ховдынхон чинь бараг онгоцонд суучихдаг юм шүү дээ гээд тийм болохоор ууул нь бас хэрэгтэй л юм байгаа юм зам засахад. Тэгээд хүүгийн тухай түрүүн ярьсан.

Өнөөдөр дэлхий нийтээрээ банкны хүү өндөр болчихсон. Арилжааны банкнуудын хүү Монголд 20 хувьтай байна. Монголбанкны бодлогын хүү 13 хувьтай байна. Монголбанкны бодлогын хүү чинь 6 хувь хүртэл буурч байсан шүү дээ. Та бүхэн мэдэж байгаа байх. Гаднаас мөнгө авахад бид нар тийм үү маш бага хүүтэй мөнгө авдаг байсан. Одоо яах вэ дэлхий нийт мөнгө өндөр болчихсон гэхдээ хөвөх ч хүүтэй юм байна лээ. Тэгээд Чингис бондын хүү 5.25 хувийн хүүтэй 4.25 хувийн хүүтэй зээл авч байсан. Үндсэндээ энэ энэ бол 5, 6 орчим хувийн хүүтэй зээлээр бид нар замаа засах гэж байгаа юм байна лээ. Ийм зээл гаднаас авч байгаа. Ингэж та ойлгоорой.

Яах вэ болж байгаа бүтэж байгаа юм ч байгаа, болохгүй бүтэхгүй юм ч байгаа. Аль алин дээр бас асуудал байна аа. Нэг тулгамдсан асуудал шатахуун дээр жсоохон бас сая нэг жсоохон тулгамдсан асуудал үүсэх шиг боллоо. Ард иргэдийг бухимдуулсан юу гэдэг юм ногоон автобусны асуудал бас байх шиг байна.

Гэхдээ Монгол Улсын эдийн засаг өсөж байна эдийн засгийн өсөлтийг бас

ард иргэдийнхээ амьдралд наалдуулах тал дээр бас Монгол Улсын Засгийн газраас чадлаараа л хичээж анхаарч ажиллаж байгаа. Зөвхөн одоо би өөрийнхөө хариуцсан зам, тээврийн салбартай холбоод хэлэхэд түүхэндээ анх удаагаа бид нар 100 сая тонн ачаа тээвэрлэх гэж байна. Өнгөрсөн жил 2022 онд бид нар 60 сая тонн ачаа тээвэрлэж байсан. Бид нар 100 сая тонн ачаа тээвэрлэх гэж байна. Түүхэндээ анх удаагаа. Энэ хэмжээгээр үндсэндээ эдийн засаг өсөж байгаа. Энэ хэмжээгээр тээвэрчдийн орлого нэмэгдэж байгаа гэсэн үг. Монгол Улсын эдийн засагт үр өгөөж орж байгаа гэсэн үг.

60 сая байсан, 100 сая болж байна. Гадагшаа явдаг иргэдийн маань тоо 3.5 дахин нэмэгдсэн байна. 3.5 дахин. Монгол Улс руу ирж очдог хүмүүсийн тоо 3.5 дахин нэмэгдсэн. Онгоцны билетийн үнэ олон улсдаа ч тэр, дотооддоо ч тэр 2-оос 3 дахин буурлаа. Урьд нь Сүүл рүү 3 саяар явдаг байсан бол одоо сая төгрөгөөр явдаг болсон байна.

Ховд руу сая 800 мянга, сая 600 мянгаар нисдэг байсан одоо 800 мянгаар 2 талдаа нисдэг болж байна. Гурав, дөрөвхөн аймагт орон нутгийн нислэг явж байсан бол 9 аймагт онгоц нисдэг боллоо. 9 аймагт Монгол Улсын төмөр зам хэдийгээр бас хоцрогдсон гэж хэлж байгаа ч Улаанбаатар төмөр зам түүхэндээ байхгүй. Намайг ажил хүлээж авч байх үед 2020, 2022 онд 60 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан 2023 онд 70 тэрбум төгрөгийн ашигтай ажиллах гэж байна. 70 жилийнхээ ирэх жил 75 жилийнхээ ойг Улаанбаатар төмөр зам тэмдэглэнэ. Түүхэндээ тийм 32 сая тонн ачаа тээвэрлэсэн ийм төмөр замаар тээвэрлэсэн ийм амжилт гаргах гэж байна. Мөн ажилтан албан хаагчийнхаа цалинг түүхэндээ байхгүй өндөр хэмжээгээр нэмэгдүүлсэн ийм бас амжилт гаргах гэж байна гээд ярих юм жишээ нь.

Манай салбарт бас тодорхой үр дүн гарч Эрээнээс Улаанбаатар хүртэл ачаа 25 мянган юаниар явдаг байсан нэг машин ачаа. 2500 юаниар явдаг болсон 10 дахин буурсан байна. Тээврийн зардал. Гэх мэтчилний тодорхой бас ажлуудын үр дүн гарч байгаа. Тэгээд та бас нэг авах гээхийн ухаанаар мэдээж сайныг нь сайн мууг нь ингээд зөвийг нь зөв, бурууг нь буруу гэдгийг үндэснээс харж байгааг ээ гэдгийг танд бас хүсье ээ. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тодруулчихъя. Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Манай Зам, тээврийн сайд тэгээд хариуцлагатай хэлж байх шиг байна. Арвайхээр-Баянхонгорын зам бол 150 км засагдах нь ээ гэж ойлголоо. Уул нь 220 км байдаг юм. 210 орчим. Уг нь гүйцээгээд нэг мөр юм хийчихмээр байгаа юм аа. Чингис бондоор цементийн асуудлыг бүрэн шийдсэн шүү дээ. Хэдийгээр муу нэртэй янз бүр байдаг боловч. Тэрийг бас хэлчих хэрэгтэй. Нөгөө талаар бол энэ хугацаа чинь ямар байх юм бэ? Эргэн төлөгдөх хугацаа чинь. Хүү бол одоо Чингис бондтой харьцуулахад 7 гаран хүүтэй юм байна шүү дээ энэ чинь. Бас л их өндөр хүү шүү. Долларын зээл гэхэд бол. 4 хувийн хүүтэй авч байсан юмыг одоо ингээд л 7 хувийн хүүтэй зээл авч байна аа. Яах вэ дэлхий нийтийн нөхцөл байдал ийм юм байна гэж ойлгоё. Гэхдээ энүүгээр маш үр дүнтэй зөв ажил хийх ёстой шүү гэдгийг бас анхааруулья.

Ямар нэгэн авлига энээ тэрээ юм байхгүй шүү. Тэгээд сонгуулийн өмнө оруулчих хэрэгтэй байна аа. Та нар наадхаа. Хурдан түргэн хийгээд. Мөнгө нь бэлэн байгаа юм юу байх вэ дээ. Засвар юм чинь. Тэгээд нэг нөхөөс хийж байгаа юм гээд л нэг хачин хачин юм хийдэг шүү айн. Тэрүүгээр та бид нар бүгдээрээ явна. Тэгээд бас л нөгөө нэг та нарын хэлдгээр нөгөө та нарын үе чинь бүх замууд чинь янз бүрийн нэр хочтой болчихсон байна шүү дээ. Тамын гээд л тэ. Тэгээд л явж байгаа хүн болгон л хараал хэлэх вий дээ

айн. Тийм их мөнгөөр хийчихээд ийм муухай юм болох гэж энэ тэр гээд л ярих нь байна шүү дээ. Тэгээд хугацаа нь ямар байгаа юм. Дархан бол одоо тэгээд 7, 8 жил хийгээд. Нөгөө хүүхдүүд нь дөнгөж төрсөн хүүхэд сургууль соёлд ордог ийм зам. 200, 300 хүн нас барсан зам гээд ийм нэртэй болчихсон шүү дээ. Ард түмэн ч сайхан нэрлэх юм даа. Та нарын ажлыг тэрүүгээр л дүгнэх юм.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл, Ганибалын Амартүвшин, Тогмидын Доржханд нарын урилгаар Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил амьдралд нь сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе өө. Одоо Төмөртогоогийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Ямар ч байсан зээл аваад энэ замаа засах юм байна. Эвдэрсэн замаа ямар ч байсан засаж арчлах юм байна гэж бодож байна аа. Ер нь цаашидаа Зам, тээврийн яамнаас барьж байгаа бодлогууд бий юу? Ялангуяа Замын-Үүд, Эрээний боомт 24 цагийн үйл ажиллагаанд шилжих гэж байна. Улаанбаатар төмөр замын ачаа эргэлт их болсон. Улаанбаатар төмөр зам үндсэндээ даацаа дийлэхээргүй болсон байж байгаа. Ачаа зөөж чадахгүй болсон их хэмжээгээр.

Тийм учраас нөгөө Замын-Үүдээс Налайх хүртэл хатуу хучилттай хүнд даацын зам тавих ажил ер нь яаж шийдэгдэж байгаа вэ? Энэ дээр юу гэдэг юм олон улсын банк ч байдаг юм уу Азийн хөгжлийн банк ч гэдэг юм уу дэлхийн банк ч гэдэг юм уу ийм газраас мөнгө босгоод

энэ замыг барих бололцоо боломж байна уу?

Одоо 24 цагийн үйл ажиллагаанд шилжих юм бол үндсэндээ Замын-Үүдээр явж байгаа нурмаг ачаа нэмэгдэнэ. Тэгээд бид нарын одоо явж байгаа зам бол 44 тонны зам байгаа шүү дээ. Тийм учраас энүүгээр нурмаг ачаа зөөгөөд ингээд байх бас бололцоо боломж бас муутай байж байгаа юм аа. Тийм учраас цаашидаа бол тэнд хүнд даацын 100 тонны энэ авто замаа яаралтай барих юм бол Монгол Улсын эдийн засаг бас нэлээн өсөх Замын-Үүдийн 24 цагийн үйл ажиллагаа ч гэсэн нэлээн идэвхтэй явах, эдийн засаг өсөх ийм бололцоо боломж байна аа.

Ер нь одоо бид нар эдийн засагтаа орлого оруулж ирж чадах орлогоо нөхөх ийм бололцоо боломжтой л энэ замуудаа л яаралтай барих хэрэгтэй байж байна. Замын-Үүд-Налайхын замыг барьчих юм бол 2, 3 жилийн дотор л юу гэдэг юм зээлээ төлчихнө шүү дээ.

Тийм учраас энэ зээл авах энэ асуудал дээр Зам, тээврийн яам, Зам, тээврийн сайд ямар бодлого барьж байгаа юм бэ? Энэ ажил өдий 2024 онд эхлэх ийм бололцоо боломж байна уу? Энэ дээр нь нэг хариулт хэлж өгөөч ээ гэж хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Сандагийн Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Замын-Үүд-Улаанбаатар чиглэлийн зам маш чухал зам аа. Түүрүүн би хэлсэн. Монгол Улс Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд гээд 70 жилийн хугацаанд ганцхан төмөр замтай, ганцхан авто замтай байсан. Замын-Үүд-Эрээний боомтыг хүчин чадлыг нэмэгдүүлэх төмөр замын болон авто замын хүчин чадлыг нэмэгдүүлэх тодорхой ажлууд хийгдэж байна. Хүчин чадал нэмэгдэж байгаа. Цаашидаа бас урагшаа 5 төмөр замаар гардаг гарцтай болох. Ганцхан Замын-Үүд Эрээнээр

гардаг биш 5 авто замаар гарах гарцтай болох ийм бас бодлого бас нэлээн эрчимтэй явагдаж байгаа. Замын-Үүдээр үндсэндээ Монгол Улсын импортын ачааны үндсэндээ 80, 90 хувь нь орж ирдэг. Тяньжинээр дамжаад. Монгол Улс ганцхан далай руу Тяньжин гэсэн боомтоор гарч байгаа. Бид нар бас Тяньжин боомтыг Ли Ямган боомтоор, мөн хойд талдаа Жинжав гэсэн 3 боомтоор ачаа авдаг больё. Тяньжин дээр үндсэндээ 2-оос 3 сараар ачаа саатаж байгаа. Түүнээс болж бараа багтахад өндөр үнэ өртөг өндөр болж байгаа.

Тийм болохоор 3 боомтоор ачаагаа авъя. Тэр хэмжээгээр үндсэндээ Замын-Үүдийн ачаалал нэмэгдэнэ. Үүнтэй холбоотойгоор бид нар бас Замын-Үүдээс Улаанбаатар явах замыг бас яаралтай сайжруулах, дээрээс нь нөгөө Замын-Үүдээс Чойроос олон овоотоос бас Майнтаас хулгайн нүүрс, жонш тэгээд л төмрийн хүдэр маш их ачигддаг. Үүнийг төмөр замаар ачдаг болсон.

Цаашидаа цаашидаа бид нар Тавантолгойгоосос Чойр, Майнт хүртэл хулгайн нүүрс тээвэрлэж ирээд Замын-Үүдэд гаргадгийг бас хорьсон зогсоосон. Гэтэл бас яах аргагүй уул уурхайн бүтээгдэхүүн бас тээвэрлэх ч нэг талдаа шаардлага байгаа, нөгөө талдаа импортынхоо ачаагаар хурдан татах шаардлага байгаа. Тийм болохоор энэ дээр бид нар Замын-Үүд-Налайх чиглэлийн замыг 4 эгнээ болгох дээрээс нь өндөр даацын болгох бас энэ асуудлыг улсын төсөвт хөрөнгө байхгүй бас гаднын зээл тусламжаар болох байх.

Тийм учраас эхний ээлжид бид нар бас хувийн хэвшлүүд сонирхож магадгүй. Төр хувийн хэвшлийн түншилэлийн хүрээнд хийгээд зарласан байна. Одоо 12 сарын 22-нд сонгон шалгаруулалт нээгдэнэ 9 компани нь одоогоор оролцсон байгаа. 9 компаниуд оролцсон байна. Тэгээд 9 компанийн дунд үндсэндээ сонгон

шалгаруулалт болоод бид нар үндсэндээ өндөр даацын эхний ээлжид 2 эгнээ өндөр даацын зам бариулах төлбөртэй.

Үүгээрээ уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэхээ буцаагаад импортын ачаа бараагаа Эрээнээс хурдан хугацаанд нааш нь Замын-Үүдээр дамжуулаад татах ийм зорилготойгоор ийм зориулалттайгаар ийм зам барих гэж байгаа. Одоогийн зам бол байдгаараа байна. Энэ бол ингээд явдгаараа үйл ажиллагаа явуулна. Эхний ээлжид ингэж бас шийдэхээр явж байгаа. Тэгээд ингэж шийдэх юм бол үндсэндээ манай ачаа, бараа, экспорт ч нэмэгдэнэ. Импортын ачаагаа ч хурдан хугацаанд бас Улаанбаатар руу татаж авах бас бололцоо боломж бүрдэнэ ээ. Тийм болохоор Замын-Үүд Эрээн 24 цагаар туришилтын хугацаанд ажиллуулаад үзье. Энэ хугацаандаа бид нар бас нэлээн ачаа барааны болон зорчигчийн эргэлт нэмэгдэх байх. Энэ хэмжээгээрээ цаад тал нь 2 талдаа энэ саад түгжээг арилгах Тяньжиниас Эрээн хүртэлх, Эрээнээс Налайх хүртэлх энэ бас түгжрэл саадуудыг бас ингээд арилгах тал дээр бас цогцоор нь томоор нь хараад ингээд бас Монгол Улсын Засгийн газар, Зам, тээврийн хөгжлийн банк анхаарч ажиллаж байгаа гэдгийг танд хэлье ээ.

Ер нь өөр боломжууд байвал бид нар ер нь зээл тусламжаар орох хэцүү байгаа. Дээрээс нь улсын төсвийн хөрөнгө оруулалт хэцүү байгаа. Тийм болохоор бид нар энэ концесс, төр хувийн хэвшлийн түншилэлийн хүрээнд ямар л бас боломжтой хувилбарууд байна энэ хувилбарууд дээр бас ажиллах бололцоотой ажиллая гэж харж байгаа. Одоо манай хотынхон чинь ингээд метро барихдаа бас тодорхой уурхайн ордыг ашиглаад ингээд ордоосоо бүтээгдэхүүн өгөх байдлаар ингээд явъя гэсэн тиймэрхүү юм ярьж байна. Иймэрхүү нөхцөлүүдийг ч одоо, хувийн хэвшлийн одоо ордуудыг бид нар энд бас оролцуулах санхүүжилтийг нь босгох талд нь

оролцуулах ийм хувилбар механизм бас байж болох юм аа.

Энэ нэн чухал яаралтай барих ёстой зам учраас бүхий л бололцоотой хувилбараар ажиллана гэж бодож гэж бодож байгаа.

Л.Мөнхбаатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Зээлийн энэ гэрээг бол дэмжиж байгаа. Зам, тээврийн яамнаас энэ 20, 30 жилийн насжилттай болсон энэ замуудыг өнгөрсөн 30 жилийн хугацаанд дээлийн цоорхой шиг нөхөж ирсэн. Ямар ч үр дүн байхгүй байсан. Харин энэ жилээс ингээд шинэ хучилт хийгээд ингээд явж байгаа нь одоо зүүн тийшээ 501 гэдэг энэ зам дээр ямар их аваар осол гардаг байлаа. Ямар их олон хүн эд материал амь насаараа хохирдог байлаа. Энэ бол би зөв зүйтэй зүйл гэж ингэж бодож байгаа юм.

Сая ингээд өнөөдрийн чуулганы хуралдааныг сонсож байхад, сууж байхад 2 ноцтой юм яригдаж байна шүү дээ. Нэг нь Улсын Их Хурлын дарга хэлсэн. Би 5 хоног орон нутагт ажиллаж энэ цас зуд энэ нөхцөл байдлыг газар дээр нь мэдэрчхээд урьд шөнө ирлээ. Сая Улсын Их Хурлын дарга юу гэж хэлсэн гэхээр энэ нефтийн компаниуд түлшээ нөөцөлчихсөн байна гэж яриад байх юм. Энэ хэрвээ үнэн бол бас арай хэтэрч байгаа юм биш үү. Ер нь хөдөө цасан дунд цасан далай дунд нэг портертоо балга бензин хийгээд цасанд зоогдчихсон. Жоохон зүтгэх гэхээр балга бензин нь дуусчих гээд үйлээ үзээд зогсож байгаа хүн тэнд амьдарч байна шүү дээ. Явж байна шүү дээ амьдралын төлөө.

Тэгэхэд энэ нефть экспортолж байгаа энэ компаниуд нь төрөөс тусгай зөвшөөрөл авч энийг ингэж хийчхээд тэгээд нөөцлөөд энэ ард түмнээ бодохгүй байгаа бол энэ арай л би хэтэрч байна гэж

ингэж бүүр сая сонсоод бүүр үнэхээр эгдүү хүрлээ. Яасан арилцан дотортой хүмүүс байдаг юм. Сая Зам, тээврийн сайдын үгэн дээр нэг юм гарч байна шүү дээ. Нислэгийн тийзний үнэ буурсан гэж энэ үнэн. Ард түмэн юу гэж ярьдаг вэ гэхээр Монголоос мориор ч хамаагүй хил гарчих юм бол хамгийн хямд тийз дээр очдоогоо гэж. Тэгээд энэ өндөр байсан тийзийг буулгасан шалтгаан нь энэ. Онгоцны бензиний үнийг бууруулахад төр өөрөө оролцоод аж ахуйн нэгж байгуулаад тэр үнийн өсөлтийн бас нэлээдгүй хувийг эзэлж байгаа юм байна лээ шүү дээ.

Дээрээс нь энэ салбарт өрсөлдөөн оруулаад ирсэн юм байна лээ шүү дээ энэ Зам, тээврийн яам. Тэрэн шиг энэ нефтийн энэ экспорт, импортон дээр бид нар ер нь бас нэг жоохон бодолтой хандахгүй бол ингээд л нэг хэдэн компани одоо энэ дотор орж ирээд ингээд янз янзын зовлонг нь сонсож л байна. Засгийн газрын эхний ээлжид тэр нефть үйлдвэрлэдэг улсуудаас очиж гуйдаг юм байна. Нийлүүлэлтийг нь гуйдаг юм байна. Үнийг нь гуйдаг юм байна. Одоо оруулаад ирсэн нефтийг түгээгээд өгөөч ээ гэж энэ аж ахуйн нэгжүүдээс гуйх болж байгаа юм байна шүү дээ.

Тэгэхээр бид бас энэ ард түмний өмнө тулгамдаад байгаа энэ зовлонг бас ойлгож мэдэрч бас хариу арга хэмжээг авмаар санагдаад байгаа юм. Хөдөө орон нутагт цасан далай байна шүү. Тэгэхээр өнөөдрийн энэ чуулган дээрээс ингээд Их Хурлын даргын хэлсэн үгийг ч тэр, салбарын сайдын энэ салбар дээр бас ахиц гаргасан энэ жишээг бид ер нь бас нэг жоохон дараа дараагийн салбарууд дээрээ ч гэсэн ер нь бодмоор юм биш үү гэж би асуулт гэхээсээ илүү, үг хэлмээр санагдаад хэлж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Идэрбат гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан байр сууриа илэрхийлж үг хэллээ.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд гишүүний урилгаар Хустайн цогцолборт газрын албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил амьдралд нь амжилт сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе өө.

Хустайн нуруунд тахь үржүүлж байгаа, байгалиа хамгаалж байгаа иргэдийн маань төлөөлөл бас Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. 1992-оос 2000 онд тахь нутагшуулах ажлыг зохион байгуулсан. Анх 15 тахь ирж байсан бол одоо нийтдээ Монгол Улсын хэмжээнд 800 гаруй тахь болон үржиж өсөөд байгаа. Үүний 400 гаруй нь Хустайн нуруунд нутагшаад байна аа. Ийм болохоор энэ Монголын ард түмэнд энэ дэлхий нийтэд тахь нутагшуулах ажлыг олон улсад жишиг болгон хөгжүүлж хийж байгаа эрхэм байгаль хамгаалагчид та бүгддээ Улсын Их Хурлын гишүүдийнхээ та нарын өмнөөс амжилт, сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе өө.

Гишүүд асуулт асууж үг хэлж дууслаа.

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 44.3-д заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг маргааш өглөө 10 цагаас буюу 15-ны 10 цагт санал хураалтыг явуулна аа.

12.47 цагт

Дараагийнхаа асуудалд оръё. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2016, 2018 онд оруулсан нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн

Бямбацогт танилцуулна. Таныг индэрт урьж байна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс нь олон улсын хөдөлмөрийн байгууллагын гишүүнээр 1968 онд элссэн бөгөөд тус байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2014 онд нэгдэн орсныг мөн энэхүү конвенцод 2010, 2014 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын Их Хурал 2019 онд соёрхон баталсан билээ. Швейцар улсын Женев хотноо 2016, 2018 онуудад зохион байгуулсан олон улсын хөдөлмөрийн байгууллагын бага хурлаар тус конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулсан нь 2019 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр болон 2020 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн тус тус хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн.

Одоогоор нийт ер гаруй гишүүн улс тус өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөөд байна аа. Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр далайчдын эрхийг хамгаалах үүднээс хөлөг онгоц дээрх ялгаварлан гадуурхалт болон дарамтыг багасгах мөн далайн дээрэм болон хөлөг онгоцны эсрэг зэвсэглэсэн дээрэм тонуул гэсэн нэр томъёог шинээр тусгаж тус нөхцөл байдлын улмаас олзлогдсон үеийн далайчны хөдөлмөрийн гэрээний зохицуулалтыг нэмсэн болно оо.

Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталснаар Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцон дээр ажиллаж буй далайчны хөдөлмөрлөх эрхийг хангах, хөлөг онгоц эзэмшигчийн зүгээс далайчинтай байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн хариуцлагыг өндөржүүлэх ач холбогдолтой юм аа.

Иймд олон улсын гэрээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг 26 дугаар

зүйлийн 26.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2016, 2018 нэгдэн оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс соёрхон батлах тухай хуулийн төслийг танилцуулж байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Бямбацогт сайдад баярлалаа.

Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Н.Энхболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 11 сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн олон улсын Хөдөлмөрийн байгууллагын далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 12 сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Энхболд өнөөдрийн байдлаар Монгол Улсын далбаатай хэдэн онгоц, хэдэн далайчин байгаа талаар болон конвенцод нэгдэн орсон гишүүн орон бүр далайчны хөдөлмөрийн гэрээг түүний хүчинтэй хугацаа дууссаныг харгалзахгүйгээр ямар

нэгэн халдлагад өртсөн тохиолдолд хүчинтэй хэвээр байлгахыг шаардана гэж заасан байгаа тул энэ хариуцлагыг хэн хүлээх талаар, мөн манай улсын далбаа бүхий хөлөг онгоц, далайн дээрэмчдийн халдлага, хүчирхийлэлд өртөж байсан эсэх холбогдох эрх зүйн зохицуулалт хариуцлагын талаар ажлын хэсгээс асууж, хариулт авсан болно оо.

Мөн гишүүн Энхболд БНХАУ-ын Тяньжсин хотод байгаа манай улсын мэдлийн 10 га газрыг боомтын зориулалтаар ашиглах асуудал удааширалтай явж ирсэн тул энэ талаар ямар бодлого баримталж байгааг Зам, тээврийн хөгжлийн сайд Бямбацогтоос тодруулан асууж цаашид энэ газрыг үр дүнтэй ашиглах асуудлыг судалж шийдвэрлэх зүйтэй талаар үг хэлсэн.

Улсын Их Хурлын гишүүн Баделхан Монгол Улсын далбаатай бүртгэлтэй хөлөг онгоцны ямар асуудлыг манай улс хариуцдаг, хэрхэн хяналт тавьдаг тухай болон улсын төсөвт төвлөрүүлдэг нийт ашиг Далайн захиргааны байгууллагын жилийн төсөв, бүтэц, орон тооны талаар асуулт асууж хариулт авсан. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2016 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах нь зүйтэй гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно оо.

Их Хурлын эрхэм гишүүд ээ, олон улсын хөдөлмөрийн байгууллагын далай хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2016, 2018-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг зөвшилцөх хэлэлцүүлэх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Энхболд даргад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Далайн ашиглалт, усан замын тээврийн хэлтсийн дарга Дагвын Жавхлан, ЗТХЯ-ны Хуулийн хэлтсийн дарга Сүхээгийн Мяндасмаа, Далайн захиргааны дарга Дамдинсүрэнгийн Отгонсүрэн, Далайн захиргааны хөлөг онгоцны бүртгэл хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ононгийн Анужин нар оролцож байна аа.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 44.3-д заасны дагуу хуулийн төслийн эцэслэн батлах санал хураалтыг маргааш өглөө буюу 15-ны өглөөний 10 цагаас санал хураалтыг явуулна аа. Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдааныг өндөрлүүлж байна. 14 цагаас чуулганы нэгдсэн хуралдаан үргэлжилнэ ээ.

12.53 цагт

ЗАВСАРЛАГА

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 14-ний өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төсөл болон

хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Даваажанцангийн Сарангэрэл гишүүн танилцуулна.

Ажлын хэсэг сайд орж ирэхгүй бол хойшлуулах. Дамдинням гишүүн хойшлуулах санал гаргаж байна. Дамдинням гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Хойшлуулах хойшлуулах санал хураалт явуулъя.

Чинзориг сайд орж ирэхгүй энийг хойшлуулъя. Та өөрөө байхгүй шүү. Тэгвэл та өөрөө горимын санал гарга.

Содномын Чинзориг сайд орж ирсэн байна. Тэгээд төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Даваажанцангийн Сарангэрэл гишүүн танилцуулна аа, индэрт урьж байна.

Д.Сарангэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 12 дугаар тогтоолоор хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл

хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Сарангэрэл ахалж, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Анужин, Жаргалмаа, Оюунчимэг, Чинбүрэн нар ажилласан болно.

Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Ажлын хэсэг, Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлал, зарчмыг хөндөхгүйгээр салбарын мэргэжилтэн судлаачдын санал зөвлөмжийг тусган боловсруулсан зарчмын зөрөөтэй 50 санал, найруулгын шинжтэй нэг санал болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан зарчмын зөрөөтэй 10 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Үүнд:

1.Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагын тогтолцоог тодорхой болгож хэрэгжүүлэх чиг үүргийг оновчтой болгох,

2.Нийгмийн эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг эрүүл мэндийн тухай хуульд заасан Эрүүл мэндийн мэргэжилтэнтэй адилтгах,

3.Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох асуудлыг Монгол Улсын хөгжлийн бодлогод тусгаж хэрэгжүүлэх,

4.Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг анхан шатны

тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагын тэргүүлэх чиглэл болгон хэрэгжүүлэх зэрэг асуудлыг тусгалаа.

Түүнчлэн Боловсролын ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах санал гаргасан нь дэмжигдсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг улсын төсвөөс санхүүжүүлэхтэй холбогдуулан өрхийн эмнэлгүүдийн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, санхүүгийн тооцоолол, хуулийн төсөлд тодорхой туссан эсэх, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээ авах зохицуулалтыг хэрхэн тусгасан талаар асуулт асууж хариулт авлаа. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын Байнгын хорооны санал дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: *Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.*

Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, Дангаагийн Баярболд Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга, Сүрэнжавын Өнөрсайхан НЭМҮТ-ийн захирал, Бямбадоржийн Нинж Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Энхбаярын Цэрэнчунт Эрүүл мэндийн яамны Хуулийн хэлтсийн мэргэжилтэн, Эрдэнэбилигийн Баяртулга Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн, Ургахнарангийн Эрхэмбаяр НЭМҮТ-ийн Стратегийн удирдлагын албаны дарга.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Жигжидийн Батжаргал гишүүнээр тасалъя. Сайнхүүгийн Ганбаатар гишүүнээр тасаллаа.

Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууя.

С.Одонуяа: *Тэгэхээр энэ хуулийг бол үзэл баримтлалынх нь хувьд бол дэмжиж байгаа. Энэ бол яах аргагүй олон жил бидний хүсэн хүлээсэн хууль байгаа. Ер нь эрүүл мэндийн бараг хуулиудаас суурь хууль гэж бараг хэлж болохоор. Гэхдээ яг энэ одоо батлагдах гэж байгаа хууль бол ерөнхийдөө тийм их ач холбогдол багатай юм. Их хэт ерөнхийдүү ийм хууль болчихсон байгаа. Би яагаад ерөнхий хууль болчихсон байна гэж хэлж байна гэхээр нөгөө санхүүжилтийн тогтолцооны талаар тийм тодорхой зүйлүүд бас их ороогүй байгаа. Нийгмийн эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрийг яаж үнэлэх юм, яаж урамшуулах юм гэдэг асуудлууд жоохон тодорхой бус байна уу гэж харж байгаа юм. Тэгэхээр ер нь энэ хууль бол ялангуяа энэ иргэдийн эрүүл мэндийн*

асуудал энэ орчны бохирдолтой холбоотойгоор бараг үндэсний аюулгүй байдлын салиггүй ийм хэсэг болчихоод байгаа юм.

Тийм учраас энэ эхний асуудал дээр энэ Үндэсний аюулгүй байдлын тухай хууль гэж бас оруулж өгсөн байгаа. Тэгээд ажлын хэсэг нэлээн л зовох шиг боллоо. Үгүй ээ энэ хууль чинь эхнээсээ ийм зөв сайн бичээд оруулж ирэх ёстой. Сүүлийн үед энэ хуулиуд маш чанаргүй орж ирж байна. Орж ирсэн хуулийг нь орж ирсэн хойно нь яамныхан засах юм. Орж ирсэн хойно нь ажлын хэсэг дээр эрээн мяраан болоод 60, 70 санал гэдэг чинь энэ эхнээсээ л маш учир дутагдалтай орж ирсэн л гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр цаашидаа хуулиуд ийм замбараагүй орж ирэхийг болимоор байна аа. Ерөөсөө яг таг орж ирээд л ажлын хэсэг дээр тодорхой хэдэн саналууд шийддэг болмоор байна. Сүүлийн үед бол энэ Монгол Улсад зүрх судасны өвчлөл үнэхээр 1 дүгээрт байгаа. Хавдрын өвчлөл халдварт бус өвчин гээд ер нь энэ Монгол хүний эрүүл мэндийн асуудал маш ийм ноцтой ийм байдалд байгааг манайхан бүгдээрээ мэдэж байгаа.

Тийм учраас энэ Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль бүүр энэ Монголчуудын эрүүл мэндийг цоо шинэ шатад гаргах ёстой ийм ач холбогдолтой хууль байх ёстой. Тийм учраас энэ дээр яах вэ ямар ч байсан чамлахаар чанга атга гэдэг. Энийгээ баталчхаад бусад зүйлүүдийг нь баталдаг юм уу? Тэгэхдээ 4 сарын 1-нээс хэрэгжинэ гэхэд надад амжихгүй санагдаж байгаа. Яагаад гэхээр энэнтэй чинь холбоотой маш олон журмууд хэлэлцэгдэнэ. Тэгэхээр бараг 7 сарын 1-нээр уг нь эцсийн хэлэлцүүлэг дээр ярьж байгаад энэ хэрэгжих хугацаагаа жоохон хойш нь тавих нь зүйтэй байгаа юм аа. Ер нь бол энэ Нийгмийн эрүүл мэндийн хууль дээр нэг зүйлийг бид нар онцгой анхаарах ёстой юм. Одоо ингээд хүн өвдчихөөд бүгдийг нь эрүүл мэндийн

салбар руу ачаан дээр нь үүрүүлдэг энэ байдлаа бид нар болих ёстой юм.

Одоо салбарууд адилхан ачаа үүрэх ёстой, зам тээврийн салбар, барилгын салбар бусад ингээд салбарууд ачаа үүрэх ёстой. Тийм учраас энэ салбарууд тодорхой тэр батлагдсан төсвийнхөө тодорхой хувийг нэг хувийг ч гэдэг юм уу энэ ажиллагсдынхаа эрүүл мэндийг сайжруулах энэ чиглэл рүү тодорхой төсөв баталж бүүр сайн ажиллах ёстой юм аа. Тэгээд яах вэ ажлын хэсэг дээр энд Сарангэрэл гишүүн бол энэ ач холбогдлыг нь нэлээд тодруулж оруулж өгсөн байна лээ. Өөрөөр хэлбэл энийг нь хэлэлцдэг. Дараа нь Үндэсний зөвлөл энэ тайланг нь авч, аль салбар, аль нь энэ чиглэл дээрээ зөв ажиллаж байна уу, буруу ажиллаж байна уу? Тодорхой зүйлүүдийг бол энэ ажлын хэсэг бас тусгах гэж оролдсон байгаа юм.

Тэгэхээр ер нь бол энэ салбарууд дээр бас энэ ачаа үүрүүлдэг болохгүй өнөөдөр хүмүүсийн эрүүл мэндийн асуудлыг бүгдийг нь энэ эрүүл мэндийн салбар руу ингэж үүрүүлдгийг болих хэрэгтэй юм байгаа юм аа. Тэгээд ажлын хэсгээс нэг зүйлийг л асууя. Энэ нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудын энэ.

Г.Занданшатар: Байнгын хороо хариулах ёстой л доо. Чинзориг сайд хариулъя.

С.Чинзориг: Ер нь хүн амын эрүүл мэндийг хамгаална гэдэг 2 талтай асуудал гэж ойлгоод байгаа юм.

Нэг тал нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нөгөө тал нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ. Эрүүл мэндийн тухай хуульдаа ч гэсэн ийм 2 харилцаа 2 талтай ийм харилцааг зохицуулсан байдаг. Харамсалтай нь бол сүүлийн жилүүдэд Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль эрх зүйн орчин нь бүрдээгүй эрүүл мэндийн тусламж

үйлчилгээ нь давамгайлаад эрүүл мэндийн тусламж үйлчилгээндээ бид нар ач холбогдол өгөөд, өвчилсний араас нь хөөгөөд яваад олон жил явж ирсэн.

Тийм учраас бол энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай гэсэн манай салбарын суурь харилцааг зохицуулдаг анхдагч хуультай болох нь зүйтэй гэж үзээд байгаа юм. Бусад орнуудын хөгжлийн туршилагыг харахаар ч гэсэн тийм л юм байна лээ шүү дээ. Ерөөсөө л нийгмийн эрүүл мэнд, анхан шатны тусламж үйлчилгээндээ л хүн амынхаа эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээ тусламж үйлчилгээнийх нь дийлэнхийг нь тэндээ үзүүлдэг. Хөрөнгө санхүүгийнхээ дийлэнхийг нь тэр энэ шатныхаа тусламж үйлчилгээнд зарцуулдаг.

Манайх бол үүний эсрэг яваад байгаа юм. Одо бид нар нийгмийн эрүүл мэнд анхан шатны тусламж үйлчилгээнд хөрөнгө санхүүгийнхээ дөнгөж л хорьхон хувийг л зарцуулж байна шүү дээ. Тэгэхээр бол бид нар энэ олон улсын хөгжлийн жишигийн хөгжлийн энэ хандлагын эсрэг яваад байна.

Хоёр дахь асуудал. Бид нар 3 жил ковидын цар тахалтайтай тэмцэх гэж нэлээн бас дээр дооргүй ачаалалтай ажилласан. Энэ ковид ч гэсэн бид нарт асар том сургамж өгсөн гэж бодож байгаа юм. Ерөөсөө энэ ковидоос сургамж авсан сургамж бол нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлэхгүйгээр бид нар цаашидаа энэ олон нийтийг хамарсан дэлхий нийтийг хамарсан ийм халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ийм бэлэн байдал байхгүй байна гэдэг ийм маш том сургамж авсан.

Тийм учраас энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй хууль зайлшгүй шаардлагатай байгаа юм. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг Төрийн албан хаагчдын

нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг яах юм бэ гээд Одонтуяа гишүүн асуугаад байгаа юм. Эрүүл мэндийн тухай хуулиараа эрүүл мэндийн салбарын ажиллаж байгаа ажиллагсад төрийн албан хаагчдын нийгмийн баталгааны асуудлууд зохицуулагддаг. Мөн төрийн албаны тухай хуулиараа бол нийгмийн баталгаа зохицуулагддаг. Хөдөлмөрийн хуулиар бас төрийн үйлчилгээний албан хаагчдын нийгмийн баталгаа, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлууд зохицуулагддаг.

Тэгэхээрээ бид нар энэ хуульд бол нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллаж байгаа албан хаагчдын нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг бусад хуульд байгаа заалтуудыг ийш нь оруулаагүй. Ерөөсөө л Төрийн албаны хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиараа нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нарын нийгмийн баталгааг нь хангана гээд ингээд оруулчихсан юм. Энийг бас хэт ерөнхий байна гэж ойлгож байж магадгүй. Би бол хууль хэт ерөнхий болчихсон байна гэж бодохгүй л байгаа юм. Манайх чинь одоо Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль гээд яг эмнэлгийн тусламж үйлчилгээг зохицуулсан тусгай бие даасан хуультай. Нийгмийн эрүүл мэндийн хууль чинь урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгтэй холбоотой асуудал.

Дээр нь нөгөө өвчний хяналт тандалт сэргийлэлттэй холбоотой асуудал. Гол нь нөгөө иргэний эрүүл мэндийн боловсролтой холбоотой асуудлууд орсон учраас ерөнхий харилцаа зохицуулж байгаа юм шиг бас ийм ойлголтууд бас байгаад байж магадгүй гэж бодож байна аа.

Салбарын салбарт ачаалал үүрэгтэй гэдэг нь санал нэг байгаа. Ийм зохицуулалт оруулж өгсөн. Нэг юмыг бас бид нар гишүүд сайн ялгаж ойлгомоор юм байна лээ. Хүн амын иргэдийн эрүүл

мэндийн асуудал энэ агаарын бохирдол орчны бохирдол асар их сөрөг нөлөө үзүүлж байгаа нь үнэн. Энэнтэй холбоотой асуудлуудыг энэ хуулиар зохицуулахгүй юм уу гээд байгаа юм. Манайх чинь бас энэ их Эрүүл ахуйн тухай хууль гээд бас бие даасан хууль байна. Энэ эрүүл ахуйн тухай хуулиар энэ орчны бохирдол агаарын бохирдолтой холбоотой энэ бас харилцаануудыг зохицуулсан ийм бие даасан хууль байгаа юм аа.

Тийм учраас бол нэг хууль болгоогүй.

Г.Занданшатар:

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна.

Ж.Чинбүрэн: Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хуулийн төсөл Засгийн газраас Эрүүл мэндийн яамнаас өргөн барьсанд бас их талархалтай байгаа.

Энэ тулгамдаж байгаа нэг асуудлын нэг. Өнөөдөр бид өвчин туссанаас туссан хойно нь эмчлэх гэж асар их мөнгө зардал гаргаж байна. Тухайлах юм бол одоо ЭМД-ын санд бол бид 2020 онд Улсын Их Хурлын гишүүн болж байхад ердөө 500 тэрбум төгрөгтэй байсан бол өнөөдөр бид 2 их наяд хүргэчихсэн. Энэ эмнэлгийн тусламж үйлчилгээ чинь ийм өндөр үнээр худалдаж аваад тэгээд энэ нь өөрөө л ер нь эдийн засгийн хувьд дандаа өвчний туссан хойно нь эмчлэх гэж явж байгаа бодлого. Тэгвэл өнөөдөр бидэнд дутагдаж байгаа нэг том асуудал бол ерөөсөө л урьдчилан сэргийлэлт, орчны эрүүл ахуйн байдал, иргэндээ ээлтэй байх, нярай хүүхдүүдээ эрүүл өсгөдөг. Ажлын байран дээр өвчин эмгэгтэй болдоггүй. Ер нь бол эцсийн зорилго бол бид Монголчуудаа урт наслуулах урт наслахдаа чанартай урт насалдаг байх энэ тогтолцоог хийх нь их чухал юм аа.

Тийм учраас энэ хууль бол мэдээж бүх зүйлүүдийг тусгаж бүх детальчилж зүйлүүдийг оруулахаасаа илүүтэй нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг Монгол улсад анхдагч хуулиар бий болгох, түүнийг дэмжих төсөв санхүүтэй байлгах явдал бол өөрөө энэ эрүүл мэндийн салбарын тэр битгий хэл Монгол Улсын 3.4 сая хүнийг эрүүл амьдрах, оршин байх энэ утга санааг илэрхийлэх том хууль болж байгаа гэж харж байгаа.

Тэгэхээр мэдээж салбар хоорондын уялдаа үнэхээр чухал. Өнөөдөр бид агаарын бохирдолтын тухай ярихлаар ганцхан энэ чинь Эрүүл мэндийн яамны асуудал болж чадахгүй шүү дээ. Энэ бүх л салбаруудын оролцоо чухал. Тийм ч утгаараа энэ хуульд бас Үндэсний зөвлөл байгуулж тэр нь Ерөнхий сайдын доор бас байхаар зохицуулж өгч байгаа нь олон салбарын оролцоог илүү чухал болгож өгч байгаа гэж харж байгаа.

Дээрээс нь бид бас энэ парламентад нэг сайн жишиг тогтсон зүйл бид ди парламентаар дамжуулан энэ хууль дээр бас мэргэжлийн, салбарын мөн төрийн бус байгууллагуудын, иргэдийн саналыг авч чадаж байгаа.

Тийм учраас би бас энэ ди парламент дээр ирсэн саналуудаа та бүхэн хэр сайн суулгаж чадсан бэ гэдгийг ажлын хэсэг болон ажлын дэд хэсгийн хүмүүсээс бас асуумаар байна. Бас нэг хэлэх гэж байгаа санаа бол ер нь бид энэ ковид цар тахалтай холбоотой их том сургамж авсан. Энэ бол олон нийтийг хамарсан өвчин зовлонгийн үед бид даатгалын сангаасаа илүү их зардлууд гаргаад тэгээд одоо энэ ковидыг давж туулах энэ хохирол багатай давахад чухал үүрэг гүйцэтгэсэн. Тэгвэл энэ хуулиараа бид бас энэ тогтолцоогоо илүү олон нийтийг хамарсан өвчин түүнтэй тэмцэх үйлсэд энэ төсвөөс мөнгө төсөвлөдөг, санхүүжүүлдэг, энэ тодорхой байх явдал нь чухал юм гэдэг энд бас олж өгсөн гэж

нэлээн сайн жишээ бол энэ гэж бодож байна.

Дараагийн бас нэг хэлэх гэж байгаа зүйл бол бид ахмадуудаа илүү эрүүл саруул байлгах. Бас сав л хийвэл өвчин зовлон эм тан уудаггүй байлгахын тулд энэ нийтийн биеийн тамирын асуудлыг нэлээн байдаггүй ярих ёстой. Олон түмнийг хамарсан эрүүл мэндийн боловсрол энэ чиглэлд бас үйл ажиллагаа нэлээн сайн явуулах ёстой. Энэ чиглэлдээ бас энэ хуульд бас нэлээн ерөнхий орсон. Гэхдээ бас би энэ хангалттай гэж бодож байгаа. Яагаад гэвэл дараа дараагийн бусад журмуудаараа тогтоол шийдвэрүүдээрээ энийгээ хийгээд явчих байх гэж бас харж байна.

Бас нэг хэлэх гэсэн санаа бол ер нь бид энэ өвчин судалдаг төвтэй болох нь их чухал юм. Монголчууд бид ямар өвчнөөр яагаад өвдөөд байгаа юм гэдэг ийм судалгаа нотолгоон дээр гаргасан шийдвэрлэсэн шийдвэрүүд гарах ёстой. Тийм учраас энэ Си Ди Си гэж нэрлэдэг өвчний хяналт судалгааны төвтэй ижил төстэй ийм төвийг Монголдоо байгуулж иргэддээ тулгамдаж байгаа энэ өвчлөлд хүргэж байгаа шалтгаануудыгаа нэлээн тийм бодитой судалгаанд тулгуурлаж өөрсдөө төсвөөрөө төсөвтэй байж судалгаа шинжилгээ хийж ойрын ирээдүйд ямар ямар өвчин илүү их өвдөх юм, алийг нь бид урьдчилан хэрэглэх юм гэдэг бодлогоо тодорхойлоход энэ хуульд бас.

Г.Занданшатар: Буланы Бейсен гишүүн. Чинзориг сайд хариулъя. Ди парламентын санал.

С.Чинзориг: Би Чинбүрэн гишүүнтэй санал нэг байна аа. Ер нь энэ Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль оруулж ирж байгаа гол зарчим нь бол бид энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг одоогийн эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа даатгалын сангаас

чанар үр дүнд суурилсан санхүүжилтийн аргаар санхүүжүүлнэ гэхлээр энэ бас арай болохгүй байгаад байгаа юм аа.

Тийм учраас энэ хуулийн гол зарчим нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг улсын төсвөөс санхүүжүүлдэг байх. Ийм одоо зарчим бол орж ирж байгаа юм.

Хоёр дахь асуудал нь тэр ер нь бол иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх асуудал бид онцгой анхаарал хандуулах ёстой. Энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хуулийн гол тэр чиглэл нь иргэний эрүүл мэндийн боловсролын асуудал байна гэж үзэж байгаа. Бид Үндсэн хуульдаа иргэн хүн эрүүл мэндээ хамгаалах нь иргэний журамт үүрэг гэсэн маш том заалттай. Энийг төр ч ярьдаггүй, эрүүл мэндийн байгууллага ч ярьдаггүй. Эмч ч ярьдаггүй. Ерөөсөө иргэний эрүүл мэндийн асуудлыг эрүүл мэндийн байгууллага эмч хариуцна гээд олон зуун жил яваад ирчихсэн. Энэ хандлагыг нэлээн өөрчлөх ёстой.

Хоёрдугаарт манай энэ өндөр хөгжилтэй орнуудын туршилагыг харсан ч эрдэмтэн судлаачдын хийж байгаа судалгааг эд нар харахаар иргэний эрүүл амьдралын зөв хэв маяг, иргэний эрүүл мэндийн эрүүл байх асуудлыг чинь бараг л 55 хувийг нь хангадаг гэдэг ийм судалгаа нотолгоо байдаг юм байна лээ. Тэгэхээр бид нар бол энэ иргэнтэйгээ нэлээн бас ажиллах, ялангуяа иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх тэр эрүүл амьдралын хэв маяг хэвшүүлэх тэр нь ямар ажил байх ёстой юм. Буруу дадал зуршлаас бас салах, буруу дадал зуршилд бас орохгүй байх тэр идэвхтэй хөдөлгөөн, идэвхтэй амьдрал гэж ямар асуудлыг хэлээд байгаа юм. Эд нар ингээд иргэнтэй нэлээн ажиллах ийм асуудлууд байна. Өвчин судлах төвтэй болох асуудлыг бид зорьж байгаа. Одоо бол манайд Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний төв гээд төсөвт байгууллага байгаа. Цаана нь ХӨСҮТ, Зоонозын төв эд нар гээд бас энэ

чиглэлээр бас зарим нэг чиг үүрэг нь давхацсан халдварт өвчний нөгөө хяналт, тандалт, сэргийлэлт хийдэг ийм одоо бас чиг үүргүүд нь давхацсан байгууллагууд байна.

Тийм учраас бид нар энэ олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулаад өвчний хяналт сэргийлэлтийн төвтэй болохыг зорьж байгаа. Гэхдээ энэ бол шинээр байгууллага бүтэц бий болгох асуудал биш. Одоогийн байгаа энэ эрүүл мэндийн үндэсний төв дээрээ тулгуурлаад энэ өвчний хяналт сэргэлтийн төвөө байгуулъя. ХӨСҮТ, Зооноз гэх мэт байгууллагуудад байгаа тэр чиг үүрэг нь давхцаж байгаа өвчний хяналт тандалтын чиглэлийн чиг үүргийг нь энэ төв рүүгээ шилжүүлэх замаар олон улсын хөгжлийн жишигт нийцсэн тэр өвчний хяналт сэргийлэлтийн төвтэй болохыг зорьж байгаа. Ди парламент болоод бусад бас энэ эрдэмтэн судлаачдын гаргаж байгаа саналыг бид нар ажлын хэсэгт өгсөн. Ажлын хэсэг дээр бол Сарангэрэл гишүүн маань ахалж ажилласан, нэлээн сайн ажилласан. Энэ ди парламент болоод эрдэмтэн судлаачдын гаргасан саналуудыг үндсэндээ дийлэнхийг нь аваад ингээд явж байгаа гэдгийг бол хэлье ээ.

Дэлгэрэнгүй хариулт байвал тэр ди парламентын тодорхой саналуудыг манай ажлын хэсэг Сарангэрэл гишүү нар бас хариулах байх гэж л бодож байна.

Г.Занданшатар: Ажлын хэсэг ди парламентаар ирсэн тодорхой саналуудын талаар. Баярболд 85.

Д.Баярболд: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя.

Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Баярболд байна. Бид Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төслийг ди парламент сайтад тавьж

нийтдээ иргэдээс 44 санал авсан. Саналыг бүгд хуульд тусгаж ажилласан.

Тухайлбал энэ олон нийтийг хамарсан гамигийн нөхцөл байдлын үед, зуд гамигийн үед яг энэ нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрхэн ажиллах вэ гэдэг асуудал, мөн иргэдэд ил тод нээлттэй мэдээллийг хүргэх зэрэг 40 гаруй санал ирснийг бид хуулийнхаа төсөлд тусгаж оруулсан байгаа. Нийтдээ бид бас 60 гаруй удаагийн хэлэлцүүлгийг Засгийн газрын хууль өргөн барихаас өмнө Их Хурлын Байнгын хороон дээр ирснээс хойш 19 удаагийн хэлэлцүүлгийг бас явуулсан байгаа.

Г.Занданишатар: Буланы Бейсен гишүүн асуулт асууна.

Б.Бейсен: Энэ Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг дэмжиж байгаа юм аа. Гэхдээ энэ эрүүл мэндийн салбарт олон жил ажилласны хувьд бас нэг хэд хэдэн санал хэлье гэж бодож байна. Уг нь энэ хууль 2012, 2013 оноос хэрэгжих ёстой байсан. Тухайн үед би бас эрүүл мэндийн салбарт удирдах ажил хийж байсны хувьд эрүүл мэндийн газрын дэргэд Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс газар байгуулахаар тухайн үед сайдын Засгийн газрын шийдвэр гараад л бүүр тавилгатай нь очиж байсан. Гагцхүү энэ хэрэгжээгүй. Гол нь энэ Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль хэрэгжсэнээр энэ өвчлөлийг эрт илрүүлэх өвчилсөн хойноо зардал их гаргах биш эрт илрүүлээд арга хэмжээ авбал бас тустай юм.

Гэхдээ энэ нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллаж байгаа ер нь эрүүл мэндийн чиглэлээр ажиллаж байгаа улсуудын нийгмийн баталгаа маш муу байна. Цалин бага хариуцлага нь өндөр. Ард иргэд бас эрүүл мэндийн салбар руугаа дайрдаг, ерөөсөө юм болохоор муулдаг, нөхцөл нь бага багтаамж нь муу эмнэлгүүдийн. Наад зах нь бол эрүүл мэндийн салбарын дунд мэргэжилтнүүд

эмч нар хамгийн их авч байгаа нь сая 400, сая 500 мянга л авч байна шүү дээ. 20 хувь 10 хувийн нэмэгдэл үндсэн цалин нь нэмэгддэггүй. Илүү цагийн хөлс, шөнийн нэмэгдэл энэ тэр нь бол нөгөө цалингийн сүлжээгээр нь бодогддог. Нөгөө 20, 30 хувь нэмэгдсэн юу нь нэмэгддэггүй. Энийг бол үндсэн цалин нэмж өгөх талаар ямар бодлого барьж байна та бүгд. Аль эсвэл цалингийн сүлжээг 2 дахин нэмэхгүй бол одоо сувилагч нар чинь хомсдолд орчихлоо шүү дээ. Хүний нөөцийн хомсдолд орчихлоо. 24 цаг гарч байна, тултал нь гарч байна. Нөхөж гарч байна.

Зарим нь энэ талаар эмнэлгүүдээр яваад судалгаа гаргасан уу? Хүний нөөцийн асуудал яаж бэлдэх гэж байна. Хөдөө сумууд дээр мөн адилхан, дутагдалтай мэргэжилтнүүд яаж тэгж бодож байна ер нь олон жил яригдаж байна даа. Энэ асуудал дээр нэлээн анхаарч ажиллаж байгаа юм байна уу? Энэ талаар асууя. Дараа нь тодруулъя.

Г.Занданишатар: Чинзориг сайд.

С.Чинзориг: Эрүүл мэндийн салбар хүний нөөцийн асуудал тулгамдсан асуудлын нэг бас болоод байгаа нь үнэн л дээ. Гэхдээ олон улсын бусад хөгжилтэй орнуудтай жишээд үзэхэд бол манайх эмчийн тоогоор тийм дутагдалтайд ордоггүй юм байна лээ. Эмчийн тоогоор. Харин сувилагчийн тоон дээр бол эмч, нэг эмчид нэг сувилагч оногдож байгаа ийм асуудлууд бий.

Тийм учраас бол цаашидаа бид нар бас тодорхой бодлого дэвшүүлж энэ эмчийг нэг эмч 2 сувилагч гэсэн ийм чиглэлээр үйл ажиллагаа явуулна гэсэн ийм бодолтой байна.

Сувилагчдын хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор бас хэд хэдэн чиглэлийн арга хэмжээ авч байгаа. Та бүхний баталж өгсөн төсвөөр ирэх оны 4 сарын 1-нээс хөдөө орон нутагт ажиллаж байгаа эмнэлгийн эмч

мэргэжилтнүүдэд бага албан тушаалын үйлчилгээний ажилчид ороод орон нутгийн нэмэгдэл 40 хувийг өгнө. Аймгийн төвийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмч, сувилагч, үйлчилгээний ажилчдад 20 хувийн нэмэгдэл өгнө. Энэ хөдөө орон нутагт ажиллаж байгаа эмнэлгийн эмч мэргэжилтнүүдийг бас тогтвор суурьшилтай ажиллуулах нэлээн дөхөм болох болов уу гэж бодож байна.

Хоёрдахь асуудал нь бид нар хавар сувилагч нартай уулзах сувилагч нар хэд хэдэн зүйл ярьдаг юм байна лээ. Нэг дэх асуудал нь энэ сувилагч нарыг бас давтан сургах мэргэшүүлэх ур чадвар эзэмшүүлэх асуудал чухал байна гэж. Тийм учраас 2024 оны улсын төсөв дээр сувилагчийн, сувилахуйн ухааны хөгжлийн төв байгуулах нийтдээ төсөвт өртөг нь 13 тэрбум төгрөг. Ирэх онд санхүүжих нь 3 тэрбум төгрөг гээд ингээд төсөв баталсан. Ингэвэл бас одоо байгаа сувилагчдаа мэргэжил дээшлүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэх талаар нэлээн дорвитой алхам болох болов уу гэж.

Хоёр дахь асуудал нь бид нар сувилагч гэдэг зөвхөн эмчийн туслах гэж бол ойлгохгүй байгаа.

Тийм учраас бол энэ эмнэлгийн байгууллагуудад сувилагчдын бас эзлэх байр суурийг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа. Сайд тушаал гаргаад томоохон мэргэжсэн төрөлжсөн эмнэлгүүд аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд эмнэлгийн удирдлагын бүтцэд өөрчлөлт оруулж сувилахуйн асуудал хариуцсан дэд даргын орон тоо гаргаж ажиллуулах ийм бас тушаал гаргаад түрүүчээсээ манай 3 дугаар эмнэлгээс эд нар 3 дугаар эмнэлгийн дэд даргаар сувилахуйн асуудал эрхэлсэн дэд дарга гээд ингээд сувилахуйн сувилагч бас ажиллаж байгаад ийм бас чиглэлээр бас сувилагч нарыг бэлдэж байгаа асуудлууд байгаа.

Хоёр дахь асуудал нь ер нь блд энэ сувилагч нарыг бас гадна дотнын сургалтад бас хамруулж чадавх бэхжүүлэх шаардлагатай байна гэж үзэж байгаа. Энэ онд анх удаагаа гадаадад богино хугацааны сургалтад 200 эх баригч сувилагчдыг сургалтад хамруулах арга хэмжээ авсан. Мөн бас анх удаагаа хөдөөгийн багийн эмч нарыг гадаадад богино хугацааны сургалтад хамруулах, мэргэшүүлэх ур чадвар эзэмшүүлэх, дээшлүүлэх ийм бас арга хэмжээ авч байгаа.

Энэ онд багтаад бид нар 84 хөдөөгийн сумдын хөдөөгийн багийн эмч нарыг гадаадад, улсад бас сургалтад хамруулж ур чадварыг нь бас дээшлүүлэх ийм бас чиглэлийн арга хэмжээнүүд авч байгаа.

Ингээд цаашидаа бас нэлээн тогтвортой ийм бодлогууд явуулна гэсэн ийм бодолтой байгаа гэдгийг хэлье. Нэг асуудал байгаа.

Эмнэлгүүд гүйцэтгэлээс санхүүжилт авч байгаа учраас цалингаа нэмэгдүүлэх ийм боломжтой. Эрүүл мэндийн газар төсвөөс санхүүжилт авдаг төрийн захиргааны албан хаагчид эмнэлгүүд нь болохлоор гүйцэтгэлээс санхүүжилт авдаг учраас цалин мөнгө нь нэмэгдэх боломжтой. Эрүүл мэндийн газрууд нь төрийн захиргааны албан хаагчид төсвөөс шууд цалин авдаг учраас эмнэлгийн эмчээсээ бас доогуур цалинтай болчихоод байгаа асуудлууд бий.

Г.Занданшатар:

Даваажанцангийн Сарангэрэл гишүүн тодруулъя.

Д.Сарангэрэл: Баярлалаа.

Манай Одонтуяа гишүүн санаж байгаа бол 2016 оны парламентын сонгуулийн өмнө Энх-Амгалан гишүүн, Одонтуяа гишүүн бид нар ингээд Нийгмийн бодлогын байнгын хорооны

гишүүд Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг батлуулж байсан. Энэ хүрээндээ бол Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийг бас батлуулах тухай асуудал яригдаад тэгээд өнөөдрийг хүртэл энэ эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн зохицуулалт байхгүй явсаар ирсэн.

Тэгээд өнөөдөр бол гол зорилго нь түрүүн ч энд үг хэлсэн хүмүүс хэллээ. Өвчний хойноос биш өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх эрт үед илрүүлэгт хамруулах иргэд маань өөрсдийнхөө эрүүл мэндийг хамгаалах мэдлэг боловсролтой болох зэрэг энэ асуудлуудыг эмнэлгийн тусламж үйлчилгээнийхээ өмнө тавьж энэ эрүүл мэндийн салбарыг зүй тогтлоор нь хөгжүүлэх ийм зорилттой. Энэ хүрээнд бол энэ хуулийн төсөл ингээд санаачлагдаад 7 бүлэг 2 зүйлтэй анхдагч хууль болоод явж байгаа юм. Энэ хуулиар нэлээн олон асуудал шийдэгдэж байгаагийн нэг нь эрүүл мэндийн, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний боловсон хүчин бий болох бүтэц тусдаа бий болох санхүүжилт, Монголын хүн амын өвчлөлийн талаарх дата баазтай болох. Эрүүл мэндийн нийгмийн эрүүл мэндийн байдаг юм уу эрүүл мэндийн ноцтой байдлын үед хэрхэн яаж ажиллах гээд анх удаа зохицуулж байгаа ийм заалтууд орсноороо давуу талтай.

Тэр дотор түрүүн Одонтуяа гишүүн маань асуусан. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн боловсон хүчний энэ нийгмийн баталгааны асуудал цалин мөнгөний асуудал хэрхэн яаж явах юм бэ гэж. Өнөөдрийг хүртэл энэ чиглэлд хамрагдаж байгаа хүмүүс маань ТЗ-д хамрагдаж байсан учраас эрүүл мэндийн ажилтны авдаг тэр нийгмийн баталгааг хүртэж чаддаггүй байсан. Энэ хууль тусдаа бие даан гарснаар 25 мэргэжлийн энэ чиглэлд ажиллаж байгаа хүмүүс маань эрүүл мэндийн ажилтнуудынхаа нэгэн адил нийгмийн баталгаа нь

хангагдах ийм боломж бүрдэх юм байгаа юм.

Тухайлбал одоо эрүүл мэндийн нийгмийн ажилтан, багш, биологич, химич зэрэг ингээд 25 мэргэжлийг энд оруулаад үндсэндээ нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ эмнэлгийн тусламж үйлчилгээ 2 маань зэрэгцээ явах тэр дундаа нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь өмнөө явах дэлхийн жишигт нийцүүлэх ийм зорилттой хуулийн төсөл явж байгаа гэдгийг би бас нэмж хэлэх гэсэн юм аа. Баярлалаа.

Г.Занданшатар: Булааны Бейсен гишүүн тодруулж асууя. Нэг минут.

Б.Бейсен: Энэ аргагүй л дээ. Манай салбарын сайдууд ч ойр ойр солигддог. Газар хэлтсийн дарга нар ч ойр ойр солигддог. Тэгээд ажил нь хэрэгждэггүй асуудал байгаа л даа. Гол нь хөдөөд анхан шатан дээр ажиллаж байгаа зарим мэргэжилтнүүд бол мэргэжлийн бус улсууд байж байдаг. Мэргэжил олгох сургалт ажил дадлагажуулах ажлын байрны сургалтыг хийх талаар Эрүүл мэндийн яам боловсруулж байгаа төсөл хөтөлбөр байна уу? Тэгэхгүйгээр наашаа авчирна. 1, 2 хоног байж байдаг зарим алслагдсан аймаг энд ирж сууж чадахгүй шүү дээ. Нэг талын зардал нь 600, 700 мянга, сая 200 мянга авч байгаа. Цалин нь тэгээд сая хүрэхгүй цалинтай. Эмнэлгийн байгууллагууд нь ч гэсэн тэнд өгөх юу нь байхгүй.

Ер нь эрүүл мэндийн салбарын Эрүүл мэндийн яамны төсөв бол хангалттай биш л байна. Бусад салбартаа бодоход ер нь хангалттай төсөв байхгүй. Эд нар тэр энэ талаар та нар энэ Засгийн газарт тавьж байгаа асуудал байна уу?

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Салбарын төсөв дээр бол Засгийн газар нэлээд их анхаарч байгаа. Ялангуяа эрүүл мэндийн салбарын төсвийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн салбарт хийгдэх хөрөнгө оруулалтад нэлээн анхаарал хандуулж байгаа. Энэ далд эдийн засгийг ил болгож байгаа ялангуяа энэ уур уурхайн нүүрсний борлуулалтыг цахимаар хийж худалдаалж эхэлсэнтэй холбоотойгоор нүүрсний орлого нэлээн их нэмэгдэж байгаа. Энэ авлига албан тушаалын хэрэгтэй нэлээн Засгийн газар шуурхай тэмцэж байна. Эдгээрээс орж байгаа орлогыг үндсэндээ нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанартай, хүртээмжтэй хүргэхэд зарцуулах нь зүйтэй гэсэн Ерөнхий сайд бас ийм бас бодлого баримталж байгаа. Ийм чиглэлийн бас тэмдэглэл ч гаргасан байдаг.

Үүний үр дүнд бол 2024 онд эрүүл мэндийн салбарт салбарын санхүүжилт өмнөх оноосоо 25 хувиар өссөн. Эрүүл мэндийн салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээ 48-аар өссөн. Тийм учраас бол бас нөгөө юмаа бодвол эрүүл мэндийн салбарын төсөв хөрөнгө оруулалт бас нэлээд бас нэмэгдсэн.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль орж ирж байгаа энэ гол хууль. Тэгэхдээ бид хэд углуургаар нь юмыг хармаар байгаад байдаг. Иргэдийнхээ эрүүл мэнд бие бялдрын хөгжлийг дэмжих цогц зохицуулалтын тухай л ойлголт л энд л яригдах ёстой. Би бол тэгж л хараад байдаг. Гэтэл бидэнд юу байна гэхээр зэрэг 2 том тогтолцоо байгаад байгаа байхгүй юу. Эрүүл мэндийн тогтолцоо, Боловсролын тогтолцоо. Энэ 2 дээрээ давын өмнө бид суурилах шаардлагатай. Тэгэхээр зэрэг үндэсний гэдэг юм уу тэр аймгийн эрүүл мэндийн газрын дэргэд энэ тэр нийгмийн эрүүл мэндийн төвүүд

байдаг юм байжээ болно. Хүн ам байгаа анхан шатдаа яах юм? Тэр сумын ЭМТ-үүд чинь ер нь ямар чиг үүрэгтэй, ямар тогтолцоотой, юу явуулдаг газар байх юм бэ? Энийгээ нэг тодорхой болгомоор байна, нэг.

Хоёрдугаарт энэ боловсролын байгууллага дотроо СӨБ, ЕБС хоёрынхоо сургалтын хөтөлбөр дотор хүүхдүүд эрүүл мэндийн боловсролоо олж авч чаддаг эрүүл аж төрөх зан үйлдээ төлөвшиж чаддаг. Тэгээд өнөө бие бялдрын хөгжлөө хангаж чаддаг. Энэ 3 асуудал нь орж байгаа юм уу яаж оруулах гээд байгаа юм бэ? Тэгээд тэрнийг үнэлдэг үнэлэмжийн тухай юм байх болно.

Тэгэхээр зэрэг хүний нас, хүйсийн онцлогт нийцсэн нормативууд байх шаардлагатай. Тэгэхгүйгээр зүгээр л үлгэр яриад л яваад байгаа байхгүй юу. Нийгмийн эрүүл мэндийн талаар ингэж байгаа ингэж эрүүл мэндийн боловсрол дээшлүүлж байгаа ингэж нийтийн биеийн тамирыг хөгжүүлж байгаа гээд л яриад л байна. Нормативчил л даа. 14 настай эрэгтэй хүүхэд 100-д хэдий хугацаанд гүйх ёстой юм. Эмэгтэй хүүхэд хэд гүйх ёстой юм. Үгүй ээ ингэж байж л наадах чинь яг амь орно шүү дээ. Энүүнийг нь яаж хараад энэ юман дотор тусаж ороод байна вэ? Энэ л бидэнд хамгийн гол зүйл энд байх ёстой гэж би хараад байна.

Дараагийн нэг зүйл энэ иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлээд байгаа орчныхоо асуудлыг бид анзаарах ёстой.

Тэгэхээр өвчнөөр нь ч дамжуулж, орчноор нь ч дамжуулж судалгаагаа хийж чаддаг тэр тогтолцоо нь баймаар байна. Тэрүүн дээрээ тулгуурлаад тэр шалтгаан нөхцөлийг арилгаж чаддаг бодлого хөрөнгийн асуудал бидэнд чухал. Давын өмнө усны чинь асуудлаас болоод олон иргэд хохирч байна аа. Тухайн бүс нутгийн өөрийнх нь усны агууламжаасаа хамаараад хүмүүс маш их эрүүл

мэндээрээ хохирч байгаа ийм зүйл бий. Тэгвэл ундны усны стандартад энэ усыг нийцүүлэх талаар бид юу хийх ёстой юм бэ? Энийг ямар хугацаанд баталгаажуулж тэрийг хангаж чадахгүй байгаа бол ямар арга хэмжээ авах ёстой юм бэ? Энэ л бидний хамгийн өмнө тулгамдсан зорилт.

Сая тэр Одонтуяа энэ тэр гээд арваад гишүүд өнөө сахарлаг ихтэй бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай оруулж ирж байна лээ. Энэ яг зөв байхгүй юу. Хүний эрүүл мэндэд нөлөө үзүүлээд байгаа бүтээгдэхүүн үйлдвэрлээд байгаа энэ үйлдвэрүүдээ яах юм? Импорттоо яах юм? Үгүй ээ үнэхээрийн л өвчлүүлдэг нь үнэн. Эрүүл мэндэд нь сөрөг нөлөө үзүүлдэг нь л үнэн юм бол одоо тэгээд мөнгө цагаан нүд улаан гээд яваад байх юм уу? Эс үгүй бол энүүнийг чинь хязгаарлаж барьж энэ ирээдүйнхээ эрүүл мэндийг хамгаалах юм.

Энэ л асуудал шүү дээ. Тэгээд явж явж эцсийн дүндээ энэ нийгмийн эрүүл мэндийн асуудал дээр иж бүрэн үнэлгээ хийдэг тогтолцоо хэрэгтэй. Тэрүүн дээр тулгуурлаад төсөв хөрөнгөө гаргаж чаддаг тэр асуудал нь л хэрэгтэй. Ерөөсөө энэ хуулийн амьдрах амин сүнс эргээд энэ хууль гарснаар иргэд олон түмэнд маань наалдах наалдац нь энэ л агууламж дотор байгаа л гэж би хараад байгаа. Тэрнээс биш маш олон харилцааг зохицуулаад яриад байж болно. Барьж авах юмтай үлдмээр байна шүү дээ. Энүүнийгээ л углуургаар нь харах ёстой. Энэ хэр тусаж ороо вэ? Би энэ ажлын хэсгийнхнээс сайдаас асууя.

Г.Занданшатар: Анужин Нийгмийн бодлогын байнгын хороон дарга Пүрэвочирын Анужин гишүүн хариульяа.

П.Анужин: Баярлалаа.

Батжаргал гишүүн маш чухал асуудлыг хөндөж байна. Энэ нэгэнтээ бид

нар нийгмийн эрүүл мэндийн талаар ярьж байгаа юм бол энэ иргэдээ эрүүл амьдралын хэв маягт соён гэгээрүүлэх ажлыг бага наснаас нь хэрхэн хийх юм бэ энэ ер нь сурах бичигт тусгах ёстой юм уу гэсэн асуудлыг маш чухал асуудал юм байгаа юм. Ер нь энэ соён гэгээрлийн асуудалд ялангуяа хүүхдүүдийн сурах бичгийн асуудалд эрүүл мэндийн асуудал төдийгүй ер нь улс орны чухал хүн эрүүл явахад хүн эрүүл амьдрахад хүн хөгжихөд чиглэгдсэн олон асуудлуудыг бид нар сурах бичигт тусгах шаардлагатай байгаа.

Манай ажлын хэсгийнхэн энэ ажлын хэсэг хуралдах үеэр энэ асуудлыг тавьсан. Бид нар Боловсролын яамныхантай бас ярьсан юм байгаа юм. Тэгээд Боловсролын яамныхан бол энэ дунд сургуулийн сурах бичгийг албан ёсоор өөрчлөгдөх ажлыг ирэх оноос нэгдсэн журмаар хийж эхлэх юм аа.

Тэгэхээр бид нар бол энэ эрүүл мэндийн чиглэлд тусгасан асуудлуудыг бас боловсруулж байгаа гэдэг хариулатыг өгсөн. Тэр тусдаа явах хууль яах вэ. Бид нар энэ хуульдаа яаж тусгасан юм бэ гэхээр хүний амьдралын зөв хэв маягт сурах гэдэг энэ тусгай зүйл заалтыг оруулж өгсөн. Эндээ бид нар энэ зөв хэв маягт сургахад ямар байгууллага ямар үүрэг гүйцэтгэх юм бэ гэдгээ л бид нар маш тодорхой оруулаад өгчихсөн. Яг таны хэлсэн тэр норматив хүн яаж эрүүл байх вэ гэдгийг бол тэр хариуцсан байгууллагууд нь өөрсдөө нарийн журмаа гаргаад зохицуулаад батлаад явна гэсэн. Ийм зүйлийг бид нар оруулсан байгаа. Ер нь би ахин нэмж хэлэхэд сая ажлын хэсгийн дарга ч хэлж байна, эрүүл мэндийн сайд ч хэлж байна.

Энэ хуулийн маань хамгийн чухал зүйл юу вэ гэхээр ерөөсөө л өвдсөнийх нь араас хөөж барьж чаддаггүй, энэ өвдсөнийх нь араас явдаг энэ тогтолцоог л бид нар өөрчилье. ЭМД-ын сангаас гарч байгаа энэ мөнгийг бид нар урьдчилан сэргийлэх энэ чиглэл рүү зарцуулж байя

гэдгийг бид нар бодлогын хувьд буюу хууль эрх зүйн хувьд нь нээгээд хуулиа батлаад өгч байгаа юм.

Хоёрдугаар бас чухал зүйл гэвэл үүнд шаардлагатай төсвийн асуудлыг хэрхэн шийдэх юм бэ. Энэ бүх асуудлыг ЭМД-ын сангаас гээд дааж чадах, чадахгүй, энэ хөвөрсөөр явах юм уу. Бид нар үүнийг улсын төсөвт яаж суулгах вэ гэдэг асуудлыг хууль эрх зүйн хүрээнд нь маш тодорхой зааж өгсөн гэдгийг хэлэх хэрэгтэй байна.

Ахиад энэ сурах бичиг болоод бусад энэ нарийн зохицуулалтаар холбогдох зүйлүүд дээр манай Баярболд дарга гүйцээгээд хариулт өгье.

Г.Занданшатар: 85 Баярболд. Энэ хариулт нь нийтдээ 5 минутад багтах ёстой. Энэ чинь ингээд дамжуулж ярьсаар байгаад энэ цаг амжихгүй тойруулж ярьсаар тойруулж ярьсаар байгаад сүүлийн мөчид нь тэр шийднэ ээ л гээд л тэгэх юм. Баярболд 85.

Д.Баярболд: Нийгмийн эрүүл мэндийн асуудал зөвхөн энэ хуулиар биш маш олон хуулиар зохицуулагдаж байгаа. Тухайлбал иргэд иргэдийн эрүүл мэнд бие бялдрыг дэмжих асуудлыг Биеийн тамир спортын тухай хуульд тусгасан. ЕБС, СӨБ-ын сургалтын хөтөлбөрт бас яг энэ эрүүл мэндийн боловсрол олгох асуудлыг тусгаж хэрэгжүүлнэ ээ гээд. Боловсролын ерөнхий хуульд тусгагдсан учраас бид бас энэ хууль боловсруулж байх явцдаа нэг бүлгээ бүүр авсан байгаа. Энэ бусад нийгмийн салбарууд энэ хуулийн төслийн 5.11-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх асуудлыг улсын хөгжлийн бодлогодоо төлөвлөд явахаар оруулж ирсэн ийм байгаа. Мөн энэ сөрөг хүчин зүйлийн нөлөөллийг судлан тогтоох асуудлын хувьд энэ өвчний хяналт сэргээлтийн асуудал хариуцсан нийгмийн эрүүл мэндийн асуудлыг үндэсний түвшинд хариуцсан байгууллага болон нийгмийн

эрүүл мэндийн төвүүд дээр нийгмийн эрүүл мэндийн лабораториуд ажиллана.

Энэ дээр бол байнга судалгаа шинжилгээтэй тандалтуудыг хийгээд энэ тандалтаар гарсан үр дүнгээ бид бас энэ Эрүүл мэндийн үндэсний зөвлөлдөө танилцуулж энэ салбар хоорондын уялдаа холбоог хангаж шийдвэрлүүлэхээр хуульд тусгаж явсан байгаа.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Ингээд тэнд тийм юм байгаа энд ийм юм байгаа гэвэл байхгүй юм байхгүй л дээ. Угаасаа бүгд байгаа. Хамгийн гол нь энэ хууль чинь өөрөө анхдагч хууль гэж үзэж байгаа бол энэ хуульдаа үндсэн харилцаагаа тусгаад тэр цаад хуульдаа тэр нь задарч ордог хэлбэрээр явж байж наадах чинь нэгдсэн тогтолцоо хяналтын чинь систем ажиллана аа. Тэгэхгүй бол энд тэндхийн юм яривал яриад байж чадна хэдүүлээ. Энийг нэлээн бодмоор байна.

Хоёр дахь зүйл хэдүүлээ энүүнийг ярьсан нь дээр. Энэ нийтийн эрүүл мэнд биеийн тамирын үндэсний хөтөлбөр гаргаад тэгээд тэрэн дотроо бүүр яг хүрэх түвшин, зорилтот түвшин энэ тэр бүх юмаа тусгаж багтааж оруулмаар байна аа. Тэгэхгүйгээр бид нэг хууль гаргаад бусад хуулиудад байгаа гэж яриад энэ ярьж байгаа асуудлыг нааштай шийдэхэд бас тийм амар биш шүү үнэнийг хэлэхэд. Бодлогыг төвлөрүүлж зөв зүгт нь харуулаад тэр лүүгээ нийт.

Г.Занданшатар: Чинзориг сайд.

С.Чинзориг: Энэ анхны хэлэлцүүлэг Батжаргал гишүүнтэй бол би санал нэг байгаа юм аа. Хуучин социализмын үед биднийг нөгөө бага байхад чинь ХБ тэмдгийн норм хангуулна гээд л баахан хийдэг байсан юм. Тэр нь тийм л юм хийе гэж л Батжаргал дарга хэлээд байх шиг байх юм.

Засгийн газар бол иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхтэй холбоотой асуудлаар тогтоол гаргасан. Боловсролын сайд Батлан хамгаалахын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Спортын сайд, Эрүүл мэндийн сайд нар хамтраад иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ийм төлөвлөгөө баталж ажиллах үүрэг өгсөн. Энэ төлөвлөгөөг 5 сайд хамтраад баталж байгаа. Энэ төлөвлөгөөний нэг хэсэг нь яг одоо таны яриад байгаа тэр нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхдээ энэ эрүүл амьдралын идэвхтэй амьдралыг бас хэвшүүлэхтэй холбоотойгоор асуудлууд орж байгаа. Бид нар тэр Тусгай сангийн тухай хууль өнгөрсөн онд баталсан. Тэр хүрээндээ Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг бас нэмэгдүүлж байгаа. Тэр хүрээндээ.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Батжаргал гишүүний хөндөөд байгаа асуудал маш зөв асуудал байгаа юм. Энэ Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль ч гэсэн бас энэ рүү л агуулга нь чиглэх ёстой. Өвдсөний дараа эмчлэх эндээ л олон жил анхаарч эхэлсэн. Өвдөхөөс урьдчилан сэргийлэх өвдөхгүй байгаа хүмүүсийг яаж урамшуулж дэмжих вэ? Энэ рүү ерөөсөө бодлого таг орхигдчихсон байгаад байгаа юм.

Тэгээд энэ хуулийг харахаар бас л нэг тэр тал руугаа бас анхаарч байгаа юм харагдахгүй л байгаад байна л даа. Тэгээд асуулт асууя даа. Хариулаад өгөхгүй юу. Өнөөдөр чинь бид нар ингээд эрүүл мэндийн даатгал төлөөд тэгээд даатгалтай иргэд нь жилдээ нэг удаа үзлэг оношилгоо, шинжилгээ үнэ төлбөргүй хийгдээд эрүүл мэндийн хуулиараа бид нар эмнэлэгт очоод хэвтэх юм бол ерөөсөө л хурдан хугацаанд эмчлээд л аль болох гүйцэтгээд санхүүждэг болчихсон учраас хүмүүс аль эмнэлгүүд аль болох уриалгахан хүлээж

аваад аль болох их эмчилгээ хийхийг боддог болчихсон ийм болчихсон. Тэгээд нөгөө нэг сан хангалттай хөрөнгөтэй болчихсон.

Гэтэл энэний цаад талд нь нөгөө л хөрөнгө л гараад байгаа юм л даа. Гол нь энэ хөрөнгийг бага гаргаад иргэдээ аль болох бага өвчлүүлэх өвдөхөөс урьдчилан сэргийлээд өөрсдөө өөртөө анхаарч байгаа. Тэр фитнес хичээллэж мөнгө зарж байгаа ууланд алхаад эрүүл агаарт алхаж байгаа гадаа гараад гүйж байгаа зааланд тоглож байгаа энэ хүмүүс чинь тодорхой хэмжээгээр өвдөхгүйн тулд бас өөрсдөө зардал гаргаад өөрсдөө тийм үү эрүүл мэндийн боловсролтой учраас илүү анхаараад ингээд өөртөө ч ачаалал дарамт үүсгэхгүй, төрд ч ачаалал, дарамт үзүүлэхгүй эмнэлгийн эрүүл мэндийн байгууллагад ч ачаалал, дарамт үзүүлэхгүй л яваад байгаа юм л даа. Тэгээд энэ хүмүүсийг улам дэмжсэн, энэ хүмүүсийг улам тийм үү урамшуулсан ийм бодлоготой болчих юм бол тэр өвддөг эмчлүүлдэг хүн чинь цөөрнө өө. Үүнийг л уяж ингэхийн тулд эрүүл мэндийн боловсрол гэдгээс нь хүүхдийг сургуульд байхаас нь авхуулаад та тэгээд өвдөхөөс урьдчилан сэргийлэх ёстой шүү. Өвдөх юм бол хэцүү байдаг юм шүү.

Өвдөхөөс урьдчилан сэргийлж ингэх юм бол төр засгаа ингэж дэмждэг юм шүү гэдгийг нь ойлгуулаад тэгээд тэр хүмүүс нь биеийн тамир спорт, нийтийн биеийн тамир спортоор хичээллээд ингээд явбал нь эцэстээ эрүүл мэндийн тогтолцоо маань зөв болно л доо. Одоо яаж байна гэхээр өвдөх юм хангалттай эмчилнэ. Даатгалаа төл, даатгалаа төлөх юм бол дуртай газар үзлэг, оношилгоо, шинжилгээ үнэгүй хийнэ. Ингээд байхаар чинь улам л нөгөө өвдөхийг дэмжсэн бодлого болчихоод байна шүү дээ. Энэ хууль дээр чинь яг нөгөө талд нь явж байгаа бодлого хаана байна. Үүнийг хариулж өгөөч. Би мэргэжлийн улсуудаас, энэ Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хүрээлэн энэ

холбогдох улсуудаас нь асууя даа. Энэ л явах ёстой шүү дээ. Тогтолцоо чинь, бодлого чинь жоохон буруу яваад байгаа юм биш үү.

Дээрээс нь нэмээд би тэр энэ баруун бүсийн эмчилгээ оношилгооны төв гээд баруун 5 аймгийн дунд нэг эмнэлэг байдаг юм. Ховд аймагт байдаг. Тэр эмнэлэг дээр байдаг имрай гэх мэт аппаратууд нь эвдэрчихсэн. Тэгээд Улаанбаатар очиж үзүүлэх шаардлага гардаг гээд. Энэ дээр манай Эрүүл мэндийн яамнаас хөрөнгө оруулалт талд нь анхаарч байгаа зүйл байгаа болов уу. Үүнийг бас сайдаас асууя.

Хоёрдугаарт нь, Эрүүл мэндийн даатгалаа малчид нөгөө мах сүү, ноос ноолуурынхаа урамиууллаас төлөх тогтолцоог бий болгочихсон. Одоо энэ хэр зэрэг төлөгдөж байна. Үүнийг малчид иргэд маань хэр зэрэг мэдэж байгаа юм бол. Уг нь даатгалаа төлчих юм бол тэр иргэд чинь өөрсдөө үзлэг оношилгоогоо үнэ төлбөргүй хийлгэх бололцоотой болчих гээд байдаг. Даатгалыг нь хавар, намартаа ноолуураас, махнаас олдог орлогоос нь биш ерөөсөө л тэр урамиуулал дээрээс нь суутгаад авчихдаг ийм болчихвол малчиддаа ч хялбар, нөгөө талдаа ЭМД-ын сан ч гэсэн бүртгэх бололцоотой, тэр сан бас арвижих бололцоотой болчихоод байгаа юм. Аль, аль талдаа ашигтай юм. Үүнийг хэрхэн яаж хэрэгжүүлж байна. Ямар үр дүн гарч байгаа бол. Энэ дээр нэг хариулт өгөөч.

Г.Занданшатар: Чинзориг сайд хариулъя.

С.Чинзориг: Би Бямбацогт гишүүний асуултад хариулъя. Тэгээд Бямбацогт гишүүнтэй би санал нэг л байгаа юм. Ерөөсөө ингээд өвдсөн хойно нь эмчлэх гээд хамаг байдаг төсвийн хөрөнгөө, даатгалын сангийн хөрөнгийг гэвж байна л гэж. Тэгээд бид нар өвчилсөн хойно нь эмчлэх гээд араас нь хөөгөөд, хөөгөөд гүйцэхгүй юм байна

билээ. Тийм учраас олон улсын энэ хөгжлийн жишигт нийцүүлээд эрүүл мэндийн салбарынхаа бодлогодоо өөрчлөлт оруулъя, тогтолцоондоо өөрчлөлт хийе. Ер нь Эрүүл мэндийн тухай хуулиараа ч гэсэн Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль эрх зүйн орчинтой байхаар хуульчлагдсан. Ингээд арваад жил энэ хууль гарахгүй яваад ирчихсэн. Тийм учраас энэ өвчлөхөөс нь өмнө урьдчилан сэргийлдэг байх энэ тогтолцоо руу оруулъя бодлогоо өөрчилъе л гэж байгаа юм. Өвчлөхөөс нь өмнө нийгмийн эрүүл мэндийн шатад зарцуулсан нэг доллар зарцуулбал, өвчилсний дараа эмчлэх зардлыг 7 дахин хэмнэдэг гэсэн ийм олон улсын судалгаа байдаг юм байна. Тийм учраас бид нар өвчилсөн хойно нь ийм их өндөр өртөг зардлаар эмчлэх гэж хөөх биш урьдчилан сэргийлдэг. байх энэ цоо шинэ анхдагч хууль л оруулж ирж байгаа юм.

Тэр малчдын ноос арьс ширний урамиуулал яг нийгмийн даатгал болоод ЭМД-ын төлөлтөд оруулан тооцдог байх хууль батлагдсан. Журмыг нь Засгийн газар баталчихсан. Энэ хууль ирэх оноос хэрэгжинэ. Тийм учраас ирэх жилээс хэрэгжихэд нь Хөдөлмөр хамгааллын яамтай хамтарч хэрэгжилтийг нь бас эхнээс нь зөв шуурхай хангах тал дээр нэлээн ажиллана гэж.

Нэг асуудал бий Бямбацогт гишүүн ээ. ЭМД-ын сангийн зарлага тал нь эрүүл мэндийн сайдын багц дээр явдаг. Орлого бүрдүүлэх асуудал нь одоогийнхоо хуулиар нөгөө нийгмийн даатгалын 5 сангийнхаа нэг хэвээрээ байгаа. Өөрөөр хэлбэл орлого бүрдүүлэх асуудал нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд дээр байгаа. Гэхдээ бид нар орлого бүрдүүлэх нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд дээр байгаа гээд хаядаггүй. Хамтраад ЭМД-ыг ашиг тусыг сурталчлах, нөлөөллийг нэмэгдүүлэх, даатгалд хамрагчдын тоог нэмэгдүүлэх гээд нэлээн хамтарч

ажиллаж байгаа. Энэ урамшууллыг 2 даатгалын шимтгэл төлөлтөд хамруулан тооцдогтой холбоотой асуудлыг ч гэсэн хамтарч ажиллана.

Ховд аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээ төвтэй холбоотой асуудлууд би бас жаахан даргынх нь асуудал жаахан яригдаж байгаа. Өмнөх дарга нь 3 шатын шүүхийн шийдвэртэй байсан учраас 3 шатын шүүхийн шийдвэрийг ханган биелүүлэх арга хэмжээ авсан. Ингээд удахгүй тэр одоо байгаа даргыг нь өөрчилж хуульд нийцүүлж даргатай болох асуудал яригдаж байгаа. Танай дээр байгаа тэр тоног төхөөрөмжтэй холбоотой асуудлыг бид нар ирэх оны төсвийн хүрээнд шийдэх мөн бусад төсөл хөтөлбөрийн хүрээнд шийдэх ямар бололцоо байна. Түүнийг нь судалж үзье. 2023 он дуусаж байна. Нөгөө талаасаа 2023 оны төсөв дээр эрүүл мэндийн салбарт хийгдэх шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийг санхүүжилтэд нэг ч төгрөг тусаагүй учраас 2023 онд тоног төхөөрөмж авч өгөх ийм боломж байхгүй байгаа. Тэгээд 2024 оны төсөв хэрэгжээд ирэхлээр бас анхаарна гэсэн ийм бодолтой байна.

Г.Занданшатар: Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хууль их чухал хууль л даа. Цаашидаа бид нар нийгмийн эрүүл мэнд, энэ нийгмийг эрүүл байх асуудал дээр онцгой анхаарах хэрэгтэй. Ер нь манай эрүүл мэндийн газрын тогтолцоо их буруу яваад байна уу гэж миний хувьд боддог. Хуучин бол юу гэдэг юм, энэ аймгуудын эрүүл мэндийн газарт, сумдын эрүүл мэндийн нэгдсэн газрууд дээр аймаг, нийслэлийн биеийн тамир спортын газрууд хамаардаг нэг тогтолцоотой байсан. Тэгээд сүүлд нь салгачихсан. Тэр үед аймгийн эрүүл мэндийн газрууд нийтийн биеийн тамирын чиглэлээр олон ажлуудыг зохион байгуулдаг байсан.

Тэгээд энэ үндсэндээ хаягдсан. Тэгээд манай эрүүл мэндийн салбарын талаар би сая Чинбүрэн эмчтэй ярьж байлаа. Эрүүл мэндийн салбарын бүх хүмүүс л ярьдаг. Өвдсөн хойно нь биш өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлдэг баймаар байна гэж. Энэ домог болчихсон яриа. Энэ чиглэлээр юу ч хийдэггүй.

Тийм учраас цаашидаа бид нар энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа энэ ААНБ, төрийн бус байгууллагуудаа яаж дэмжих юм. Энэ зөв хооллолтын талаар ярьж байгаа, энэ зөв дадлын тухай ярьж байгаа. Энэ архидалт, тамхидалт, таргалалтын талаар ярьж байгаа, энэ фитнесийн үйл ажиллагаа явуулж байгаа энэ хүмүүсийг яаж урамшуулж дэмжих юм. Төрөөс. Бид нарын энэ чиглэлийн үйл ажиллагаа дутагдаад байгаа учир л энэ асуудлууд чинь цаашидаа явахгүй байна, явахгүй байгаа юм. Тийм учраас цаашидаа бид нар энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа энэ ТББ, иргэдийг дэмжих хөрөнгө мөнгийг нь гаргаж өгөх энэ асуудал дээр л онцгой ярьж байгаа юм. Тэгээд яриад л байдаг, тэгээд мөнгөө тавьдаггүй тогтолцоогоо нэг эргээж хармаар байна. Бид нар биеийн тамир спортынхоо салбарыг, эрүүл мэндийнхээ салбартаа уямаар байна. Боловсролынхоо салбарыг, эрүүл мэндийн салбартайгаа уямаар байна. Энэ бүх чиглэлийн салбарын уялдааг хангаж байж л нийтээрээ эрүүл байх энэ асуудал чинь л явагдана.

Тийм учраас би энэ чиглэлээр ер нь ямар заалтууд тусгагдсан юм бэ. Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа энэ ТББ иргэдийг яаж урамшуулах юм, яаж дэмжих юм, ийм заалтууд тусгагдсан байгаа юу гэдэг дээр бас нэг асуулт асууя. Дээр нь бид нар бас энэ эрүүл байх зөв дадал зуршилтай байх, тусархуу нийтийн биеийн тамир ч юу гэдэг юм. Бие бялдрын хүмүүжилтэй байх асуудлыг Хүмүүнлэг боловсролын тухай хуулиараа бид оруулж ирж байгаа шүү дээ. Тэгээд олон хуулиар ингэж оруулж

ирснээс энэ Хүмүүнлэг боловсролын тухай хуулиараа оруулж ирээд энэ дээрээ тодорхой хөрөнгийг нь тавиад ингээд ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын цэцэрлэгүүдэд энэ чиглэлийн сургалтуудыг хамгийн түлхүү явуулах нь чухал болчхоод байгаа юм. Бид аль болохоор эрүүл байх, нийтээрээ хөдөлгөөнтэй, эрүүл байх зөв дадал зуршилтай байх энэ чиглэлийн үйл ажиллагааг насан туршид нь олгодог ийм сургалтын хөтөлбөртэй, ийм хуультай байх нь хамгийн чухал байгаад байгаа юм.

Тийм учраас энэ тогтолцооныхоо асуудлыг нэг эргэж хараад, энэ Биеийн тамир спортын улсын хороог Эрүүл мэндийн яамтай нэгтгэдэг юм уу, ингэж байж энэ хосолсон хэлбэрээр нийтийн эрүүл мэндийн, нийтийн биеийн тамирын асуудал бас явагдах болов уу гэсэн ийм бодолтой байна. Ийм 2 асуултыг асууж байна.

Г.Занданшатар: 85.

Д.Баярболд: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд олон нийтийн оролцоог хэрхэн хангах вэ гээд. Энэ дээр бид нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлүүдийг тодорхойлж өгсөн. Энэ төрлийн тусгагдсан үйл ажиллагааг төрийн болон ТББ, олон нийтийг оролцоотойгоор гэрээгээр гүйцэтгүүлж болно гэж заасан. Мөн энэ олон нийтийн сайн дурынхны оролцоог хангаж өгөх заалтуудыг нэмсэн. Үүнтэй холбогдуулаад энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд олон нийтийн оролцоог хангах, сайн дурын ажилтныг урамшуулах журмыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж тусгасан байгаа. Эрүүл мэндийн боловсрол олгох асуудлаар одоо бол бид Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээд, 5 яам хамтарсан арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж явж байгаа. Энэ хуульд Монгол улсын хөгжлийн бодлогод энэ эрүүл мэндийн

боловсролын асуудлыг заавал тусгаж, энэ хөгжлийн бодлого, түүний төлөвлөлтийн тухай хуулийн дагуу хэрэгжүүлнэ гэж зааж өгсөн байгаа.

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Энэ хуулийг дэмжиж байгаа маш чухал хууль орж ирж байна. Ер нь Монголын ард түмэн сэргийлж болох энэ өвчнөөр нас баралтын 77 хувийг нь багасгаж сэргийлж болох тийм боломж байгаа шүү дээ. Энэ асар том боломж. Эрүүл мэндийн салбарын 50 мянга гаруй ажиллагсдын 1.9 хувь нь л энэ нийгмийн эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа. Дэндүү харамсалтай энэ бол бидний бас арчаагүй байдлын илэрхийлэл л дээ. Тэгээд эрүүл мэндийн тухай хуулийн 13.1 ерөөсөө биелээгүй, хэрэгжүүлдэггүй хэрэгжээгүй Эрүүл мэндийн яамны сайдын 2012 оны 250, 2014 оны 415, 2020 оны А/38 дугаар тушаалууд нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах шийдвэр гарсан боловч огт хэрэгжээгүй. Энэ дээр огт мөнгө тавьдаггүй. Гээндээ ч бий, гоондоо ч бий. Энэ асуудлыг Сарангэрэл гишүүн сайд байхдаа маш их хөөцөлдөж бас бэлтгэл ажлуудыг хангаж байсан. Өнөөдөр ингээд Чинзориг сайд бас оруулж ирж байгаа явдал үнэхээр чухал хууль. Үнэхээр энэ бас цаг үеэ олсон байна. Тэгээд би асуух гэж байгаа зүйл 1 дүгээр асуулт, хуулийн төслийн 3.1.21. та нар яг төслүүдээ хараарай. 4.1.7, 5.3.5, 9.1.5, 11 дүгээр зүйл, 11.1.2, 11.1.3 Нийгмийн эрүүл мэнд мэндийн тусламж үйлчилгээнд олон нийтийн оролцоо, сайн дурын ажилтныг чухалчлах, олон нийтийн түншлэл хамтын ажиллагаа, олон нийтийн хяналт тавих, олон нийтийн оролцуулах, хамтын шийдвэр гаргах, олон нийтийн хяналт бий болгох гэсэн 8 нэр төрөл энд яригдаж байна. Олон нийтийн гэдэг энэ зохицуулалтыг зүгээр тунхаг маягтай болгочихжээ. Энэ яг хэрэгжүүлэх механизм энд ерөөсөө байхгүй байгаад

байна. Энэ талаар надад дэлгэрүүлж ярьж өгөөч, ямар механизм байгаа вэ?

Хоёрдугаар зүйл, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд Монголын уламжлалт анагаах ухааны ихээхэн чухал. Ер нь явдал мөрөө зохицуулах гэдэг л гол юм шүү дээ. Идэш ууш явдал суудал гэж ярьдаг. Энэ уламжлалт анагаах ухааны заалтууд энд маш бага орсон байна. Энэ механизм дээр яагаад оруулж болохгүй ажиглачхав аа. 2 асуулт асуулаа.

Би дуусаагүй байна. Би дараад нь энэ дээр тодруулж хэлбэл, Монголын хуулийн төслийн 2 дугаар бүлэгт халдварт болон халдварт бус өвчний хяналт орчин хөдөлмөр гээд байж байгаа, 3 дугаар хуудсыг ярьж байна шүү. Энэ дээр Монголын уламжлалт анагаах ухааныг яагаад оруулаагүй юм бэ? Хаячихсан байна. Хуудас 4-д, энэ бүлэгт нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх байгууллагыг дараах байдлаар тодорхойлов гэж байна. Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төв байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв гээд ингээд байгууллага дотор уламжлалт анагаах ухааны ямар ч үнэр алга. Яагаад үүнийг оруулсангүй вэ, энэ дээр орчих болов уу гэж би их горьдлоо л доо. Азаар энэ хуудас 14-д, хуулийн 4 дүгээр зүйлийн үйл ажиллагааны баримтлах зарчим дотор 4.1.5 дээр үндэсний онцлог уламжлалд суурилсан гээд таслал тавиад олон улсын гээд явчхаж байгаа юм аа. Энэ үндэсний уламжлалт анагаах ухаан чинь л яг энэ нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх гэдэг асуудал шүү дээ. Бид сэтгэлгээндээ өөрчлөх хэрэгтэй. Сэтгэлгээгээ онцлогийг нь өөрчлөх хэрэгтэй. Сайн өвчин.

Г.Занданшатар: Баярболд 85.

Д.Баярболд: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлийг нийтдээ

8 төрөлд хуваасан байгаа. Гэхдээ энэ 8 төрлийн тусламж үйлчилгээг үзүүлэхийн тулд бид энэ эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх зарчмыг баримталж ажиллана. Уламжлалт анагаах ухаан, уламжлалт зан үйлийн асуудлыг бид нар 4.1.5 дугаар заалтад үндэсний онцлог, уламжлалд суурилсан, тэгээд олон улсын жишиг хөгжлийн хандлагад нийцсэн байх гэдгээр томъёолж өгсөн байгаа.

Г.Занданшатар: Механизм санцрыг нь асуугаад байна.

Д.Баярболд: Олон нийтийн оролцооны асуудал дээр эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ олон нийтийн оролцоог хангах, сайн дурын ажилтныг урамшуулах журмыг батална гээд зааж өгсөн байгаа. Одоо бас манай энэ эрүүл мэндийн тогтолцоонд төрийн болон ТББ олон нийтийн оролцоотой хэрэгждэг арга хэмжээ байдаг. Тухайлбал энэ Глобал сангийн дэмжлэгтэй хэрэгждэг төсөл дээр бид энэ зорилтот бүлгийн хүн амд яг одоо энэ төрийн байгууллагаас хүрч чадахгүй үйлчилгээг энэ 2 төрийн бус байгууллагуудаар дамжуулж хүргэдэг энэ механизмыг энэ хуулийн журамд тусгаж өгөөд хэрэгжүүлэх бүрэн боломжтой байгаа.

Г.Занданшатар: Даваажанцангийн Сарангэрэл гишүүн нэмж хариулъя.

Д.Сарангэрэл: Манай гишүүд их чухал асуудлыг хөндөөд байна. Энэ анхдагч хууль гэдгийг түрүүн хэлсэн байгаа. Хэд, хэдэн асуудлыг шийдэж байгаа. Монгол Улсын хүн амын эрүүл мэндийн байдлын талаарх үндэсний дата баазтай болох юм. Энэ дата бааз дээр суурилсан өвчний хяналт, сэргийлэлт, тандалт судалгааны ажил хийгдэнэ. Тэгээд энэ судалгаа чиглэлийнхээ ажил зохицсон үйл ажиллагаа явуулна гэсэн үг. Хамгийн гол нь тухайлбал манай Бямбацогт сайд

ингээд асууж байна. Залуучууд мэдээж хэрэг өвдөх нь бага байдаг. ЭМД-ын шимтгэлээ төлнө. Тэгээд ер нь үүнийгээ хэрэглээгүй өшөө эрүүл саруул амьдралын хэв маягийг өөрөө өөртөө хэрэгжүүлээд, хийгээд явж байгаа залуучуудад, тухайлбал, фитнесийнх нь мөнгийг даах уу, бүжгийн дугуйланд явбал яах юм бэ гэх мэтчилний асуултуудыг асууж байгаа юм.

Ерөнхийдөө манай эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын тогтолцоо бүхэлдээ бас эв санааны нэгдэл дээр явдаг гэдгийг та бүхэн маань мэднэ. Тийм учраас бас үүнийг яг ингэж хуваах юм бол ЭМД-ын сан өөрөө эрсдэлд орох бас тийм аюул бий. Тийм учраас цаашидаа энэ сангуудаа тэр дундаа хувийн даатгалын тогтолцоо руу шилжүүлж байж энэ асуудлыг бас шийдвэрлэх боломж нь бий. Тэгэхдээ бид нар энэ асуудлыг энэ хуулийн зохицуулалтаар огт орхигдуулсан асуудал байхгүй ээ. Ер нь нийгмийн эрүүл мэндийн асуудал гэдэг Монгол Улсын 3.4 сая хүн амд бүгдэд нь хамааралтай учраас бид энэ дээр иргэний оролцоо, төрийн болон ТББ-ын оролцоо, хэвлэл мэдээллийн оролцоо гээд олон оролцооны асуудлыг анх удаа хуульд суулгаж өгснөөр барахгүй энэ оролцоог урамшуулдаг байх ийм тогтолцоог суулгаж өгсөн байгаа. Харин саяын та бүхний асуугаад байгаа тэр нарийвчилсан өвдөөгүй тэгээд өөрөө өөрийгөө эрүүл байх ийм хэв маягт бусдадаа үлгэр жишээ болж авч явж байгаа хүмүүсээ яаж урамшуулах юм бэ гэдгийг энэ заалтууд хуулийг дагасан журмаар шийдвэрлэгдээд явах юм аа. Та нар маань ингэж ойлгож болно. Баярлалаа.

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Олон нийтийн оролцоог хангана гэдэг тэр тунхгийн чанартай зүйлүүдийг хуульдаа болж өгвөл их тийм тодорхой оруулахгүй бол тэгээд олон нийтээс яг яаж тодорхойлох

юм, хэнийг тодорхойлох юм, ямар шалгуураар гаргаж ирэх юм тэгээд хэлэлцээрийн маягаар явах юм уу, гэрээний маягаар явах юм уу гэдэг нь тодорхой биш байна гэдэг тунхаг болчихоод байгаа юм шүү. Үүнийг дараагийн хэлэлцүүлгээр тодорхой болгож өгнө гэж би найдаж байна.

Хоёрдугаар зүйл гэвэл, уламжлалт анагаах ухааны энэ төлөөллийн байгууллагуудтай би энэ урьд урьдчилсан энэ бэлтгэлийг нь ингээд харсан чинь тэд нартай та нарыг оролцуулсан, ямар ч саналыг нь авсан зүйл энэ дээр байхгүй байна. Авсан бол надад энд хэлээч ээ.

Гуравдугаар зүйл, ер нь сэтгэлгээгээ өөрчилмөөр байна. Олон өвчин илрүүлээд, олон өвчин эмчлээд, хагалгаа хийгээд байвал анагаах ухааны салбарыг сайн гэж үзэхгүй. Олон эм зараад байвал анагаах ухааны салбар сайн байна гэсэн үг биш. Харин өмнөх жилийг бодоход энэ жил энэ өвчлөл 30 хувь.

Г.Занданшатар: Содномын Чинзориг сайд.

С.Чинзориг: Би Ганбаатар гишүүнийг бидэнтэй санал нэг байгаа юм байна гэж ойлгосон. Бид олон жил ингээд өвчилсөн хойно нь эмчлэх гэж эмнэлгийн тусламж үйлчилгээндээ асар их хүч хөрөнгө зарцуулж байна. Дэлхийн олон улсын жишгийн хөгжлийн эсрэг бид яваад байна. Нийгмийн эрүүл мэнд, анхан шатын тусламж, үйлчилгээндээ эрүүл мэндийн тусламж үйлчилгээний 50-аас 60 хувь нь үзүүлдэг. Хөрөнгө санхүүгийнх нь 50-аас 60 хувь үзүүлдэг. Бид дөнгөж 20-хон хувийг нь л үзүүлээд байна. Тийм учраас Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль зайлиггүй шаардлагатай байна. Энэ Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль батлагдвал эрт илрүүлэг улсын хэмжээгээр нэлээн явагддаг болно. Бид нар хавдрын өвчлөлөөр хамгийн их өндөр байна. Хавдраар шалтгаалсан нас баралт их

өндөр байна л гээд байдаг, Ганбаатар гишүүн ээ. Гэтэл хавдрын өвчлөлийн чинь 74 хувь нь дандаа хожуу оношлогдсон. Өөрөөр хэлбэл 3 дугаар, 4 дүгээр үедээ оношлогдоод.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. ХААИС-ийн ХАА-н Төв номын сангийн хамт олон Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхний ном эрдмийн ажилд өндөр амжилт хүсье.

Даваажанцангийн Сарангэрэл гишүүн хариулъя.

Д.Сарангэрэл: Ганбаатар гишүүн чухал асуудлуудыг хөндөж байгаа. Ер нь ДЭМБ, европын чиглэлийн анагаах ухаан, уламжлалт анагаах ухааныг хослуулж хөгжүүлэх ийм зөвлөмжийг улс орнуудад өгсөн байгаа. Өөрөөр хэлбэл уламжлалт анагаах ухааныг ДЭМБ хүлээн зөвшөөрөөд нэлээн хэдэн жил болж байгаа. Тэгээд ийм нөхцөлд нийгмийн эрүүл мэндийн чиглэлд тэр дундаа урьдчилан сэргийлэх энэ үйл ажиллагаанд бид нар уламжлалт анагаах ухаанаа ашиглах бүрэн боломж бий. Энэ бол Монгол Улсын бидний өв баялаг, үндэсний нөөц гэж хэлж болно. Тэгээд би дараагийн хэлэлцүүлэг дээр энэ талаар нэлээн тодорхой болгож оруулж ир гэдэгтэй санал нийлж байна. Ажлын хэсэг хүлээж авч байна.

Тэгээд энэ хуулийн төслийн 4.1.5-д бас уламжлалт анагаах ухаан гэдэг заалтаа оруулсан. Энэ нь урьдчилан сэргийлэх болон бусад нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаандаа уламжлалт анагаах ухаанаа хамтатгаад аваад явна. Тэр дундаа эрүүл мэндийн боловсролын чиглэлд нэлээн түлхүү уламжлалт анагаах ухаанаа оролцуулах ийм бодлогоор бид нар энэ заалтыг.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Ингээд бид нар хууль яриаад, хууль батална гэдэг нэг хэрэг. Хууль батлагдчихна л даа. Тэгээд нөгөө хуулиа биелүүлнэ, хуулийн хэрэгжилт гэдэг юм байна. Улсын Их Хурал олон сайхан хуулийг баталж гаргаж байгаа. Тэгээд хуулийн хэрэгжилт маань амьдрал дээр яаж бууж байна вэ гэдэг асуудал. Тэр нь яг өнөөдрийн ард иргэдийн өвчин эмгэг туссан байдал. Бусад улс орны иргэдтэй ингээд харьцуулаад үзэхэд харагдаж байгаа юм л даа. Яах вэ, ерөнхийдөө цаг үеэ олсон зөв зүйтэй хууль орж ирж байна, баталж байна, ярьж байна гэж ойлгож байна. Энэ дээр хэд, хэдэн зүйлүүд байгаа юм. Ингээд ярихад би түрүүн хэлж л байсан л даа. Урьдчилан сэргийлнэ. Нэг маягийн амьдралын хэв маягаасаа болоод, хэвшлээсээ болоод, ер нь нэг маягийн идэж ууж байгаа юмнаасаа болоод нэг маягийн өвчин тусаж байгаа шүү дээ. Өнөөдөр Улаанбаатар гэхэд үхлийн хөндий болчихоод л байж байгаа. Энэ агаараас болоод л, тэгээд уушгины өвчин 5 жил, 10 жилийн дараа хавдар маш их болно гэдэг нь хэнд ч ойлгомжтой зүйл болчихсон ийм байгаа.

Нөгөө талаар энэ манай эрэгтэйчүүдийн асуудлыг ярих цаг болсон байна. Эрэгтэйчүүд маань 10 насаар бага насалж байна шүү дээ. Хөдөө орон нутагт манай 35 хүртэлх насны залуучууд маань гэр бүлгүй л явж байна шүү дээ 85 хувь нь. Ийм мэтчилэнгийн зүйлүүд байна. Ингээд сургуулиудыг аваад үзэхээр хуучин гаднаа сайхан биеийн тамирын талбайтай байдаг байсан, одоо нэг ч тийм биеийн тамирын талбайтай ийм сургууль байхгүй болчихсон. Тэгээд цэрэгт тэнцдэг залуучууд гэж байхгүй. Цэргийн ачааллыг даадаг залуу гэж байхгүй. Ийм л болчихоод байна л даа. Энэ аюулын дохио. Үндэсний аюулгүй байдалд нэлээн анхаарах ёстой асуудлын нэг болчихоод байгаа юм аа. Үүнийг хаа, хаанаа ойлгох хэрэгтэй.

Нөгөө талаар 20, 30 жил нийгмийн даатгал ЭМД төлдөг. Жишээлбэл би

төлөөд л яваад байгаа. Тэгээд тэтгэвэр авах нь ойлгомжтой юм шиг байгаа юм. Тэгшитгэсэн тэтгэвэр. Тэр төлсөн мөнгө маань ингээд байршихаараа тэгээд хэн нэгэн нөхөр банкандаа байрлуулаад идчихдэг. Дараа нь 20, 30 саяар торгуулаад явчихдаг ийм зүйл байдаг. Нөгөө хэрэглээгүй, ашиглаагүй хүнийг яаж харж үзэх юм. Нөгөө талаар хиймэл оюун ухаан гээд гараад ирлээ. Энэ маш том боломж байгаа. Өмнө эрүүл мэндийн бүртгэлийг нөгөө эмч нар хийнэ, сувилагч нар хийнэ гээд л баахан цагаа үрдэг байсан. Энд дэлхийн НҮБ-аас 10 сая доллар тавьчихсан байсныг нь 200, 300 мянгыг нь мэдэхгүй, чадахгүй компани ашиглаад буцаачихсан. Энэ талаар манай Байнгын хороон дарга нэлээн араас нь яваад бас үүнийг хэрэглэх нь зүйтэй юм гээд яриад явж байгаа юм байна билээ. Тэр их зүйтэй Анужин гишүүн бол. Нөгөө талаар энэ орон нутагт энэ 2024 онд би хөөцөлдөж байгаад 1 тэрбум тавиулчихсан. Энэ анхан шатын эмчилгээ үйлчилгээ, энэ шилэн зуд болж байгаатай холбогдуулаад бараг урьдчилаад харсан юм даа. Тэгээд Баянхонгор аймгийн малчдад тусалъя, дэмжье. Эрүүл мэнд дээр анхааръя гээд. Үүнийг та Эрүүл мэндийн сайд минь эрүүл мэндийн яг мэргэжлийн хүмүүстэйгээ ЭМЯ-ан дээрээ шалгаруулчихвал зүгээр байна. Тэгэхгүй бол аймаг, орон нутагт түүнийг чинь ойлгодог, ойлгодоггүй тийм хүмүүс байна. Тийм нарийн мэргэжлийн хүмүүс алга байна. Тэгээд л нөгөө нэг явдгаараа явчихдаг, хяналтаа тавьж чаддаггүй, үр дүнтэй ажил болдоггүй ийм асуудлууд байна шүү. Үүнийг танд зориуд анхааруулаад хэлчихье. Тэгээд хэрэгтэй шаардлагатай би бичиг явуулъя. Тэгээд хамтдаа хяналт тавиад, үр дүнтэй ажил болгочих юм сан. Тэгэхгүй бол манай малчид маань бүх юмны ард л хоцорч байна шүү дээ.

Г.Занданшатар: Чинзориг сайд хариулах уу. Содномын Чинзориг сайд.

С.Чинзориг: Ганбат гишүүний асуултад хариулъя. Ер нь манайд энэ эрүүл мэндийн салбарт жендерийн тэгш байдал нэлээн алдагдчихсан байгаа юм билээ. Ер нь нийт бас ажиллагсдын 82 орчим хувь нь эмэгтэйчүүд ажилладаг. Дээр нь энэ эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа асуудал дээрээ ч гэсэн энэ жендерийн эрх тэгш байдлыг яаж бид хангаж, иргэддээ ижил тэнцүү тусламж үйлчилгээ үзүүлэх вэ, тэгш эрхийг нь яаж хангах вэ гэдэг бодлогын өөрчлөлт хийх зайлиггүй шаардлагатай болчихсон юм байна билээ. Сая та ч гэсэн бас яриад л байна. Дундаж наслалт эмэгтэйчүүдээсээ эрэгтэйчүүд маань 10 насаар бага байна. 10 насаар бага байна. Энэ үндсэндээ манай эрчүүд амьдралын хүнд хүчрийг бас үүрч явдаг, ар гэрээ тэжээх гэж цаг наргүй зүтгэдэг, ачааны хүндийг үүрдэг үүнтэй ч холбоотой. Ний нуугүй хэлэхэд бас манай эрчүүдийн эрүүл амьдралын хэв маягтай холбоотой, буруу дадал зуршилд бас нэлээн бас өртсөн ийм байдалтай холбоотой.

Манай монголчуудын дунд энэ архины хэрэглээ, тамхины хэрэглээ бас нэлээн өндөр байна. Үүнээс шалтгаалсан элэгний хавдар, ходоодны хавдар, хоол боловсруулах эрхтний өвчлөл гээд энэ өвчлөлүүд эрэгтэйчүүдийн дунд бас нэлээн өндөр байна. Тэгээд эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийнхээс маш өндөр байна. Тийм учраас энэ эрчүүдийн эрүүл амьдралын хэв маяг, бас хэвшүүлэх, буруу дадал зуршилаас салгах, буруу дадал зуршилд өртөхгүй байх энэ чиглэл дээр бид нар нэлээн бодлого гаргаж ажиллах зайлиггүй шаардлагууд байгаа.

Хоёр дахь, ЭМД-тай холбоотой асуудал дээр. Ер нь бид цаашидаа бодлогоо өөрчилмөөр байгаа юм. Сүүлийн жилүүдэд ЭМД-ын сангийн хөрөнгийг тухайн жилд нь үлдэгдэлгүй зарцуулж байх ёстой гэдэг нэг хэсэг яриад ингэж маш их явсан. Сүүлийн хэдэн жил. Энэ бол үндсэндээ шулуухан хэлэхэд төсвийн

санхүүжилтийг даатгалын сангаар нөхөх гэсэн ийм бодлого явж байсан гэж би тэгж бодоод байгаа юм. ЭМД-ын сан тодорхой хэмжээгээр үлдэгдэлтэй явж байх ёстой сан. Иргэн хүн өөрийн ирээдүйд эрүүл мэндэд нь эрсдэл үүсвэл түүнийг хариуцуулна гэж ингэж даатгаж байгаа мөнгө шүү дээ. Түүнийг нь ингээд заавал тухайн жилд нь зарчихвал дуусгах ёстой гэдэг ийм зарчмаас сүүлийн жилүүдэд нэлээн явж ирсэн. Үүнийг бас засах ёстой, өөрчлөх ёстой гэж бодож байгаа юм. Манай салбарт хамгийн тулгамдаж байгаа асуудал энэ цахимын асуудал, цахимын асуудал. Тийм учраас бид нар энэ Дэлхийн банктэй өмнө нь хэрэгжиж байсан төсөл зогсчихсон. Одоо Ковидын сан гэсэн энэ төслөөс 14 сая долларын санхүүгийн дэмжлэг авахаар бас энэ хүрээнд эмийн чанарын хянан баталгаажуулалтын тээгээд лабораторийг дэлхийн жишигт хүргэх цахимыг бас хөгжүүлэх гээд ийм 2 чиглэлээр ажиллана.

Таны тэр эрүүл мэндийн салбарт тавиулсан 1 тэрбум төгрөг гэдгийг би судалж үзье. Тэгээд яг юунд зарцуулахаар болсон байна вэ, тэр хүрээнд нь зарцуулъя. Хүнд юм өгч болохгүй шүү дээ Ганбат дарга гишүүн ээ. Ирэх жил ингээд он гарчихвал сонгуулийн жил эхэлчихнэ. Хувь хүнд төсвийн мөнгөөр юм өгнө гэвэл өгсөн, өгүүлсэн хэн хэн нь хэрэгт орно. Тийм учраас тэрийгээ тоног төхөөрөмж байх уу, юу байх вэ гэдгийг нь нэлээн сайн бодох хэрэгтэй. Миний баримталж байгаа зарчим яам аль болохоор тендер яаман дээр зарлахгүй, нэг хэсгийг нь Худалдан авах ажиллагааны газраар заруулна, нэг хэсгийг нь орон нутагт эрх шилжүүлж хийгдэнэ гэсэн ийм л.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Ер нь тэр анхан шатад анхаарах энэ бүх юм зөв зүйтэй санал нэг байх шиг байна. Тэр Дэлхийн банкнаас хэрэгжүүлж байсан 10 сая долларын

хэдий хэмжээнд зарцуулагдаад, хэдий хэмжээ нь хэзээ буцчихсан юм бэ. Уг нь тэр хэрэгжээд ингээд амьдрал дээр болгочихсон энэ цахим бүртгэлийн асуудал чинь шийдэгдээд, малчид маань хөдөө гаднаас ирэхдээ шууд ямар нэгэн чирэгдэлгүйгээр үзүүлж харуулаад ингээд явчих байсан. Үүнийгээ дахиад л эхлэх гэж байгаа юм байна. Сайн байна, хурдан хийх хэрэгтэй.

Нөгөө талаар би тэр орон нутгийн ярьж байгаа хэлж байгаа нь орон нутагт нэгдүгээрт мэргэжлийн хүн байдаггүй шүү. Тэгээд ЭМЯ чинь өөрсдөө мэргэжлийн хүмүүс байдаг. Юу хэрэгтэй ямар юм байх ёстой гэдгийг шийдвэрлэж чадах байх аа. Тэгээд орон нутгийн би тэр аваргуудын талаар яриад ч яах вэ дээ. Дунд шатдаа бас авлига, тэр сонгон шалгаруулах энэ тэр арай хэтэрчихсэн шүү дээ. Орон нутгийн нөхөдтэй би хэл ам хийгээд байх сонирхол алга.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Манай улсын хувьд энэ эрүүл мэндийн салбарт ер нь системээр нь өөрчлөлт хийхгүй бол өөрөө маш хүнд байдалтай болоод байгаа шүү дээ. Бид нар уг нь 2018 онд хуулиар гүйцэтгэлээр дамжсан, санхүүжилтээр дамжсан шинэчлэл хийе гэж хууль эрх зүйн орчин бий болгосон. ДНБ-д энэ салбарын эзлэх хувь хэмжээ 3, 4-өөс хэтэрдэггүй байсан бүүр 7.9 гээд бараг 8 дээр дөхөөд оччихсон байгаа. Гэтэл энэ өөрөө бас үр дүнгээ өгөхгүй байна. Бид нар ингээд ажлын хэсгүүд гараад эмнэлгүүдээр явж, өдөржин шөнөжин ажиллаж байгаа эмч мэргэжилтнүүдтэй уулзахад, манай энэ салбарын эмнэлэг эрүүл мэндийн ажилтнууд өөрөө дамжин өнгөрөх баазын нэг л нэг хэсэг болчихоод байна. Гэтэл энэ салбарт эргэлдэж байгаа энэ их 2 их наяд мөнгө хэдхэн монопол компани хувь хүн, хэсэг бүлэг хүмүүсийн халаас руу ороод байна. Үүнийг өөрчлөхгүйгээр явж болохгүй гэж хэлээд

байсан. Бодит байдал шалгалтаар бас ингээд гараад байгаа юм.

Тийм учраас өнөөдөр манайхан ярьж байна л даа. Энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ манайд уруугаа орчихсон гэж яг үнэн. Өнөөдөр 19 хувьтай. Гэтэл өндөр хөгжсөн улс орнууд ой си ди энэ тэр гээд аваад үзэхэд 50, 60 хувьтай байна. Энэ нь өөрөө юу юм гэхээр нөгөө урьдчилсан сэргийлэх, нийгмийн эрүүл мэнд дээрээ илүү их анх анхаарал хандуулдаг. Тийм учраас өвчлөл багатай хэвтэн эмчлүүлэх нь бага хувьтай байна. Тэгтэл манай улсын хувьд ингээд аваад үзэхэд энэ эмнэлэгт хэвтэгсдийн түвшин дэлхийн дунджаас 4 дахин их. ой Си Ти буюу Европын энэ хөгжилтэй орнуудаас 2 дахин их байгаа. Нөгөө орнууд эсрэгээрээ амбулаторийн тусламж үйлчилгээ буюу нийгмийн эрүүл мэнд нь манайх 34 хувьтай буюу бүүр ингээд уруугаа харчихсан байдалтай байгаад байгаа юм. Тийм учраас энэ хуулийг бид гаргаснаар ямар нэгэн хэмжээнд бас өөрчлөлт хийнэ гэж найдаж байгаа. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ маш чухал. Бид нар ингээд л түрүүн хэлээд байна. Санхүүжилт нэмээд л байгаа. Хүмүүсийн энэ эрүүл мэндийн салбарт эм тарианд хэвтэн эмчлүүлэхэд гарч байгаа хувь хүний төлбөрийн хэмжээ манайх бүүр ядууралд хүрэх үндэс болж байна гэж судалгаа гарчхаад байгаа шүү дээ. Иргэд үнэхээр бухимдаж байна. Энэ үнэн. Тэгээд хараад үзэхэд ЭМД-аас гарч байгаа санхүүжилтийн хамгийн сүүлийн мэдээг авахад эмийн эмчилгээнд гэхэд 2022 онд 312 тэрбум төгрөг зарцуулж байсан. 2023 оны байдлаар дахиад л ийм хэмжээний 300-гаад тэрбум. Хоёрт орж байгаа нь мэс засал. Мэс засал дээр 2022 онд 242 тэрбум байсан, одоо 2023 оны 12 сарын 1-ний байдлаар 196 тэрбум төгрөг. Гуравт нь, хэвтэн эмчлүүлэх бас л энд зарцуулж байгаа мөнгө нь 2022 онд 55 тэрбум байсан бол одоо бүүр 77 тэрбум төгрөг болоод нэмэгдчихсэн байна. Тэгэхээр нөгөө түрүүний хэлээд байгаа эрүүл мэндийн санхүүжилт тэр хүнд мэс

засал юм уу, хэвтэн эмчлүүлж байгаа юм уу эсвэл эмэнд өгөөд байна шүү дээ.

Харин хүнийг урьдчилан сэргийлэх амбулаторийн анхан шатын үзлэгт байх, эрүүл байх чиглэлийг нь дэмжихээсээ илүүтэй өвчтэй хүнийг тэр дундаа илүү их өвдвөл энэ тэнд мөнгө өгнө гэсэн нэг тийм буруу зарчим яваад байгаа юм. Тэгэхээр сая Чинзориг сайдын хэлээд байгаа энэ хууль эхлэл нь болоод энэ хуулиар ядахдаа эхний өөрчлөлтүүдийг хийгээд, тусламж үйлчилгээ рүүгээ бас санхүүжилтээ түлхүү зарцуулдаг байх энэ хандлага руу орох нь өөрөө зөв байгаа. Тэгэхээр энэ дээр 5 дугаар хэсэгт нь нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хамтын ажиллагаа, төрөл, үйл ажиллагаа гээд нэг бүхэл бүтэн бүлэг орсон. Энэ бүлэг дээр нөгөө салбар дундын, энэ нийгмийн эрүүл мэнд гэдэг чинь ганц эрүүл мэндийн салбарын ажил биш. Бүх салбар хоол хүнс, хүнс ХААЯ боловсрол. Энэ чинь хүүхдийг бүүр багаас нь зөв хооллох, зөв хэвшилтэй болгох, биеийн тамир гээд ингээд бүх салбарын уялдаа холбоо чухал байж байж энэ нөгөө эрүүл байх өвтгөхгүй байх гэдэг асуудал чухал. Тэгэхээр үүнийгээ бид нар бас хамтарч оруулж ирэх ёстой. Тэгэхгүй зүгээр зөвлөл байгуулаад ингээд явчихна гэхээр угаасаа Эрүүл мэндийн яамны ажил биш учраас энэ ингээд л орхигдчихно. Тиймээс бид нар энэ дээрээ бас бусад хуультай уялдаад маш сайн анхаарахгүй бол иргэдээ өвчлүүлэхгүй байх дээр л анхаарах нь чухал байна шүү дээ.

Хавдар гээд байна шүү дээ. Хавдар гээд байна энэ юу юм. Энэ хөрс агаарын бохирдлоос л үүдэлтэй шүү дээ. Хүнсний аюулгүй байдал алдагдсанаас л үүдэлтэй. Тэгээд зарцуулж байгаа хөрөнгө мөнгө асар их байгаад байдаг. Гэтэл хүн маань эрүүл болохоосоо илүүтэй эцсийн мөчид ороод л, хүнд байдалд ороод л.

Г.Занданшатар: Содномын Чинзориг сайд хариулъя.

С.Чинзориг: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Ер нь эрүүл мэндийн салбарт өгч байгаа санхүүжилтийн хэмжээ бас жилээс жилд нэмэгдээд байгаа гэдэгтэй би санал нэг байгаа юм. Бид нар 2022 онд Нийгмийн бодлогын байнгын хорооноос ажлын хэсэг ч гарч ажиллаад энэ гүйцэтгэл санхүүжилтийн байдал дээр үнэлэлт дүгнэлт хийгээд анхан шатын эрүүл мэндийн байгууллагууд олгох санхүүжилтийн нэг иргэнээр тооцож олгох санхүүжилтийн хэмжээг нэмэх хэрэгтэй байна гэж 2 дахин нэмэгдүүлсэн. Нөгөө талаасаа даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр олгох санхүүжилтийн хэмжээ 30 орчим тэрбум байсан бол одоо бараг л 90 тэрбум болоод бараг 3 дахин нэмэгдэж байгаа юм. Гэхдээ бас иргэдийн зүгээс чанар хүртээмж сайн биш байна гэдэг шүүмжлэл асар их гарч байгаа юм. Тийм учраас бид нар энэ дээр нэлээн дүгнэлт хийж, нэлээн өөрчлөлтүүд хийх ёстой юм байна билээ. Би бол энэ эрүүл мэндийн байгууллагуудын энэ шатлалтай холбоотой асуудал, тарифтай холбоотой асуудал дээр бас нэлээн бас өөрчлөлт хийх шаардлагатай юм байна гэж бодож байгаа юм. Өмнө нь аймгийн нэгдсэн эмнэлгүүдийг 2 дугаар шатлалын эмнэлэг гээд, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүдийг 3 дахь шатлалын эмнэлэг гээд бид нар явдаг байсан. Одоо бид нар 2020 оноос хойш аймгийн нэгдсэн эмнэлэг ч тэр, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүд ч тэр бүгдийг нь лавлагаа шатын эмнэлэг гээд нэг том малгай өмсгөчихсөн. Энэ малгай нь нэг хэсэгт нь томдоод, нэг хэсэгт нь жижигдээд байгаа юм байна билээ.

Нөгөө талаасаа энэ лавлагаа шатны эмнэлгүүд боловсон хүчний чадавх нь, нөөц нь, оношилгоо, эмчилгээ хийх тоног төхөөрөмжийнх нь нөөц чадавх нь өөр өөр учраас хэдийгээр нэг шатлалын эмнэлэг болчихсон ч гэсэн тусламж үйлчилгээ үзүүлэх чадамж нь өөр учраас санхүүжилт авч байгаа байдал нь өөр.

Орон нутгийн нэгдсэн эмнэлгүүд нь өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээ хийх боломж байхгүй. Өндөр өртөгтэй мэс заслын ажил хийж тусламж үйлчилгээ үзүүлж чадахгүй учраас санхүүжилт авч чаддаггүй. Тэр байдлаараа бас үйл ажиллагаа нь доголдох ийм асуудлууд байх юм. Нөгөө талаасаа бүх нэгдсэн эмнэлгүүдийг лавлагаа шатны эмнэлэг гээд нэг шатлалд оруулчихлаар асар их тусламж үйлчилгээний давхцал бий болчихсон юм байна. Аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн хийж чаддаг ердийн өвчнийг ч гэсэн төрөлжсөн эмнэлгүүд нь үзүүлдэг болчихсон. Тэгээд би энэ оны 8 сараас тарифт өөрчлөлт хийгээд орон нутгийн нэгдсэн эмнэлгүүдийн хийж чаддаг эмчилгээг үйлчилгээг хийвэл олгох тарифыг нь нэлээн нэмж өгөөд орон нутгийн эмнэлгүүдийн нэгдсэн эмнэлгүүдийн хийж чаддаг үйлчилгээг нэгдсэн төрөлжсөн эмнэлгүүд хийвэл тарифыг нь жаахан багасгаад нэлээн ийм давхцалыг бас арилгах тарифын нэлээн зохицуулалтууд хийсэн. Цаашидаа шатлал шатлалаар нь өөр тариф мөрдүүлэхээс өөр аргагүй юм байна гэж би бодоод байгаа юм.

Одоо ирэх оны 4 дүгээр сарын 1-нээс орон нутгийн эмнэлгүүдэд бүсийн нэмэгдэл өгнө, цалин нэмэгдэнэ. Ингээд нэг шатлалд оруулчихаар нэг тарифаар цалин, бүсийн нэмэгдэл өгөхлөөр тарифтаа шингээд тэр цалин, бүсийн нэмэгдэл чинь аймгийн нэгдсэн.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн нэг минут.

М.Оюунчимэг: Өнгөрсөн жилүүдэд Улсын Их Хурлын даргын зүгээс ч бид нарт чиглэл өгч байсан. Энэ ЭМД-ын санхүүжилтийн хувь хэмжээ төрлийг аваад үзэхэд эмэнд зарцуулж байгаа мөнгө нь дандаа 300 тэрбумаас дээш байгаад байдаг. Гэтэл эм нь үйлчилдэггүй, эмийн чанар нь муу. Тэгээд бид нар түр хороо хүртэл байгуулаад л явж байна. Үр дүнд хүрэх эсэх нь тодорхойгүй л байна л

даа. Тэгэхээр Чинзориг сайд ч гэсэн энэ дээр илүү их анхаарч байгаа байх. Өөрөө манай ажлын хэсэгт өмнө нь ороод явж байсан. Тэгээд олгосон санхүүжилтийг аваад үзэхэд 14.5 хувь нь хувийн эмнэлэг, 74 хувь нь улсын эмнэлэг, 2.5 хувь нь л рашаан сувилал, 8.8 хувь нь эмийн сангууд гэж байгаа юм. Тэгэхээр яг бид нар нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай энэ эрх зүйн орчныг нь бүрдүүлэхээр энэ бүтцэд өөрчлөлт орох болов уу Чинзориг сайд аа. Одоо яг ЭМД-ын сангаас тусламж үйлчилгээнд бид энэ хувийг нь оруулна аа. Энэ өөрөө рашаан сувилалтайгаа хамт нэгдээд явчих уу? ирэх онд л гэхэд 2024 онд 365 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тусгасан хөрөнгө оруулалт гэж байна. Үүний хэдэн хувь нь жишээлбэл нийгмийн эрүүл мэнд тусламж үйлчилгээ рүү орох вэ? Тэр эмийн үнэ чанар эмийг дагасан энэ мафи.

Г.Занданшатар: Чинзориг сайд мафитайгаа яаж тэмцэх гэж байна.

С.Чинзориг: Би мафи гэж хэлэх нь хаашаа юм бэ дээ. Ер нь манай салбарт түлгамдаж байгаа асуудлын нэг бол энэ эмийн чанар, аюулгүй байдал, үнийн асуудал байгаа юм. Бид нар удахгүй чадвал бас энэ эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах саналаа боловсруулаад Засгийн газраар хэлэлцүүлээд Их Хуралд өргөн барих чиглэлд ажиллаж байгаа. Харин гишүүд санаж байгаа байх хаврын чуулганаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулаад олон улсын стандарт шаардлагад нийцсэн эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын үйлдвэрээс нь болоод олон улсын худалдан авалтын систем ашиглаж шууд бас худалдан авалт хийдэг байна гэсэн ийм хуульд өөрчлөлт оруулсан. Одоо энэ хуулийн өөрчлөлт 1 сарын 1-нээс хэрэгжинэ. Энэ хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор би гадаад улсын үйлдвэрээс нь болоод олон улсын худалдан авалтын системийг ашиглаад ялангуяа

манайхан бэлээхэн систем байна. Энэ НҮБ-ын хүүхдийн.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаагийн урилгаар аутизмтай хүүхдийн асран хамгаалагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхний энэ ажил үйлсэд өндөр амжилт хүсье.

Содномын Чинзориг сайд гүйцээж хариулъя.

С.Чинзориг: Тэгэхээр энэ шууд худалдан авалтын хууль нэг сараас хэрэгжинэ. Тийм учраас энэ шууд худалдан авалтын журам Засгийн газарт орно. Би эхний ээлжид төрийн эрүүл мэндийн байгууллагуудын хэрэглэдэг эм, даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр олгож байгаа эмийг энэ олон улсын худалдан авалтын системийг ашиглаж шууд худалдан авалт хийе гэсэн ийм бодолтой байгаа. Ингэвэл эмийн үнэ чанар дээр нэлээн ахиц гарах байх. Энэ маань нийт импортын эмийн хэрэглээний 30 хувь байгаа юм.

Хоёр дахь асуудал нь, бас шинэ мэдээ дуулгахад, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Монгол Улсын Эрүүл мэндийн яамтай хамтран ажиллах захидалд ирэх 7 хоногт гарын үсэг зурна. Энэ захидалд гарын үсэг зурснаар хүүхдийн хавдрын зонхилон тохиолдох 6 төрлийн хавдрын эмзэг шаардлагатай 35 нэр төрлийн эмийг 3 жилийн хугацаатай үнэ төлбөргүй олгохоор болж байгаа. Энэ бас нэлээн тийм том ахиц бас болох болов уу гэж бодож байна.

Г.Занданшатар: Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуулт асууна.

Д.Өнөрболор: Чинзориг сайдын оруулж ирж байгаа хуулийн төслийг дэмжиж байгаа. Цаг үеэ олсон маш чухал

хуулийг оруулж ирж байна. Тэгээд сүүлийн үед энэ ялангуяа цар тахлаас хойш энэ улс орнууд нийгмийн эрүүл мэндийн нийтлэг стандартыг тогтоосон энэ хуулийг бас батлахыг чухалчилж байгаа.

Тэгээд өнөөдөр энэ манайд ер нь агаарын ийм бохирдол тэгээд л хүнсний баталгаат байдал, замын хөдөлгөөний аюулгүй байдал, эрчим хүчнээс эхлээд аюултай нөхцөл байдалд байгааг бүгдээрээ л бид нар мэдэж байгаа. Тэгээд энэ урьдчилан сэргийлэх мөн хамгийн гол нь урьдчилан сэргийлэх, хамгаалах, хянах, зохицуулах, эрүүл мэндийн боловсрол олгох энэ асуудал хуулиар зохицуулагдах ёстой. Гэхдээ энэ ерөөсөө дан ганц Эрүүл мэндийн яамны ажил бас биш юм аа. Энэ эрүүл мэндийн салбарын болон боловсрол хүрээлэн байгаа орчин, дэд бүтэц, нийгэм, соёл, хэвлэл мэдээллийн гээд бүхий л салбарт хамааралтай ийм хууль орж ирж байгаа. Тэгэхлээр энэ хуулийн төслөөр энэ салбаруудын уялдаа холбоог ер нь яаж зохицуулалт хийсэн бэ? Энэ талаар бас хариулт авъя.

Нөгөөтээгүүр ДЭМБ-ын энэ судалгаагаар хувь хүний зан үйл эрүүл мэндийн 55 хувийг тодорхойлдог гэж заасан байж байгаа. Сая маш их олон гишүүд бас энэ дээр анхаарал хандуулж бас асуулт тавьж байна. Үүнтэй ч гэсэн миний хувьд бас санал нэг байгаа. Ер нь Эрүүл мэндийн яамтай хамтраад Сэлэнгэ аймагт бид нар эрүүл мэндийн үзлэг оношилгоог бас гаднын эмч, ажилтнууд мөн үндэсний мэргэжлийн багийг ажиллуулж, нийт 10 мянган Сэлэнгэчүүдийг үзлэгт хамруулсан байгаа. Үүний үр дүнд маш аюултай ийм дүн гарсан. Өөрөөр хэлбэл энэ зан үйл, амьдралын хэв маягтай холбоотой энэ асуудал газар дээрээ нотлогдсон гэмээр ийм үр дүн гарсан. 10 хүүхэд тутмын 9 нь шүдний цооролттой, шүдний ямар нэгэн асуудалтай байсан. Тэгэхлээр иргэдийн ер нь энэ зан үйл, амьдралын хэв маягтай холбоотой нөлөөллийн үйл ажиллагааг маш сайн хийх ёстой юм байна, ойлгуулах

хэрэгтэй юм байна. Энэ мэдлэгийг хуваалцаж тэр хүмүүст нэн ялангуяа олон улсад хувь хүний болон бүлэг хүний хамт олонд зориулсан эрүүл мэндийн зөвлөгөө, эрүүл мэндийн боловсролд дэмжлэг үзүүлэх загварчлал гээд олон гарын авлага материалууд бий болсон байдаг. Үүнийг иргэдэд түгээж нөлөөллийн энэ арга хэмжээнүүдийг сайтар зохион байгуулах шаардлагатай юм байна гэж ойлгож байгаа.

Олон улсад нэг эмчид ноогдох сувилагчийн тоо 3 байдаг юм байна билээ. Манайд 1:1-ийн харьцаатай байгаа. Тэгэхлээр энэ эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулахын тулд ялангуяа энэ сувилагчийг дадал дадлагажуулах ажил маш чухал байгаа. Энэ хүрээнд бас бид нар Эрүүл мэндийн яамтай хамтраад миний бие санаачлаад бас БНСУ-д Сэлэнгийн 25 сувилагчийг, Өвөрхангайн 5 сувилагчийг хамруулаад ингээд түүхэндээ бараг шинэ хуудсыг нээсэн ийм мэргэшүүлэх дадлагажуулах энэ үйл ажиллагааг ингээд хийж байгаадаа бас баяртай байгаа. Тэгэхлээр нэн ялангуяа иргэдийн зан үйл амьдралын хэв маягтай холбоотой энэ асуудлыг ер нь манай Монгол Улс бүхэлд нь ингээд судалгаа хийсэн байдаг юм уу? Үүний тоо баримт байдаг юм уу? Ямар нөлөөллийн үйл ажиллагаа явуулах зохион байгуулалтыг энэ хуулийн хэрэгжилтээр хийж зохицуулахаар төлөвлөж байгаа вэ?

Г.Занданшатар: 81 Өнөрөө дарга хариулна аа.

Ч.Өнөрсайхан: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Би НЭМҮТ-ийн захирал Өнөрсайхан гэж хүн байна. Өнөөдөр ингээд яригдаж байгаа бүх зүйлд бүгд энэ нийгмийн эрүүл мэндийн талаар бүх хүн санаа зовж байгаа нь аргагүй. Бид Монгол улсад халдварт бус өвчин осол, гэмтлийн шалтгаан гээд судалгааг Номхон далайн баруун бүстэй цорын ганцаараа 4 удаа хийсэн орон байдаг. 20 жил дараалаад судалсан. Тэгэхэд хүн

амын маань дөрөвхөн хувь нь ямар нэгэн эрсдэлгүй хүн ам, 17-65 насны хүн амын маань 96 хувь нь ямарваа нэг эрсдэлтэй. Архи уудаг, тамхи татдаг, хөдөлгөөн хийдэггүй, артерийн даралт ихсэлттэй гээд энэ болгон маань явсаар байгаад дэлхийн 168 орноос улаан хоолойн хавдар, элэгний хавдраараа нэгд эч ни өү умайн хүзүүний хавдраар 4-д орж байгаа ийм эмгэнэлтэй тоонд хүрчхээд байгаа юм. Тэгээд энэ бүхний гол эх үүсвэр тэр эрүүл мэндийн боловсролын асуудал байгаа. Тэгээд бид нар хэрвээ хувь хүнд ингээд ямар нэгэн зөвлөгөө өгөөд явах юм бол энэ зөвлөгөө болоод явдаг. Эрүүл мэндийн боловсролын асуудал бүлэг хүмүүст тусгайлан хийдэг хөтөлбөртэй хийдэг. Түрүүн яригдаад байгаа боловсролын салбарт байгаа тэр хөтөлбөрийн асуудлууд энэ маань өөрөө эрүүл мэндийн боловсрол олгох ажил. Манай байгууллагаас гол яадаг нь эрүүл мэндийг дэмжих ажлыг голчлон хийдэг. Тэр маань өөрөө эрүүл мэндийн боловсрол олгох, дээрээс нь нэмээд орчныг нь бүрдүүлж өгнө. Ямарваа нэгэн зүйл дээр орчин бүрдэж өгөхгүй юм бол бид дан ингээд аваад хэдэн бүлэг хүмүүсийг сургаад тэр нь байнгын биш давтамжгүй, тэгээд 55 хувь нь зан үйл нь нэгэнт тогтчихсон, 17-45 насны хүмүүстэй голчлон үйл ажиллагаагаа явуулж ирснээрээ манай салбарын алдаа байсан байна гэж бид хэд олж харж байгаа.

Ингээд бид нар бүсээрээ сая бид нар Монгол Улсын хоол тэжээлийн судалгааг 6 дугаар судалгааг бас дуусгаж байна. Мөн сургуульд суурилсан хүүхдийн зан үйлийн судалгааг 10 модулиар анх удаагаа бас хийж байна. Урьд нь 6 модулиар хийж байсан. Энэ болгоноор бид нар 2023 онд Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон насанд хүрсэн хүмүүсийн хооллолт, зан байдал, халдварт бус өвчний эрсдэлүүд нь ямар байна вэ гэдэг нь бүх сумдаараа гарч ирж байна. Аймаг, аймгаараа. Ингээд хүмүүс өөрийгөө харьцуулж үзнэ. Хатгалд байгаа хүнд бид нар агаарын

бохирдол яриад байхаар ямар нэгэн хүрч очиж наалдахгүй байна. Тэнд харин зам тээвэр, аялал жуулчлалтай холбоотойгоор хүчирхийллийн асуудал маш өндөр байна. Осол гэмтлийн асуудал өндөр байна. Тэгэхээр тухайн оршин байгаа өөрөө хувь хүний хамаарч байгаа тэр эрсдэлт хүчин зүйлүүдийг юу юун дээр анхаарах вэ гэдэг ийм зөвлөмжүүдийг хүргэхээр ажиллаж байгаа.

Тэгээд түрүүн гишүүд нэлээн асууж байна. Энэ хуульд ингээд хувь хүн ингээд яаж ямар нэгэн байдлаар тэр хүнийг зохицуулсан уу гэсэн зүйл дээр бид нар энд орсон байгаа. Иргэн хүн ямар эрх үүрэгтэй байх юм, олон нийтийн байгууллага ямар эрх үүрэгтэй байх юм. Засгийн газрын байгууллагууд нь ямар эрх үүрэгтэй байх юм гээд. Тэгээд шагнах урамшуулах тогтолцоог нь эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас журам гаргаж мөрдөнө гээд. Ийм байгаа. Энэ хууль дээрээ компактний болгохын тулд тэр жижиг байсан заалтууд авагдаад бөөнөөрөө орж ирсэн байгаа.

Г.Занданшатар: Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн асууна. Өнөрболор гишүүний асуултад 85 хариулах юм уу. Баярболд 85.

Д.Баярболд: Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Энэ салбар хоорондын уялдаа холбоог хангахын тулд хуульд ямар асуудал тусгав гээд. Энэ дээр нийгмийн эрүүл мэндийн асуудлыг хэлэлцэж салбар дундын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах чиг үүрэг бүхий Нийгмийн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл Ерөнхий сайдын дэргэд ажиллахаар тусгасан байгаа. Мөн төрийн захиргааны төв байгууллага буюу энэ яамдууд бас энэ хүн амын эрүүл мэндийг дэмжих аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бодлого үйл ажиллагаандаа тусгана. Мөн салбарынхаа хэмжээнд энэ ажлын байранд ажилтны эрүүл мэндийг

дэмжих орчин бүрдүүлэх асуудлуудыг энэ хөдөлмөрийн дотоод журамдаа хэрэгжүүлэх мөн энэ зөвлөлийн гаргасан дүгнэлт зөвлөмжийг бодлого шийдвэртээ тусгах чиглэлийг оруулж өгсөн. Энэ талаар хэрхэн ажиллаж байгаа талаараа жил бүр энэ үндэсний зөвлөлд тайлангаа тавихаар тусгасан нь энэ уялдаа холбоог хангаж гарч ирнэ. Ялангуяа энэ хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад энэ томоохон шийдвэр гарах гол зөвлөл байна гэж бид тодорхойлж оруулж ирсэн байгаа.

Г.Занданшатар: Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ Монгол Улсын хүн амын эрүүл мэндийн маш чухал хууль орж ирж байгаа учраас үүнийг бүрэн дэмжиж байна. Тодруулах хэд, хэдэн асуулт байна. Монгол Улсын хөдөлмөрийн насны хүн амын бараг 77 хувийн нас баралтын шалтгааны 77 хувь нь халдварт бус өвчин буюу ерөнхийдөө нөгөө урьдчилан сэргийлж болох өвчнүүд байгаа. Тийм учраас энэ асуудлыг шийдэх, хүн амын дундаж наслалтыг уртасгах, нас баралтын шалтгааныг багасгахад энэ нийгмийн эрүүл мэндийг дэмжих нь асар чухал. Тэгээд тэр дотроо энэ нийтийн бие бие бялдрын хөгжил тэгээд агаарын бохирдол, тэр дотор дотоод орчны агаарын бохирдол гээд сэргийлж болох нийгмийн эрүүл мэндийн гол асуудлыг энэ хуулиар шийдэх ёстой гэж үзэж байгаа. ДЭМБ-ын стандартаар энэ урьдчилсан сэргийлэлт дотор энэ хүн амын бие бялдрын эрүүл мэнд, зөв хооллолт, дотоод орчны агаарын бохирдол зэрэг зүйлүүд орж байгаа. Тийм учраас манай энэ Эрүүл мэндийн тухай хууль дээр ч гэсэн энэ эрүүл мэнд гэдэгт хүн өвчин эмгэггүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг хэлнэ ээ гэж байгаа.

Гэтэл манай энэ Нийгмийн эрүүл мэндийн тусламж үзлэгийн тухай хуулийн төсөлд бие бялдрын эрүүл мэнд гэдэг

талаар ерөөсөө заалт байхгүй байгаа. Энэ заалт яагаад ороогүй вэ. Хэрвээ хүн амаа эрүүл чийрэг байлгах нийгмийн эрүүл мэндийг дэмжих гэж байгаа бол бие бялдрын эрүүл мэндэд анхаарсан энэ тал дээр төрийн тусламж үйлчилгээг чиглүүлэх ёстой. Тэгэхээр нэгдүгээр асуулт энэ бие бялдрын эрүүл мэндийн талаар яагаад оруулаагүй хаягчав гэдгийг асуумаар байна. Бүр тодруулбал хуулийн төслийн 5.1 дээр байгаа нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ дараах төрөлтэй байна гээд. Тэгээд энэ дотор нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гэр бүл төлөвлөлт, орчин, эрүүл мэнд гээд явсан боловч яг хүн амын бие бялдрын хөгжлийн эрүүл мэнд гэдэг нь байхгүй байгаа.

Тэгээд түрүүн тэр дурдсан нөгөө сэргийлж болох боломжтой тэр өвчний эсрэг энэ бие бялдрын эрүүл мэндийг дэмжих нь чухал. Үүнийг оруулж хэрвээ шаардлагатай бол энэ зарчмын зөрүүтэй саналаар нэмэх шаардлагатай шүү. Түрүүн манай их олон гишүүд асуусан, энэ бие бялдрын эрүүл мэндийг дэмжих тал дээр гэж.

Хоёрдугаар асуулт нь, энэ хуулийн төслийн 5.2.2 дээр нөгөө хүн амын суурьшлын орчин, агаарын чанар, хөрсний бохирдол, ус хангамж зэргээс урьдчилан сэргийлнэ гээд. Энэ дотор тэр нөгөө дотоод орчны агаарын бохирдол маань бас хаягдчихсан байна. Ер нь хүн амын амьдран суух хамгийн их цагаа өнгөрүүлдэг энэ газар дотоод орчин гээд. Тэгээд энэ олон улсын судалгаагаар ерөнхийдөө хүн ам бараг 80-90 хувь нь дотоод орчны агаарын бохирдол эрүүл байж, тэр тухайн хүн эрүүл мэндийн хувьд өвчин эмгэг сэргийлэгдэнэ гэж байгаа. Тэгэхээр нийгмийн эрүүл мэндийн энэ хуульд яах аргагүй дотоод орчны агаарын бохирдол орох ёстой шүү. Энэ дээр ажлын хэсэг ямар байр суурьтай байна.

Гуравдугаарт, энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтэд энэ улсын төсөв, ЭМД-ын болон эрүүл мэндийг дэмжих сангийн төсөв тэгээд иргэн, ААН-ийн хандив гэгчихсэн байгаа. Тэгэхээр энэ ЭМД-аас санхүүжиж байгаагийн хувьд түрүүн бас Бямбацогт гишүүн асуусан, Энхтүвшин гишүүн ч асуусан юм аа. Хуучин манай 2017 оны ЭМД-ын тухай хуульд байсан нөгөө хүн амын тодорхой магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хамрагдсан, хөдөлгөөнөөр хичээллэсэн хүмүүст даатгалаас урамшуулал олгох тухай заалтаа энэ хуулиараа сэргээвэл яасан юм бэ. Бид нар ковидын үеийн эрүүл мэндийн хямралын улмаас энэ заалтыг хассан шүү дээ. Одоо энэ чинь орж ирэх ёстой. Энэ дээр мөн ажлын хэсэг ямар байр суурьтай байна. Бас мөн сайдаас тодруулж асууя. Ер нь тэгээд урьдчилан сэргийлэх энэ үйл ажиллагаа энэ дотор илүү анхаарч ялангуяа тэр бие бяldrын эрүүл мэнд, дотоод орчны агаарын бохирдол гэдэг дээр шаардлагатай зохицуулалт орох ёстой шүү гэдгийг онцгойлон хэлмээр байна. Ингээд хариултаа авъя.

Г.Занданшатар: Хариулт 85 Баярболд.

Д.Баярболд: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Биеийн тамир энэ бие бяldrын эрүүл мэндийн асуудал дээр бас хэрхэн тодорхойлогдсон бэ гэхээр 5.1.1-д халдварт болон халдварт бус өвчний хяналт сэргээлт хэсэг гэдэг дээрээ энэ асуудал орж явж байна. Энэ асуудал бол Биеийн тамир спортын тухай хууль дээр маш тодорхой заагдаад орсон учраас энэ хууль дээр давхцаж оруулах шаардлагагүй гэдэг үүднээс энэ асуудал орхичихсон. Агаарын бохирдлын асуудал дээр энэ 5.3 дээр хүн амын суурьшлын орчин агаарын чанар гэсэн байгаа. Энэ гадаад, дотоод гэдгээр ялгаагүй. Энэ бол хоёулаа дотоод болон гадаад орчны агаарын чанарын асуудлыг энэ дээр хамааруулж үзэх юм гэдгийг хэлье. Санхүүжилтийн хувьд

ЭМД-ын сангаас нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ дээр зөвхөн эрт илрүүлэхтэй холбоотой асуудал ЭМД-ын санхүүжилтээр санхүүжигдэнэ. Бусад нь энэ улсын төсөв тэгээд гаднын болон ОУБ-ын санхүүжилт хандив тусламжаар санхүүжигдэхээр тусгагдаж орж ирсэн байгаа.

Дээр нь агаарын чанартай холбогдуулаад нийгмийн эрүүл мэндийн лабораториуд, нийгмийн ЭМТ нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төв байгууллагуудад ажиллана. Энэ лабораториор дамжуулан энэ чанарыг бас хянаад явах бүрэн боломж энэ хуулиар олгогдож байгаа.

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн нэг минут.

Ц.Туваан: Энэ асуудлыг дэмжиж байгаа. Тэгээд хурдан батлах нь зүйтэй. Манай улсын ард иргэддээ үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ маань буруу тогтолцоо буюу уруугаа харсан пирамид байдалтай ийм байгаа. Тэгэхээр үүнийг яаралтай засахад энэ хууль маш чухал гэдгийг хэлье. Энэ дээр 2 асуудал байгаа юм. Нэг нь, хөдөө орон нутагт сумд сурч байгаа хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн асуудал, шүд цооролтын асуудал. Энэ дээр ер нь яг заалтаар гэдэг юм уу, тухайлчилж энэ дээр оруулсан зүйл юу байна.

Хоёрдугаарт, энэ Үндэсний зөвлөл Ерөнхий сайдын дэргэд гээд энэ ажиллахгүй. Үүнийгээ дахиж нэг харж үзэх боломж байна уу. Салбарын сайд нь дэргэдээ авдаг юм уу, яадаг юм. Энэ Хүнсний аюулгүй байдлын зөвлөл гээд л нэг байгууллага байгаа тэгээд л ажилладаггүй. Тэгэхээр энэ дээр.

Г.Занданшатар: Даваажанцангийн Сарангэрэл гишүүн хариулъя.

Д.Сарангэрэл: Туваан гишүүний асуултад хариулъя. Гишүүний маань хэлж байгаа үнэн л дээ. Ерөнхий сайдын дэргэд олон зөвлөлүүд ажилладаг. Энэ зөвлөлийн хувьд зайлиггүй байх ийм шаардлага байгаад байгаа юм. Яагаад гэвэл энэ нийгмийн эрүүл мэндийн асуудал гэдэг бол Монгол Улсын 3.4 сая хүн ам бүгдэд нь хамааралтай. Ер нь үндэсний аюулгүй байдлын хэмжээний асуудал гэж үзэж болно. Тийм учраас бид Ерөнхий сайдын дэргэд нийгмийн эрүүл мэндийн ноцтой асуудал үүссэн үед хуралддаг, шийдвэр гаргадаг ийм үндэсний зөвлөлийг бий болгоё гэж байгаа юм. Тэгээд хамгийн гол нь Туваан гишүүн ээ, энэ нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлууд, хүний эрүүл мэндэд бусад салбарын үзүүлж байгаа сөрөг хүчин зүйлүүд их байна л даа. Тухайлбал, барилгын салбарын энэ тоос шороо, хатуу хог хаягдал, агаарын бохирдол, утаа гэдэг юм уу? Тийм ээ, бусад салбарын эрчим хүчний гээд олон салбарын ийм хор хөнөөлүүд байна. Тухайлбал энэ томуу дээр хүндрэл болгож байгаа.

Г.Занданшатар: Сарангэрэл гишүүн гүйцээгээд хариулчихъя.

Д.Сарангэрэл: Томууг уяжгируулж байгаа хүчин зүйл бид нар агаарын бохирдол утаа гэдгийг мэдэж байгаа. Тэгэхээр энэ бусад салбараас хамаарч байгаа энэ хүчин зүйлийн чиглэлээр шийдвэр гаргахад ижил түвшний сайд нарын түвшинд асуудал шийдэгдэхгүй л дээ. Тийм учраас үүнийг Ерөнхий сайдын дэргэд Үндэсний зөвлөл байгуулж, энэ бусад салбараас хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийг бууруулах, илаарьшуулах, засаж залруулах тул ийм Үндэсний зөвлөл зайлиггүй шаардлагатай гэж үзэж тусгасан юм байгаа.

Г.Занданшатар: Туваан гишүүн тодруулж асууя. Нэг минут.

Ц.Туваан: Энэ концепц маань өвдсөн хойно нь эмчлэх биш яаж өвтгөхгүй байх вэ гэдэг л концепц. Тэгэхээр энэ дээр би сая тодорхой асуултыг асуусан Сайдаас. Адилхан хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүд бүгдэд нь байгаа. Сумдад шүд эмчлэх шүдний кабинеттай байх, шүдний эмчтэй байх, тэгээд тэр шүдний багаж тоног төхөөрөмжийн ариутгал гээд юмнууд боломж маш муу байгаад байгаа. Тэгэхээр энэ хууль орж ирж байгаа дээр үүнийг нэгэнтээ тэгж кабинетын байдлаар шийдэж чадахгүй учраас энэ нийгмийн эрүүл мэндийн буюу урьдчилан сэргийлэх хүрээнд хэрхэн шийдвэрлэх бодлого энэ дотор байгаа вэ гэдэг л асуулт.

Г.Занданшатар: Чинзориг сайд хариулъя.

С.Чинзориг: Туваан гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ иргэний эрүүл мэндийн боловсролын хүрээнд яг энэ хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах шүд цооролтоос урьдчилан сэргийлэх гээд энэ асуудлууд бүрэн тусаад явж байгаа. Засгийн газар дээр асуудал оруулаад, ирэх оноос бид Шүд төсөл бас хэрэгжүүлэхээр болж байгаа. Энэ хүрээндээ тогтоол гарсан. Боловсролын яамтай хамтарч нэгдүгээрт, амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах талаар цэцэрлэгийн наснаас нь хүүхдүүдэд бас ойлголт мэдлэг өгөх асуудлууд, сургуулийн наснаас нь хүүхдүүдэд ойлголт өгөх ялангуяа энэ шүд цооролтоос урьдчилан сэргийлэх хүрээнд шүд угаадаг угаалтыг бас нэмэгдүүлэх. Дотуур байр, сургуулийн орчинд, үдийн ундны дараа шүд угаадаг байх энэ нөхцөл боломжийг нь бүрдүүлэх эд нар гээд тодорхой асуудлыг тусгасан ийм хөтөлбөр батлагдсан.

Өмнө нь ийм 3, 4 хөтөлбөр баталсан юм билээ. Гэхдээ үр дүн их муутай байсан юм байна билээ.

Г.Занданшатар: Сарангэрэл гишүүн гүйцээж хариулахгүй юу.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт явуулъя. Зарчмын зөрөөтэй 61 санал байгаа.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төслийн талаар Нийгмийн бодлогын байнгын хороон дээр гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал байгаа.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн хүчин зүйл халдварт болон халдварт бус өвчнийг тандах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хамгаалах гэснийг, хүчин зүйлийг тандах, судлах, үнэлэх, хариу арга хэмжээг авах өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх гэж өөрчлөх. Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл, Пүрэв-Очирын Анужин, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Бадарчийн Жаргалмаа, Мөнхөөгийн Оюунчимэг /цаашидаа “ажлын хэсэг” гэнэ/.

Санал хураалт. 63.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хууль,” гэсний дараа “Үндэсний аюулгүй байдлын тухай,” гэж, “Эрүүл ахуйн тухай хууль,” гэсний дараа “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай,” гэж нэмж, мөн хэсгийн “Боловсролын тухай” гэснийг “Боловсролын ерөнхий” гэж өөрчилж, 2.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “нотолгоонд” гэсний өмнө “судалгааны үр дүн,” гэж нэмж, 3.1.11 дэх заалтын “өвчний шинж тэмдэг илрээгүй хүн амыг” гэснийг “хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан, өвчин эмгэгээс” гэж өөрчилж, 3.1.3, 3.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.3. “нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал” гэж хүний болон зоонозын—халдварт өвчний дэгдэлт, шалтгаан тодорхойгүй өвчлөл, өвчлөлийн шинэ тохиолдол, хими, цацрагийн осол, хордлогод хүн ам өртсөн, эсхүл өртөх нөхцөл үүссэнийг;

3.1.4. “эрүүл мэндийг дэмжих” гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.19-д заасныг;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. Энэ Онц байдлын тухай хуульд байдаг заалттай уялдуулах ёстой л юм.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “чанар, тоон үзүүлэлт судалгааны аргаар” гэснийг, 3.1.13 дахь заалтын “арга барилд сургах” гэснийг, 3.1.8, 3.1.19, 3.1.21 дэх заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.17 дахь заалтын “эрүүл мэндийн их, дээд сургуулийг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр төгссөн мэргэжилтнийг” гэснийг “их, дээд сургууль, коллежийг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр төгссөн, тухайн мэргэжлээрээ энэ

хуулийн 11.1.1-11.1.4-т заасан байгууллагад ажиллаж байгаа ажилтныг” гэж, 3.1.18 дахь заалтын “ажилтан” гэснийг “мэргэжилтэн” гэж, “энэ хуулийн 7.1.1-7.1.3-д заасан байгууллагад” гэснийг “их, дээд сургууль, коллежийг энэ хуулийн 3.1.15-д зааснаас бусад чиглэлээр төгсөж, энэ хуулийн 11.1.1-11.1.4-т заасан байгууллагад энэ хуулийн 5.2-5.9-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэн” гэж, мөн заалтын дугаарыг “3.1.16” гэж, 3.1.16 дахь заалтын “чиглэлээр ажилладаг бусад ажилтныг” гэснийг “бусад мэргэжилтнийг” гэж, мөн заалтын дугаарыг “3.1.17” гэж, 3.1.17 дахь заалтын дугаарыг “3.1.15” гэж, тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

3.1.15-ыг өөрчилж байгаа чинь буруу юм биш үү. Эрүүл мэндийн коуч гэж байдаг юм уу? Энэ эрүүл мэндийн их, дээд сургуулийг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжилтний зохицуулах заалтыг яагаад доошлуулаад.

62.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 4 дүгээр зүйлийн гарчгийн “Үйл ажиллагаанд баримтлах” гэснийг “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “нотолгоонд” гэснийг “судалгааны үр дүн, нотолгоонд” гэж тус тус өөрчилж, 4.1.1 дэх заалтын “, тэгш хүртээмжтэй, чанартай” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:

“4.1.8.чанар, үр ашигтай байх;

4.1.9.тэгш хүртээмжтэй байх;

4.1.10.жендэрийн тэгш байдлыг хангах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Яг тэгш байдлыг хангах юм уу. Яг жендерийн хууль бол жендерийн тэгш байдлыг харгалзах ч гэдэг юм уу. Тэгэхгүй бол хангах гэхээр 50:50 хувь гэж яг тэгш байдал хангагдана гэж. Үүнийг чиглэл өгье. Тэгэхгүй бол энэ хууль зүйн хувьд хангагдах боломжгүй заалт.

Анагаахын салбар чинь эмэгтэйчүүд голдуу ажилладаг учраас эрэгтэй хүн ажиллуулах биш.

7.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтын “гэр бүл төлөвлөлт,” гэснийг хасаж, 5.2.6 дахь заалтыг 5.7 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.7.Энэ хуулийн 5.1.6-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд хувь хүн, хосууд эрүүл мэнд, эдийн засаг, амьдралын байдалд тохируулан гэр бүл төлөвлөх, тэдний нөхөн үржихүйн эрхийг хамгаалах, мэдлэг олгох үйл ажиллагаа явуулна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “сэтгэл зүйн эрүүл мэнд” гэснийг “сэтгэц-зан үйл” гэж өөрчилж, 5.2.5 дахь заалтыг 5.6 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.6.Энэ хуулийн 5.1.5-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

5.6.1.нийгэм болон хүрээлэн байгаа орчноос үүдэлтэй сэтгэц-зан үйлийн эмгэгт нөлөөлж байгаа хүчин

зүйлийг тогтоох, тандалт, судалгаа хийх, урьдчилан сэргийлэх, хянах, бууруулах;

5.6.2.хүнийг амьдралын зөв хэв маягт сургах.”

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт.

65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын “хөрсний бохирдол, ус хангамж, ариун цэвэр, хог хаягдлаас” гэснийг “уур амьсгалын өөрчлөлт, ус хангамж, хог хаягдал, хөрсний бохирдлоос” гэж, мөн заалтын дугаарыг “5.3” гэж тус тус өөрчилж, 5.2.4 дэх заалтыг 5.5 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.5.Энэ хуулийн 5.1.4-т заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

5.5.1.хүнсний аюулгүй байдал, шим тэжээлийн зохистой байдал алдагдсанаас шалтгаалсан өвчлөл, хордлогоос урьдчилан сэргийлэх;

5.5.2.хүнсний аюулгүй байдал, шим тэжээлийн зохистой байдал алдагдсанаас шалтгаалсан өвчлөл, хордлогод нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тогтоох, тандалт, судалгаа хийх.”
Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 5.2.1 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.2.Энэ хуулийн 5.1.1-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж,

үйлчилгээ үзүүлэх хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

5.2.1.халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тандан судлах, тодорхойлох, урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг иргэн, гэр бүл, байгууллага, хамт олонд тулгуурлан зохион байгуулах;

5.2.2.нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх.”

Энэ дээр Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн үг хэлнэ.

Ж.Чинбүрэн: Эрхэм гишүүд ээ, энэ гүйцээн боловсруулалт чиглэл авах гэсэн юм аа дарга аа. Энэ дээр, ди парламентаар бас энэ уламжлалт анагаах ухааны чиглэлийн хүмүүс бас энэ дээр орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны судалгааны толгойд тулгуурласан шийдвэр гаргах асуудал дээр найруулгын өөрчлөлт оруулж өгөөч ээ гэсэн хүсэлт ди парламентаар дамжуулж тавьсан байсан.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор 10 дугаар санал хураалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгчихвөл бид энэ 5.2.1 дээр энэ халдварт болон халдварт бус өвчнийг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны судалгаа нотолгоонд тулгуурлан шийдвэр гаргах үйл ажиллагааг явуулах гээд ингээд оруулчихвал болохоор байна.

Тэгэхээр энэ дээр гүйцээн боловсруулах чиглэл өгөхгүй юу гэж хүсэх гэсэн юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Чинбүрэн гишүүний гаргасан саналаар гүйцээн боловсруулах чиглэлийг 10 дугаар зүйлийн гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

Санал хураалтыг үргэлжлүүлье.

11.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалтын “өвчлөл,” гэсний дараа “осол, гэмтэл,” гэж нэмж, мөн заалтын дугаарыг “5.4” гэж, 5.2.8 дахь заалтын дугаарыг “5.9” гэж, мөн заалтын “байгалийн гамшиг, нийтийг хамарсан ноцтой байдлын үед” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед” гэж, “бэлэн байдлыг хангах;” гэснийг “бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаа явуулна.” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

65.8 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалтын “дэмжих,” гэсний дараа “хамгаалах” гэж нэмж, мөн заалтын “эрүүл мэндийн боловсрол олгох” гэснийг 5.10.3 дахь заалт болгон өөрчилж, 5.3.4 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

64.1 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмэх:

“5.11.Энэ хуулийн 5.10.3-т заасан чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх асуудлыг Монгол Улсын хөгжлийн бодлогод тусгана.

5.12.Энэ хуулийн 5.11-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах, эрх бүхий этгээдэд танилцуулахтай холбогдсон харилцааг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу зохицуулна Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 6 дугаар зүйлийн гарчиг, 6.1-6.5, 6.10-6.12 дахь хэсгийг тус тус хасаж, 6.6 дахь хэсгийг 6 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл

6.1.Нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг хэлэлцэж, салбар дундын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах чиг үүрэг бүхий Нийгмийн эрүүл мэндийн орон тооны бус үндэсний зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ Ерөнхий сайдын дэргэд ажиллана.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөлийн шийдвэр нь дүгнэлт, зөвлөмж хэлбэртэй байх бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газар батална.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

59.0 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсгийг 7 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

7.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.Нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сангийн ажиллах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;

7.1.2.нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдлын

удирдлагын тогтолцоогоор ажиллах журмыг гамшигийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

51.3 хувиар санал дэмжигдлээ.

16.Төслийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийг 8 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагуудын чиг үүрэг

8.1.Төрийн захиргааны төв байгууллагууд нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1.1.хүн амын эрүүл мэндийг дэмжих, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бодлого, үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх;

8.1.2.энэ хуулийн 14.1.3-т заасан чиг үүрэг;

8.1.3.Зөвлөлийн гаргасан дүгнэлт, зөвлөмжийг бодлого, шийдвэртээ тусгаж, хэрэгжүүлэх.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан арга хэмжээний биелэлтийн тайланг жил бүрийн хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 6 дугаар зүйлийн 6.8.3 дахь заалтын “нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед” гэсний өмнө “шуурхай удирдлагын нэгжтэй байх бөгөөд” гэж нэмж, мөн заалтын дугаарыг “12.1.7” гэж өөрчилж, 6.8 дахь

хэсгийг 9 дүгээр зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.8.1-6.8.2 дахь заалтын дугаарыг “9.1.1-9.1.2” гэж, 6.8.4 дэх заалтын дугаарыг “9.1.3” гэж тус тус өөрчлөх:

“9 дүгээр зүйл.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг,

9.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар дараах чиг, үүргийг хэрэгжүүлнэ:” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

59.0 хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:

“9.1.4.нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдлын удирдлагын тогтолцоонд шилжин ажиллаж байгаа байгууллагыг арга зүйгээр хангаж ажиллах;

9.1.5.Энэ хуулийн 8.2-т заасан тайланг нэгтгэн Зөвлөлд жил бүрийн дөрөвдүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

59.0 хувиар санал дэмжигдлээ.

19.Төслийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсгийг 10 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.13.1-6.13.4 дэх заалтын дугаарыг “10.1.1-10.1.4” гэж өөрчлөх:

“10 дугаар зүйл.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

10.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

20.Төслийн 6 дугаар зүйлийн 6.13.2 дахь заалтын “иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар” гэснийг “шаардлагатай санхүүжилтийг эрх бүхий байгууллагаар” гэж, 6.13.3 дахь заалтын “нөхцөлийг бүрдүүлэх” гэснийг “нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх” гэж тус тус өөрчилж, 6.13.4 дэх заалтын “урьдчилан сэргийлэх” гэсний дараа “, эрүүл мэндийн боловсрол олгох” гэж, мөн заалтын “оролцуулах” гэсний дараа “, урамшуулах” гэж, мөн хэсэгт доор дурдсан агуулгатай заалт тус тус нэмэх:

“10.1.5.нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, эрүүл мэндийн боловсрол олгох асуудлаар эрүүл мэндийн байгууллага, ажилтныг дэмжиж ажиллах.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

21.Төслийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д заасныг үндэслэн” гэснийг, “эрх зүйн байдал,” гэснийг тус тус хасаж, мөн хэсгийн дугаарыг “11.2” гэж өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

56.4 хувиар санал дэмжигдлээ.

22.Төслийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийн “7.1.2, 7.1.3-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын” гэснийг “11.1.2-т заасан байгууллагын” гэж, “батална” гэснийг “баталж, удирдлагыг Эрүүл мэндийн тухай хуулийн 12.2-т заасны дагуу аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга томилж, чөлөөлнө” гэж тус тус өөрчилж, “дүрмийг” гэсний дараа “хүн амын төвлөрөл, газар нутгийн байршлыг харгалзан” гэж нэмж, мөн хэсгийн дугаарыг “11.3” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

60.5 хувиар санал дэмжигдлээ.

23.Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг 11.4 дэх хэсэг болгон, мөн хэсгийн “15.1.4, 15.1.7, 15.1.11-15.1.13-т” гэснийг “15.1.3, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.11, 15.1.12, 15.1.13-т” гэж, “нийгмийн эрүүл мэндийн” гэснийг “энэ хуулийн 11.1.3-т заасан” гэж тус тус өөрчилж, “Хувийн хэвилийн эрүүл мэндийн байгууллагад нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан ажилтныг ажиллуулж болно.” гэснийг хасаж, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг 11.10 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.10.Хувийн хэвилийн эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, боловсролын сургалтын байгууллагад нийгмийн эрүүл мэндийн нэгж, алба, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнийг ажиллуулж болно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

57.9 хувиар санал дэмжигдлээ.

24.Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“11.5.Энэ хуулийн 11.1.3-т заасан байгууллагын иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэргүүлэх чиглэл нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ байна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

25.Төслийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийг 11.6 дахь хэсэг болгон “ажилтныг ажиллуулж болно” гэснийг “мэргэжилтэн ажиллуулна” гэж, 8.9 дэх хэсгийг 11.7 дахь хэсэг болгон мөн хэсгийн “7.1.1-7.1.5-д” гэснийг “7.1.1-7.1.4-т” гэж, “хоол зүйчид нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлнэ” гэснийг “хоол зүйч нарыг мэргэжил, арга зүйгээр хангана” гэж тус тус өөрчилж, мөн хэсэгт доор дурдсан агуулгатай 11.8, 11.9 дэх хэсэг нэмэх:

“11.8.Энэ хуулийн 11.1.1, 11.1.2-т заасан байгууллага нь энэ хуулийн 11.1.4-т заасан нэгж, албыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана.”

11.9.Энэ хуулийн 5.10.1, 5.10.2, 5.10.3, 5.10.4-т заасан тусламж үйлчилгээг хувийн хэвшлийн, төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

60.5 хувиар санал дэмжигдлээ.

26.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “бодлого стратеги” гэснийг “хөгжлийн бодлого, чиглэл” гэж өөрчилж, “мэргэжил, удирдлага, арга зүйгээр хангах” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“12.1.2.энэ хуулийн 11.1.2, 11.1.3, 11.1.4, 11.1.5-д заасан байгууллага, нэгж,

алба, нийгмийн эрүүл мэндийн ажилтныг мэргэжил, арга зүйгээр хангах;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

57.9 хувиар санал дэмжигдлээ.

27.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын “өвчний хяналт, сэргийлэлтийн” гэснийг “энэ хуулийн 5.2-5.9-д заасан” гэж, “удирдан зохион байгуулах” гэснийг “зохион байгуулах, хянах, мэдээлэх, холбогдох байгууллагад санал, зөвлөмж өгөх” гэж тус тус өөрчилж, 8.1.3 дахь заалтыг, 8.1.4 дэх заалтын “хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох,” гэснийг, мөн заалтын “, сургагч багш бэлтгэх, мэргэжил арга зүйгээр хангах” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

60.5 хувиар санал дэмжигдлээ.

28.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, холбогдох байгууллагад санал, зөвлөмж өгөх” гэснийг “үндэсний хэмжээний судалгаа хийх, зохион байгуулах, санал, зөвлөмж гаргах” гэж, 8.1.6 дахь заалтын “чиглэлээр үндэсний хэмжээнд лавлагаа лабораторийн үүрэг гүйцэтгэх” гэснийг “үндэсний хэмжээний лавлагаа лабораторитай байх” гэж, 8.1.7 дахь заалтын “урьдчилан сэргийлэх тарилга, био бэлдмэлийг” гэснийг “бүтээгдэхүүнийг” гэж, 8.1.8 дахь заалтын “чиглэлээр ажиллаж байгаа ажилтныг сургах, чадавхжуулах” гэснийг “ажилтныг чадавхжуулах, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах” гэж, 8.1.9 дэх заалтын “мэдээллийн санг цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг үндэсний түвшинд хэрэгжүүлэх” гэснийг “мэдээ, мэдээллийг цуглуулах, нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх, үндсэн үзүүлэлтүүдийг тооцох, эмхэтгэн түгээх,

эргэн мэдээлэх” гэж тус тус өөрчлөх.
Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.3 хувиар санал дэмжигдлээ.

29.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.1,
8.4.1 дэх заалтыг тус тус хасах. Санал
гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

60.5 хувиар санал дэмжигдлээ.

30.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.2
дахь заалтын “бодлого, хөтөлбөрийг
хэрэгжүүлэх чиглэлээр” гэснийг
“хөгжлийн бодлого, чиглэл, төлөвлөгөөг
хэрэгжүүлэх асуудлаар” гэж, 8.2.7 дахь
заалтын “аюулгүй байдал алдагдахаас”
гэснийг “аюулгүй байдал, шим тэжээлийн
зохистой байдал алдагдсанаас
шалтгаалсан өвчлөл, хордлогоос” гэж
тус тус өөрчилж, 8.2.3 дахь заалтыг доор
дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.2.2.хүн амын эрүүл мэндэд
нөлөөлөх орчны хүчин зүйлийг тогтоох,
тандалт, судалгаа хийх, урьдчилан
сэргийлэх, хянах, холбогдох арга хэмжээг
нутаг дэвсгэрийн хэмжээнд төлөвлөн
зохион байгуулах;” Санал гаргасан ажлын
хэсэг.

Санал хураалт.

63.2 хувиар санал дэмжигдлээ.

31.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.4
дэх заалтын “нийгмийн эрүүл мэндийн
ноцтой байдлын” гэсний өмнө “шуурхай
удирдлагын нэгжтэй байх бөгөөд” гэж
нэмж, 8.2.5 дахь заалтын “зонхилон
тохиолдох” гэснийг, мөн заалтын “, эрүүл
мэндийг дэмжих, хамгаалах, мэдээлэх,
хянах” гэснийг, 8.2.8 дахь заалтын
“өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх,”
гэснийг, мөн заалтын “, эрүүл зан үйлийг
төлөвшүүлэх” гэснийг, 8.2.6 дахь заалтыг

тус тус хасах. Санал гаргасан ажлын
хэсэг.

Санал хураалт.

57.9 хувиар санал дэмжигдлээ.

32.Төслийн 8 дугаар зүйлд доор
дурдсан агуулгатай заалт нэмэх:

“12.2.7.сэтгэцийн эрүүл
мэндэд нөлөөлөх нийгэм, орчны сөрөг
хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх арга
хэмжээ авах;

12.2.8.нөхөн үржихүйн
эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн
удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлэх,
хяналт, үнэлгээ хийх;

12.2.9.нийгмийн эрүүл
мэндийн лабораторийн үйл ажиллагаа
эрхлэх.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

63.2 хувиар санал дэмжигдлээ.

33.Төслийн 8 дугаар зүйлийн 8.4.2
дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн
найруулж, 8.4.3 дахь заалтын “халдварт
болон халдварт бус зонхилон тохиолдох
өвчний” гэснийг, 8.4.4 дэх заалтыг тус
тус хасах:

“12.3.1.дархлаажуулалтыг
зохион байгуулж, хэрэгжүүлэх;

12.3.2.өвчин эмгэгээс
урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн
боловсрол олгох үйл ажиллагаа зохион
байгуулах;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

63.2 хувиар санал дэмжигдлээ.

34.Төслийн 8 дугаар зүйлийн 8.4.6
дахь заалтын “хүний эрүүл мэндэд”
гэснийг “харьяа нутаг дэвсгэрийн хүн
амын эрүүл мэндэд” гэж, “зан үйл,

эрсдэлт хүчин зүйлийг тандах, судлах,” гэснийг “эрсдэлт хүчин зүйлийг тогтоох, тандалт, судалгаа хийх,” гэж өөрчилж, 8.8 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

51.4 хувиар санал дэмжигдлээ.

35.Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“12.4. Энэ хуулийн 11.1.4-т заасан нэгж, алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.4.1.тухайн эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтанд нийгмийн эрүүл мэндийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

12.4.2.тухайн эрүүл мэндийн байгууллагын төрөлжсөн чиглэлээр тандалт, судалгаа хийх;

12.4.3.тухайн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

59.5 хувиар санал дэмжигдлээ.

36.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.2.1 дэх заалтыг, 9.1.3 дахь заалтын “халдварт болон халдварт бус зонхилон тохиолдох өвчин, түүний эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх,” гэснийг тус тус хасаж, 9.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.3.нийгмийн эрүүл мэндийн асуудлаар холбогдох мэргэжлийн байгууллага, албан тушаалтанд хандах;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

62.2 хувиар санал дэмжигдлээ.

37.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“13.2.2.гэр бүл, хамт олны дунд эрүүл зан үйл, амьдралын зөв дадал хэвшлийг бий болгоход нөлөөлөх;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

64.9 хувиар санал дэмжигдлээ.

38.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “тархвар судлалд” гэснийг “тандалт, судалгаа, тархвар судлалын асуумжид” гэж, 9.2.6 дахь заалтын “нөлөөллийн талаар нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад мэдээлэх” гэснийг “нөлөөлөл, сэжигтэй тохиолдлын талаарх мэдээллийг холбогдох байгууллагад мэдэгдэх” гэж тус тус өөрчилж, 9.2.2 дахь заалтын “, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх дадал хандлагатай байх” гэснийг, 9.2.5 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

56.8 хувиар санал дэмжигдлээ.

39.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “зөвлөгөө” гэсний дараа “, мэдээлэл” гэж нэмж, мөн заалтын “хамгаалах чиглэлээр мэргэжлийн байгууллагатай” гэснийг “дэмжих чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай” гэж өөрчилж, 10.1.3, 10.1.5, 10.1.7 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

62,2 хувиар санал дэмжигдлээ.

40.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтын “орчин бүрдүүлэх” гэсний дараа “асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусган, хэрэгжүүлэх” гэж, мөн хэсэгт доор дурдсан агуулгатай заалт тус тус нэмэх:

“14.1.5.байгууллагын үйл ажиллагааны чиглэл, нутаг дэвсгэрийн онцлогт уялдуулан ажилтныг дархлаажуулалтад хамруулах арга хэмжээ авах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

64.9 хувиар санал дэмжигдлээ.

41.Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Олон нийтийн оролцоо

15.1.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нээлттэй ил тод байх бөгөөд түүнд олон нийтийн оролцоог хангах, хяналт тавих боломжийг бүрдүүлсэн байна.

15.2.Энэ хуулийн 11.1.1-11.1.4-т заасан байгууллага нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ олон нийтийн оролцоог дараах байдлаар хангана:

15.2.1.байнгын ажиллагаатай цахим хуудсаар дамжуулан мэдээлэл хүргэх, санал авах;

15.2.2.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын сайн дурын оролцоог хангах, урамшуулах.

15.3.Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд олон нийтийн оролцоог хангах, сайн дурын ажилтныг урамшуулах журмыг эрүүл мэндийн

асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

67.6 хувиар санал дэмжигдлээ.

42.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.3 дахь хэсгийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

16.1.Хэвлэл мэдээллийн байгууллага нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар иргэд, олон нийтэд үнэн зөв, бодит мэдээлэл хүргэнэ.

16.2.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд үнэ төлбөргүй түгээнэ. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

64.9 хувиар санал дэмжигдлээ.

43.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 13.1.3 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.1.1.Эрүүл мэндийн тухай хуулийн 28.1.1, 28.1.4, 28.1.5-д заасан эрх;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

64.9 хувиар санал дэмжигдлээ.

44.Төслийн 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь заалтын “эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах,” гэснийг хасаж, мөн заалтын “дэмжлэг үзүүлэх” гэсний дараа “; мэргэжлийн асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгжид зааварчилгаа, зөвлөгөө өгөх” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“17.2.5.хүн амын эрүүл мэндэд аюул бүхий өвчин, хордлого, орчны сөрөг нөлөөллийн талаар холбогдох байгууллагад мэдээлэх.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

64.9 хувиар санал дэмжигдлээ.

45.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “ажилтан” гэсний дараа “энэ хууль болон” гэж нэмж, 14.2 дахь хэсгийн “нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллага” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “гэмт хэргийн шинжгүй” гэснийг “хуульд өөрөөр заагаагүй” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

59.5 хувиар санал дэмжигдлээ.

46.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15.4 дэх хэсгийг хасах:

“19.1.Энэ хуулийн 19.2-т зааснаас бусад нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

19.2.Холбогдох хуульд заасны дагуу нийгмийн эрүүл мэндийн зарим тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын болон Эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлэх бөгөөд хандив, тусламж, дэмжлэг, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

67.6 хувиар санал дэмжигдлээ.

47.Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмж, 15.5 дахь хэсгийн “тусламж, үйлчилгээний” гэсний дараа “төрөл” гэж нэмэх:

“19.4.Нийгмийн эрүүл мэндийн байгууллагын зарим тусламж үйлчилгээг төлбөртэй үзүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

67.6 хувиар санал дэмжигдлээ.

48.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Иргэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, хуулийн этгээд нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааны талаар, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед” гэснийг “Нийгмийн эрүүл мэндийн асуудлаар” гэж өөрчилж, 16.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

62.2 хувиар санал дэмжигдлээ.

49.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.Энэ хуулийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Чинбүрэн гишүүн үг хэлье.

Ж.Чинбүрэн: Энэ ажлын хэсэг дээр би санал гаргасан юм. Энэ хуулийн хэрэгжих хугацааг 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс гээд байгаа юм. Тэгэхээр бас их л тулгамдаад байгаа. Би бас энэ дээр бас сайдаас ч гэсэн асууж байсан. Ажлын хэсгийн даргаас асууж байсан. Тэгэхээр үүнийг түрүүн Одонтуяа гишүүн ч гэсэн бас хэллээ. 7 сарын 1-нээрээ байвал яасан юм гээд. Тэгэхээр энэ дээр гүйцээн боловсруулах

чиглэл аваад бид ажлын хэсэг дээр нэг дахин ярилцах боломж олгооч.

Л.Мөнхбаатар: Эрүүл мэндийн сайд Чинзориг үг хэлье.

С.Чинзориг: Тийм. Байнгын хороон дээр Чинбүрэн гишүүн бас ярьсан юм. Тэгээд бид нар ярьж байгаа. Ер нь 4 сарын 1-нээс хэрэгжүүлбэ. Энэ хуулийг хэрэгжүүлэхэд бэлтгэл хангаад нэг их цаг алдаад байх юм бол гайгүй. Тэр бүтэц тогтолцоотой холбоотой юмнууд орон нутагт ажиллаж байгаа эрүүл мэндийн газруудад жоохон өөрчлөлт орно. Дээр нь тэр өвчний хяналт сэргийлэлтийн төв байгуулах асуудал шинээр бас агентлаг байгуулах юм байхгүй. Одоо байгаа бүтцээ л боловсронгуй болгох замаар нь ингээд аваад явчих юм.

Тийм учраас 4 сарын нэгнээсээ байвал зүгээр байгаа юм.

Хоёр дахь асуудал нь яах вэ хууль бас Их Хурал дээр хэлэлцэгдэж байгаа учраас бас Засгийн газар дээрээ, Сангийн яамтай яриад эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлыг, санхүүжилттэй холбоотой асуудал дээр 50 орчим тэрбум төгрөг, иргэний эрүүл мэндийн боловсролын асуудлыг дэмжихтэй холбоотой 5 орчим тэрбум төгрөг гээд ингээд санхүүжилттэй холбоотой асуудал ирэх оны төсөв дээр бас боломжоор тусчихсан юм.

Тийм учраас би 4 сарын 1-сээ байх нь зүйтэй гэсэн саналтай байгаа юм.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн санал бол 2024 оны 4 сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэсэн ийм санал байна. Үүнийг энэ хуулийг хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий Засгийн газрын гишүүн 4 сарын 1-нээс амжина гэж байгаа учраас үүгээрээ нь явчихъя гэж бодож байна. Санал хураалтын томъёоллыг уншиж танилцуулсан.

Санал хураалт гишүүд ээ.

56.8 хувиар санал дэмжигдлээ.

50.Төсөлд зүйл, хэсэг, заалт нэмэх, хасах саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.3 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал:

1.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын “урьдчилан сэргийлэх” гэсний дараа, 5.2.3 дахь заалтын “хадгалах” гэсний дараа, 5.2.7 дахь заалтын “тандах” гэсний дараа “үйл ажиллагаа явуулна.” гэж, 6 дугаар зүйлийн 6.13.3 дахь заалтын “нутаг дэвсгэрийн” гэсний өмнө “харьяа” гэж, 8 дугаар зүйлийн 8.2.4, 8.4.5 дахь заалтын “ноцтой байдлын” гэсний дараа “үеийн” гэж, “арга хэмжээг” гэсний дараа “авч” гэж, 8.2.8 дахь заалтын “эрүүл мэндийн” гэсний өмнө “хүн амд” гэж, 8.9 дэх хэсгийн “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “батална” гэсний өмнө “хамтран” гэж тус тус нэмэх;

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “эрүүл мэндийн байдал” гэснийг “эрүүл мэнд” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтын “нөлөөлөх” гэснийг “үзүүлэх” гэж, “хариу арга хэмжээг” гэснийг “холбогдох арга хэмжээ” гэж, 3.1.7 дахь заалтын “тодорхойлж” гэснийг “тогтоож” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “олон хувилбартай байх” гэснийг “хэлбэр үл харгалзах” гэж, 4.1.4 дэх заалтын “хуулийн этгээдийн” гэснийг “аж ахуйн нэгж, байгууллагын” гэж, 4.1.7 дахь заалтыг “олон нийтийн, сайн дурын

ажилтны оролцоог хангах” гэж, 5 дугаар зүйлийн 5.2.2, 5.2.3, 5.2.7, 5.2.8 дахь заалтын “төрөлд” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд” гэж, 5.2.2 дахь заалтын “өвчлөл” гэснийг “өвчин эмгэг” гэж, 5.3.1 дэх заалтын “тандалт, судалгаа” гэснийг “тандах, судлах” гэж, 5.3.5 дахь заалтын “түнишлэл, хамтын ажиллагаа” гэснийг “оролцоо, хамтын ажиллагааг хангах” гэж, 6 дугаар зүйлийн 6.8.2 дахь заалтын “бодлого, хөгжлийн чиг хандлага,” гэснийг “хөгжлийн бодлого, чиглэлийг болон” гэж, “тодорхойлох” гэснийг “тодорхойлж, хэрэгжүүлэх” гэж, 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.4 дэх хэсгийн “эрх үүргийг” гэснийг “чиг үүргийг” гэж, 8.2.7 дахь заалтын “тодорхойлох” гэснийг “тогтоох” гэж, 8.4.3 дахь заалтын “зохион байгуулах” гэснийг “зохион байгуулж, хэрэгжүүлэх” гэж, 8.4.5 дахь заалтын “бэлэн байдал” гэснийг “бэлэн байдлыг хангах” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтын “хуулийн” гэснийг “хууль тогтоомжийн” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалтын “боломж бүрдүүлэх” гэснийг “боломжоор хангах” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “эрхтэй” гэснийг “эрх эдэлнэ” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “ажилтанд урамшуулал олгох” гэснийг “ажилтныг урамшуулах” гэж, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “ангилал,” гэснийг “ангилаар болон” гэж тус тус өөрчлөх;

3.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “хууль эрх зүйн” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалтын “хөдөлмөр эрхлэгч” гэснийг, 5.2.7 дахь заалтын “судлах,” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.1.4, 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь заалтын “амьдрах” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.13.4, 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “нийгмийн” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтын “, мэдлэг” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалтын “энэ хуулийн 3.1.11-д заасан” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь

хэсгийн “арга болон” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураая.

Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал байна.

Нэг.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явууля.

Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмж, 1 дүгээр зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх:

“1 дүгээр зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.26 дахь заалт нэмсүгэй:

“3.1.26.“нийгмийн эрүүл мэндийн ажилтан” гэж Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 3.1.17-д заасан мэргэжилтнийг.”” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Санал дэмжигдсэнгүй.

Гонгорын Дамдинням гишүүн горимын санал гаргая.

Г.Дамдинням: Энэ Чинзориг сайд гишүүдэд бас бүрэн ойлгуулахгүй бол их л бярдаж явж байна даа. Яах вэ одоо явууля даа. Сая би дарсан юм тэгээд орсонгүй. Саяын санал хураалтыг

цуцлаад, дахин санал хураалт явуулж өгөхийг хүсье.

Л.Мөнхбаатар: Гонгорын Дамдинням гишүүний саналаар энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

Санал хураалт.

60.5 хувиар санал дэмжигдлээ.

Үндсэн саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа.

Санал хураалт.

57.9 хувиар санал дэмжигдлээ.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн “29.5 дахь” гэсний өмнө “29.2 дахь хэсгийн “эмнэлгийн мэргээжилтэн,” гэсний дараа “нийгмийн эрүүл мэндийн ажилтан,” гэж” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

60.5 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “24 дүгээр зүйлийн 24.6.4 дэх хэсэгт “нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа, арга хэмжээ болон гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлтийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, гамшигийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;” гэж” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“3 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“24.6.4.хуульд өөрөөр заагаагүй бол нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, гамшигийн үеийн

эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

63.2 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийн “эрүүл мэндийн тухай хууль тогтоомж” гэснийг “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай” гэж өөрчилж, мөн зүйлийн “тус тус өөрчилсүгэй” гэсний өмнө “35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсгийн “энэ хууль” гэснийг “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

63.2 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 3 дугаар зүйлийн “13 дугаар” гэсний өмнө “7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

60.5 хувиар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд шинэ зүйл нэмсэнтэй нийцүүлэн төслийн дугаарлалтыг өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

Боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналаар санал хураалт явуулъя.

Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “6.29 дэх хэсгийг” гэснийг “6.31 дэх зүйл” гэж өөрчлөх.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Энэ хууль асуудлаа мэдээж зохицуулах байх гэж найдаж байгаа юм. Өнөөдөр бодит байдал чинь асуудал чинь сайн явахгүй байна шүү дээ. Нөгөө гүйцэтгэлээр санхүүжих юм чинь явахгүй байна. Өнөөдрийн байдлаар манай Ховд аймгийн бүсийн оношилгооны төвийн 3.9 тэрбум, 4 тэрбум төгрөгийн өртэй байна. Дулаан, нийгмийн даатгалын шимтгэл, цалин хөлс өгөхгүй. Ингээд энэнээсээ өртэй. Тэгэнгүүт юунаас болоод ингэж байна вэ гэхээр гүйцэтгэлийнхээ санхүүжилтийг өгөхгүй. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нийтдээ 4.1 тэрбум төгрөг өгчих юм бол энэ өрнүүдээ бүгдийг төлөөд, өнөөдөр дулаан юмыг хаана гээд байна шүү дээ.

Энэ асуудлыг яаж шийдвэрлэх юм бэ. Тэгээд энэ асуулт асуух горим байхгүй. Тэгэхдээ та дараагийнх дээр нь энэ асуудлаар хариулт өгөөч үг аваад. Аймгуудын бүх эмнэлгүүд чинь бүгдээрээ ингээд өр төлбөртэй ингээд байгаад байна.

Өөрөөсөө өр авлагаа барагдуулахгүй бол хүмүүсийн цалин тэгэхэд 750 сая төгрөг өгөх ёстой. Тэр хүмүүс цалингүй өнөөдөр ингээд ажиллаад байж байна шүү дээ. Иймэрхүү юмаа шийдээгүй байж дахиад л шинэ хууль оруулж ирдэг. Дахиад шинэ хууль нь амжилттай болох уу, болохгүй юу гэж зөндөө асуудлууд гараад байна. Энэ дээр дараагийн санал дээр Чинзориг сайд бусад бүх юу байдаг юм аймгийн эрүүл мэндийн төв энэ дээр хариултыг нь өгөөдхөөч.

Л.Мөнхбаатар: Пүрэвдорж гишүүний ярьж байгаа энэ асуудал бол бүх аймагт адилхан байх. Дүрэг дээр ч гэсэн адилхан байгаад байгаа тийм ээ. Содномын Чинзориг гишүүн үг хэлэх үү. Асуултад хариулт бол байхгүй. Үг хэлэх дэгтэй. Содномын Чинзориг гишүүн үг хэлье.

С.Чинзориг: Эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлийн санхүүжилтээр санхүүжилт авч байгаа. Ялангуяа өрхийн эмнэлэг анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад бол бид нар 80 хувийг нь урьдчилж өгөөд урьдчилгаа өгөөд 20 хувийг нь 9 шалгуур үзүүлэлтээр дүгнэж санхүүжилт өгдөг.

Нэгдсэн эмнэлгүүд дээр бол гарсан гүйцэтгэлээр нь санхүүжилт өгдөг ийм журам бол хэрэгжиж байгаа. Гэхдээ асуудал бол байх нь байгаа. Бид нар өчигдөр Сангийн яамтай гүйцэтгэлийн санхүүжилтийн нэхэмжлэлээр нь санхүүжилт олгох асуудал ялангуяа ондоо багтаагаад цалин урамшууллын асуудлыг нь бүрэн шийдэх энэ тэр гээд ингээд санхүүжилттэй холбоотой асуудал ярьсан гээд. Өнөө маргаашдаа ирэх 7 хоногийн 3 дахь өдөр гэхэд бол санхүүжилтийн асуудал бол нэлээд нааштайгаар шийдээд явах болов уу гэж бодож байна.

Тэгэхдээ бас асуудал бол 2 талтай асуудлууд байгаа юм.

Даатгалын сангаас санхүүжилт олгогдож байгаа учраас бол эрүүл мэндийн байгууллагууд өөрсдөө менежментээ одоо зөв хийх, эхний ээлжид ямар зардлын зүйл ангийг санхүүжүүлэх вэ гэдгээ нэлээд бас менежмент хийх асуудлууд байх. Ний нуугүй хэлэхэд бол манайхан эмийн өр үүсгэчихээд, цалингийн өр үүсгэчихээд өөрсдөө бас өөр худалдан авалт юм хийгээд ингээд өр үүсгээд байгаа асуудлууд ч бий. Тийм учраас бол цаашидаа энэ эрүүл мэндийн байгууллагууд

даатгалын санхүүжилтээс дутуу санхүүжилт өгөөд байна гээд ярихаасаа урьдаар өөрсдөө менежментээ маш сайн хийх, зардлынхаа зүйл ангийг ямар зардлыг эхэлж санхүүжүүлэх юм. Яаж одоо зардал бас хэмнэх вэ гэдэг асуудлыг менежмент сайжруулах асуудлууд нэлээд анхаарах юм байгаа гэдгийг бас хэлье.

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Саналын томъёоллыг уншиж танилцуулсан.

Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “6.8 дугаар зүйлийн “6.28 дугаар зүйлийн 5 дахь хэсэг” гэсний дараа “6.29 дүгээр зүйл,”” гэснийг “1.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтын “7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг,” гэсний өмнө “6.31 дүгээр зүйл,”” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалтыг явуулъя.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “нийтийг хамарсан халдварт өвчний” гэснийг хасаж, “нийгмийн эрүүл мэндийн” гэсний өмнө “дэгдэлт,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

61 санал хураалт явагдлаа.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлээ.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА